



# ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

- Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, шинэлэг зохицуулалт
- Монголын хууль тогтоомжийн шинэтгэлийн түүхийн асуудалд
- БНХАУ-ын "нэг улс-хоёр систем" дэх эрх зүйн онцлог асуудал
- Хил дамнаж хэрэглэгчтэй байгуулсан цахим хэлбэр бүхий гэрээний маргаанд шүүхийн харьяаллыг нэгдмэл байдлаар тогтоох боломж
- Хүч хэрэглэсэн гэмт явдлын төрөл
- Иргэний хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон улсын тэмдэгтийн хураамж
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн байдал
- Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Япон Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийг үндсэн хуулийн эрх зүйн үүднээс харьцуулах нь
- Цахим худалдааны загвар хууль батлах болсон шалтгаан, нөхцөл
- БНХАУ-ын Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн талаар
- Гадаад орнуудын жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалт
- Хууль, шүүхийн байгууллагын залуу мэргэжилтнүүдээс авсан асуулга судалгааны зарим дүн

**СЭТГҮҮЛИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ**

|                |                                                                               |
|----------------|-------------------------------------------------------------------------------|
| Ц.Нямдорж      | - Хууль зүй, дотоод хэргийн сайд                                              |
| Ц.Зориг        | - Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч                                            |
| Д.Дорлигжав    | - Улсын Ерөнхий прокурор                                                      |
| Д.Олбаяр       | - Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга                            |
| Д.Луидэвжянцан | - Улсын Их Хурлын гишүүн                                                      |
| Ц.Мөнх-Оргил   | - Улсын Их Хурлын гишүүн                                                      |
| С.Батдэлгэр    | - Улсын Дээд шүүхийн шүүгч                                                    |
| Ц.Шаравдорж    | - Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга                  |
| П.Цагаан       | - Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх                         |
| Б.Долгор       | - Монгол Улсын Ерөнхий сайдын хуулийн зөвлөх                                  |
| Ж.Бямбадорж    | - Хүний эрхийн үндэсний комиссын дарга                                        |
| Г.Баясгалан    | - ХЭДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга                                        |
| Б.Пүрэвийм     | - Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч                                 |
| Ч.Отгонбаяр    | - Монголын Нотариатчдын Танхимын Ерөнхийлөгч                                  |
| Д.Батжаргал    | - Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал                                    |
| Ж.Амарсанаа    | - Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал |
| С.Нарангэрэл   | - МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга                      |
| Д.Сандаг-Очир  | - Цагдаагийн ерөнхий газрын дарга                                             |
| Д.Зүмбэрэлхам  | - Төрийн албаны зөвлөлийн дарга                                               |
| Д.Солонго      | - МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал                                      |
| Б.Болдбаатар   | - Дотоод хэргийн их сургуулийн захирал                                        |

**СЭТГҮҮЛИЙН ШИНЖЭЭЧ ЭРДЭМТДИЙН ЗӨВЛӨЛ**

|              |                                               |
|--------------|-----------------------------------------------|
| С.Жанцан     | - Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)     |
| Ч.Энхбаатар  | - Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)     |
| Ш.Чоймаа     | - Хэл шинжлэлийн шинжлэх ухааны доктор (Sc.D) |
| Б.Амарсанаа  | - Хууль зүйн доктор (LL.D)                    |
| Б.Гүнбилэг   | - Хууль зүйн доктор (Ph.D)                    |
| Б.Тэмүүлэн   | - Хууль зүйн доктор (Ph.D)                    |
| Г.Банзрагч   | - Хууль зүйн доктор (Ph.D)                    |
| Д.Баярсайхан | - Хууль зүйн доктор (Ph.D)                    |
| Т.Мэндсайхан | - Хууль зүйн доктор (Ph.D)                    |

**ХЯНАН ТОХИОЛДУУЛАХ ЗӨВЛӨЛ**

Хүндэт зөвлөх: Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид  
 Ерөнхий эрхлэгч: Д.Батжаргал  
 Эрхлэгч: Б.Гүнбилэг  
 Хариуцагчийн нарийн бичгийн дарга: С.Алтантуяа

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай-7  
 Утас: 312513, 99083007  
 Факс: 315736  
 Вэб сайт: www.legalinstitute.mn  
 И-мэйл хаяг: altantuya.s@legalinstitute.mn

# Хууль дээдлэх ёс

Цуврал 37 2012 он, Дөрөвдүгээр сар №2



Хууль зүйн үндэсний  
хүрээлэн

## АГУУЛГА

## Хуудас

### ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ, АРГА ЗҮЙ

|                                                                                                                                     |           |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, шинэлэг зохицуулалт</b>                                                            | <b>5</b>  |
| <i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор,<br/>хууль зүйн доктор (LL.D) Б.Амарсанаа</i>                                       |           |
| <b>Монголын хууль тогтоомжийн шинэтгэлийн түүхийн асуудалд</b>                                                                      | <b>14</b> |
| <i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрх зүй, төрийн<br/>онол-түүхийн тэнхмийн эрдэм шинжилгээний ажилтан,<br/>докторант Б.Батбаяр</i> |           |
| <b>БНХАУ-ын “нэг улс-хоёр систем” дэх эрх зүйн онцлог асуудал</b>                                                                   | <b>29</b> |
| <i>ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын<br/>эрдэм шинжилгээний ажилтан, магистр (LLM)<br/>Б.Энх-Амгалан</i>                        |           |
| <b>Хил дамнаж хэрэглэгчтэй байгуулсан цахим хэлбэр бүхий гэрээний маргаанд шүүхийн харьяаллыг нэгдмэл байдлаар тогтоох боломж</b>   | <b>35</b> |
| <i>Япон Улсын Кюсюгийн их сургуулийн<br/>Хууль зүйн сургуулийн төгсөгч,<br/>магистр (LLM) Хуо Шч И</i>                              |           |
| <b>Хүч хэрэглэсэн гэмт явдлын төрөл</b>                                                                                             | <b>46</b> |
| <i>Дотоод хэргийн их сургуулийн<br/>эрдэм шинжилгээний ажилтан, докторант Г.Оюунболд</i>                                            |           |
| <b>Иргэний хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон улсын тэмдэгтийн хураамж</b>                                                        | <b>54</b> |
| <i>МУИСийн Хууль зүйн сургуулийн ахлах багш,<br/>докторант Д.Хуяг</i>                                                               |           |

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН

|                                                                                                                                   |    |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн байдал | 64 |
| <i>Хууль зүйн чндэсний хэрэглэнгийн судалгаа</i>                                                                                  |    |

## ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

|                                                                                                                                              |    |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдутаар зүйл, Япон Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүтээр зүйлийг үндсэн хуулийн эрх зүйн үүднээс харьцуулах нь | 85 |
| <i>Улсын Их Хурлын Тамгын газрын референт-судлаач, магистр (LLM) П.Амаржаргал</i>                                                            |    |

|                                                                                                                                          |    |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Цахим худалдааны загвар хууль батлах болсон шалтгаан, нөхцөл ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Халиунаа | 91 |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|

|                                                                   |    |
|-------------------------------------------------------------------|----|
| БНХАУ-ын Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн талаар     | 96 |
| <i>Яайка төслийн мэргэжилтэн, Япон Улсын өмгөөлөгч, Ока Хидео</i> |    |

|                                                                                                                                                                 |     |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Гадаад орнуудын жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалт МУИС-ийн Худалдааны Сургуулийн Бизнесийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, магистр (LLM) О.Чулуунцэцэг | 106 |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|

|                                                                                                                                          |     |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Хууль, шүүхийн байгууллагын залуу мэргэжилтнүүдээс авсан асуулга судалгааны зарим дүн                                                    | 114 |
| <i>Дэлхийн банкны "Хууль зүйн салбарын цйлчилгээг сайжруулах" төслийн сургалтын хөтөлбөрийн зөвлөх, боловсролын доктор (Ph.D) У.Туяа</i> |     |

## ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

|                                                           |     |
|-----------------------------------------------------------|-----|
| Монгол Улсын Үндсэн хуулиуд (Монгол бичгээр)              | 120 |
| Монгол Улсын Үндсэн хуулийн үгсийн чуулган                | 120 |
| Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон                       | 121 |
| Эрх зүйн эх толь бичиг                                    | 122 |
| Хууль зүйн англи-монгол эх толь                           | 122 |
| Jurisprudence-эрх зүй судлал: философи, онол              | 123 |
| Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал | 124 |



## CONTENTS

## PAGE

## ARTICLES

|                                                                                                          |           |
|----------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>Revised Company Law of Mongolia and Its New Rules</b>                                                 | <b>5</b>  |
| <i>Amarsanaa.B, LL.D</i>                                                                                 |           |
| <i>Professor of School of Law,</i>                                                                       |           |
| <i>National University of Mongolia</i>                                                                   |           |
| <b>Historical Issues on Legislation Reform of Mongolia</b>                                               | <b>14</b> |
| <i>Batbayar.B, Ph.D candidate</i>                                                                        |           |
| <i>Researcher of Department of Legal Theory and History,</i>                                             |           |
| <i>School of Law,</i>                                                                                    |           |
| <i>National University of Mongolia</i>                                                                   |           |
| <b>Issues on Legal Features in "One Country Two Systems" in People's Republic of China</b>               | <b>29</b> |
| <i>Enkh-Amgalan.B, LL.M</i>                                                                              |           |
| <i>Researcher of International Law Sector,</i>                                                           |           |
| <i>National Legal Institute</i>                                                                          |           |
| <b>Common Ground of Determining Jurisdiction over Cross-Border Electronic Consumer Contract Disputes</b> | <b>35</b> |
| <i>Huo Shuyi, LL.M</i>                                                                                   |           |
| <i>Graduate of Kyushyu University, Japan</i>                                                             |           |
| <b>Types of the Violent Crimes</b>                                                                       | <b>46</b> |
| <i>Oyunbold.G, Ph.D candidate</i>                                                                        |           |
| <i>Researcher of Research Institute,</i>                                                                 |           |
| <i>University of Internal Affairs</i>                                                                    |           |
| <b>State Stamp Duties in Civil Procedure</b>                                                             | <b>54</b> |
| <i>Huyag.D, Ph.D candidate,</i>                                                                          |           |
| <i>Senior Lecturer of Civil Law Department,</i>                                                          |           |
| <i>School of Law, National University of Mongolia</i>                                                    |           |

## RESEARCH REPORT

|                                                                                         |           |
|-----------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>Analysis on Court Rulings on Mining Exploration and Operational Licenses Dispute</b> | <b>64</b> |
| <i>Research Report by National Legal Institute</i>                                      |           |

## NOTES

|                                                                                                                                    |            |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| <b>Constitutional Comparison of the Section 41 of the Constitution of Japan and the Section 20 of the Constitution of Mongolia</b> | <b>85</b>  |
| <i>Amarjargal.P. LL.M</i>                                                                                                          |            |
| <i>Researcher of the Secretariate of the State Great Hural (Parliament) of Mongolia</i>                                            |            |
| <b>Causes and Conditions to Adopt a Model Law on E-commerce</b>                                                                    | <b>91</b>  |
| <i>Khaliunaa.G.</i>                                                                                                                |            |
| <i>Researcher of International Law Sector,</i>                                                                                     |            |
| <i>National Legal Institute</i>                                                                                                    |            |
| <b>About the Law on ADR in People's Republic of China</b>                                                                          | <b>96</b>  |
| <i>Oka Hideo, LL.M.</i>                                                                                                            |            |
| <i>Advocate in Japan.</i>                                                                                                          |            |
| <i>Specialist of "Jaica" Project</i>                                                                                               |            |
| <b>Legal Regulations on Medium Scale Industry of Foreign Countries</b>                                                             | <b>106</b> |
| <i>Chuluuntsetseg.O., LL.M.</i>                                                                                                    |            |
| <i>Senior Lecturer of Department of Business Law,</i>                                                                              |            |
| <i>School of Business, National University of Mongolia</i>                                                                         |            |
| <b>Some Analysis on Research Questionnaires of Young Lawyers in Justice Sector</b>                                                 | <b>114</b> |
| <i>Tuya.U., Ph.D</i>                                                                                                               |            |
| <i>Legal Educaion Consultant of "Enhanced Justice Sector Services" Project, the World Bank</i>                                     |            |


## NEW LITERATURE

|                                                                               |            |
|-------------------------------------------------------------------------------|------------|
| <b>The Constitutions of Mongolia in Mongol Script</b>                         | <b>120</b> |
| <b>Lexicon of the Constitutions of Mongolia</b>                               | <b>120</b> |
| <b>Pandect of the Constitutions of Mongolia</b>                               | <b>121</b> |
| <b>Dictionary of Law</b>                                                      | <b>122</b> |
| <b>English-Mongolian Legal Dictionary</b>                                     | <b>122</b> |
| <b>Jurisprudence: Philosophy and Theory</b>                                   | <b>123</b> |
| <b>Challenging Issues of Corporate Governance and Company Law in Mongolia</b> | <b>124</b> |

**Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга,  
шинэлэг зохицуулалт**

**МУИС-ийн Хууль зүйн сургуулийн  
Олон улсын эрх зүйн тэнхмийн  
дэд профессор, хууль зүйн доктор  
(LL.D) Б.Амарсанаа**

---



2011 онд батлагдсан Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь нэлээдгүй олон зохицуулалтыг өөрчилжээ. Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухайд зарчмын шинжтэй дөрвөн үндсэн асуудалд өөрчлөлт оржээ. Эдгээр нь компанийн төрөл болон хэлбэр, компани дахь хяналтын тогтолцоо, төрийн зохицуулагч байгууллагын болон шүүхийн оролцоог үндсэнд нь өөрчилсөнд байгаа юм. Үүнээс гадна компанийн санхүүгийн эрх зүйтэй холбоотой нэлээдгүй заалт өөрчлөгдсөнийг дурдах нь зүйтэй.

## **НЭГ. КОМПАНИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР**

Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хувьд компани:

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК),
- Хувьцаат компани (ХК) гэсэн 2 хэлбэртэй.

Хувьцаат компани нь:

А. Нээлттэй хувьцаат компани (Нээлттэй ХК),

Б. Хаалттай хувьцаат компани (Хаалттай ХК) гэсэн төрөлтэй байхаар хуульчилжээ.

Хэлбэр талаас нь харвал ХК-ийг нээлттэй болон хаалттай хэмээн хоёр төрөлтэй болгосон, хязгаарлагдмал хариуцлагатай компани болон

нээлттэй ХК-ийн хувьд өмнөх хуульд байсан ХХК болон ХК-ийн үндсэн шинж нь хэвээр байгаа мэт харагдаж байна.

Үнэн хэрэгтээ Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу үйл ажиллагаа явуулах ХХК нь өмнөх хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах ХХК-тай нэрийн хувьд адил боловч зарчмын хувьд нэлээд өөр хэлбэр болжээ. Ингэж үзэх дараах шалтгаан байна.

1. Аль ч хувьцаа эзэмшигч ямар ч мэдээллийг шаардан авах эрхтэй болсон.<sup>1</sup> Энэ нь ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь мэдээлэл авах туйлын эрхтэй байх мэт маш хатуу зохицуулалтыг бий болгож байгаагаараа өмнөх хуулийн орчноосоо эрс ялгаатай юм.

2. ХХК нь нийтэд санал болгон үнэт цаас гаргах бололцоогүй<sup>2</sup> болсон бөгөөд энэ нь 50-иас дээш этгээдэд нийтэд санал болгох замаар үнэт цаас арилжих боломжгүй болж байгаа юм.<sup>3</sup> ХХК нь өөрийн хувьцаагаа нийтэд санал болгох нь өмнөх хуулийн орчинд ч угаас хаалттай хэлбэр бөгөөд харин өрийн бичгээ ХХК нийтэд санал болгож байсныг<sup>4</sup> шинэ зохицуулалтаар хоригложээ.

3. Захиран зарцуулах эрхийг нь дүрмээс гадна хуулиар хориглох бололцоотой<sup>5</sup> болсон. Ийнхүү захиран зарцуулах эрх нь зөвхөн дүрмээр хязгаарлагддаг харьцангуй уян хатан байдалтай байсныг илүү хязгаарлагдмал, хуульд заасан зарим ХХК-ийн хувьд сонголтгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Эдгээрийн дотроос эхний хоёр шалтгаан нь бизнес эрхлэгч, үүсгэн байгуулагч компани байгуулахдаа ихээхэн анхааралтай хандахад хүргэх магадлал өндөр байна. Ялангуяа мэдээлэл авах эрхийн тухай заалтын үр дагавар нь аль болох харьцааны дотно хүрээнд, цөөн хувьцаа эзэмшигчтэй байх бодит шаардлагад компанийг, бизнес эрхлэгчийг, үүсгэн байгуулагчийг түлхэн оруулж байгаа юм. Гагцхүү үүнийг хэрхэн тайлбарлаж, практик тогтохоос шалтгаалан зарим тохиолдолд компанид сөрөг нөлөө үзүүлэхийг үгүйсгэх боломжгүй юм. Мөн мэдээллийн технологийн гэх мэт мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаа явуулдаг компанид энэ хэлбэрийг сонгоход хүндрэл үүсч болох талтай. Нөгөө талаас Байгууллагын нууцын тухай хууль<sup>6</sup> энэ заалттай хэрхэн уялдах нь ихээхэн ач холбогдолтой. Мөн компанийн дүрэм, бусад баримт бичгээр

<sup>1</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга) - 5.11. Ийн заалт Компанийн тухай хууль (1999) - д байгаагүй.

<sup>2</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга) - 5.2, Компанийн тухай хууль (1999) - 5.2.

<sup>3</sup> Үнэт цаасны заа эзэмшин тухай хууль - 3.1.13.

<sup>4</sup> Ингэцлэг, хэдэн жилийн өмнө Монголын хөрөнгийн биржээр дамжуулан М.Сн-Эс Электроникс ХХК нь өөрийн өрийн бичгийг арилжааж байсан. Мөн шинэчилсэн найруулга батлагдахас өмнө буюу 2011 оны сүүлээр Жаст Агро ХХК нь Монгол нх бондыг нийтэд санал болгон гаргажээ. [http://bdssec.mn/files/text/pdf/Mongol\\_Makh\\_Bond\\_MGL.pdf](http://bdssec.mn/files/text/pdf/Mongol_Makh_Bond_MGL.pdf) (2012.02.14)

<sup>5</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга) - 3.5, Компанийн тухай хууль (1999) - 3.4.2.

<sup>6</sup> Байгууллагын нууцын тухай хууль (1995).

энэ эрхийг хязгаарлаж болох эсэх нь тодорхойгүй байна. Үндсэндээ энэ хэлбэр нь нэг хувьцаа эзэмшигчтэй компани, эсхүл хувьцаа эзэмшигч болон түүний компани нь эрх зүйн хувьд бие даасан байх шинж<sup>7</sup> нь бодит байдалд аль болох саармаг буюу бүдэг байх компанид илүүтэй тохиромжтой байж болох юм.

Тэгвэл 1999 оны Компанийн хуулийн дагуух ХХК юу болсон бэ? Миний үзэж байгаагаар Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ХХК болон хаалттай ХК-д тодорхой хэмжээгээр ХХК-ийн шинжүүд нь шилжсэн, зарим шинж нь хэвээр хадгалагдан үлджээ. Өмнө өгүүлснээр 1999 оны хуулийн дагуу байгуулагдах ХХК-ийн зарим шинж нь өөрчлөгдөж, бусад шинж нь хэвээр байгаа бол хаалттай ХК-ийн хувьд ямар эрх зүйн орчин бий болох гэдэг нь дараах эрх зүйн үр дагавартай юм.

Үүнийг задлан үзэхийн тулд хаалттай болон нээлттэй ХК нь ямар ялгаатай вэ гэдэг асуудал гарч ирнэ.

1. Хаалттай ХК-ийн хувьд хөрөнгийн биржээр хувьцаа нь арилжаалагдахыг хориглосон<sup>8</sup> бол нээлттэй ХК-ийн хувьд эсрэгээр хувьцаа нь хөрөнгийн биржээр арилжаалагдах ёстой, нөгөө талаас хөрөнгийн биржийн шаардлагыг хангасан<sup>9</sup> компанийн хэлбэр юм.<sup>10</sup>

2. Нээлттэй ХК-ийн хувьд хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг бол хаалттай ХК-ийн хувьцаа нь хаалттай хүрээнд<sup>11</sup> буюу нийтэд санал болгохыг хориглодог байна.

Үүгээр хөрөнгийн биржид арилжаалах үнэт цаасны шаардлагыг хангахаа больсон, өмч хувьчлалын үр дагавраар ХК-иас ХХК болгон өөрчлөх хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийг гаргаж чадахгүй байгаа ХК-ийг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахад Компанийн тухай хуулийн хувьд хүндрэл дагуулдаг байсан өмнөх хуулийн орчинг өөрчилсөн. Энэ утгаараа хаалттай ХК нь хувьцаагаа хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах тохиолдолд автоматаар нээлттэй ХК болох боломжийг олгож байна. Энэ нь зардал болон эрх зүйн эрсдлийн хувьд ХХК-иас нээлттэй ХК болон өөрчлөхөд гарах эрсдлийг багасгаж байгаа ач холбогдлыг агуулж буй юм.

<sup>7</sup> Хууль зүйн хувьд компани болон түүний хувьцаа эзэмшигч нь эрх зүйн бие даасан субъект байдаг.

<sup>8</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-3.8.

<sup>9</sup> Зарим улсад хувьцааны төвлөрөл нь 80 хувиас дээш бол хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаагаа арилжаалахыг хориглодог.

<sup>10</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-3.7.

<sup>11</sup> Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг үзвэл зарим нэр томъёо ялгаатай байдалаар хуульчлагдсан байдаг. Жишээлбэл, нийтэд санал болгохгүйгээр хаалттай худалдаа (Үнэт цаасны зах зээлийн тухай хууль-5.1. 7.1), хөрөнгийн биржээр дамжуулахгүйгээр хаалттай хүрээнд арилжаалах (Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга-3.8) зэрэг нь ялгаатай нэр томъёо хэрэглэсэн боловч үүнийг агуулга нь тухайн үнэт цаасаа 50-иас дээш өтгөлдэд санал болгохгүй гэсэн утгыг илэрхийлж буй юм.

Хаалттай ХК-ийн өмнөх хуулийн орчин дахь ХХК-тай адил нэг шинж нь хаалттай ХК өөрийн хувьцаанаас бусад үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах боломжийг хаагаагүй байгаа юм. Нээлттэй ХК-ийн хувьд үндсэн шинжийг нь төдийлөн өөрчлөөгүй байна.

## ХОЁР. КОМПАНИ ДАХЬ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Компани дахь хяналтын тогтолцоо нь 1999 оны Компанийн тухай хуулийн дагуу хянан шалгах зөвлөлтэй байхаар хуульчлагдсан байв. Хянан шалгах зөвлөлтэй компанийн хувьд ТУЗ нь компанийг удирдах, гүйцэтгэх удирдлагыг хянах чиг үүрэг гүйцэтгэдэг, харин түүний үйл ажиллагааны зарим хэсгийг үндсэн чиг үүрэг нь хяналт байдаг хянан шалгах зөвлөл "шалгах" бололцоотой байсан. Өөрөөр хэлбэл, компанид хяналтын давхар тогтолцоотой байжээ.<sup>12</sup>

Онолын хувьд компанийн хяналтын тогтолцоог хоёр үндсэн хэсэгт хувааж үзэж байгаа юм. Нэг нь өмнө дурдсан ТУЗ-өөс гадна хяналтын тусдаа тогтолцоотой байх, нөгөө нь ТУЗ нь өөрөө хяналтын тогтолцооны нэг хэсэг байхыг хуульчлах онолын хувилбар юм. ТУЗ-өөс тусдаа, бие даасан хяналтын тогтолцоо чиг үүргээ биелүүлэх урьдач нөхцөл нь түүний эрх хэмжээ, эрх, үүрэг нь маш тодорхой байх, компани дахь аудитор, хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага гэх мэт бусад этгээдтэй харилцах асуудлыг нарийвчлан зохицуулах явдал байдаг. Энэ тогтолцооны сул тал нь компанийг удирдах эрхгүй байдгаас түүний хяналт тавих чадвар нь сул байх магадлалтай байдаг гэж үздэг.

Харин ТУЗ нь өөрөө удирдлагын чиг үүрэг гүйцэтгэхийн хажуугаар компанид хяналт тавих (зарим тохиолдолд өөрөө өөрийгөө хянах) чиг үүрэг гүйцэтгэдэг. Ийнхүү ТУЗ нь өөрийн бүтцийн дотор хяналтын чиг үүргийг гүйцэтгэх дараах урьдач нөхцөл байгаа юм. ТУЗ-д хараат бус гишүүн байх, эсхүл гүйцэтгэх удирдлагад багтаагүй гишүүн сонгох, ТУЗ нь дэд хорооноос бүрдэж ТУЗ-ийн зарим чиг үүргийг зөвхөн тухайн дэд хороо гүйцэтгэдэг байх,<sup>13</sup> дэд хороо болон ТУЗ, ТУЗ-ийн гишүүнээс ТУЗ, гүйцэтгэх удирдлагатай харилцах асуудлыг тодорхой тусгах, ТУЗ-ийн гишүүний итгэмжлэгдсэн үүргийн илүү өндөр стандарт тогтоох<sup>14</sup> шаардлагатай байдаг. Энэ тогтолцооны гол сул тал нь ТУЗ нь өөрөө өөрийгөө хянадгаас бизнесийн соёл, ёс зүйн шаардлагаас өөр хяналт зарим тохиолдолд байдаггүй явдал юм.

<sup>12</sup> Энэ талаар Амарсанаа.Б нар (2003) Бизнесийн эрх зүй (Хуульчлал зориулсан гарын авлага), 59-72.

<sup>13</sup> Өөрөөр хэлбэл, тухайлсан дэд хорооны чиг үүргийг ТУЗ хэрэгжүүлэх ёсгүй байдаг.

<sup>14</sup> Амарсанаа.Б (2010) Хуулийн этгээлийн удирдлагад хариуцлага хүлээлгэх чөлөөтэй. Хуулийн этгээлийн эрх зүйн байдал, хариуцлага: Хэрэгжүүлсэн эрх зүйн асуудал, 79.

Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хянан шалгах зөвлөлтэй хяналтын тогтолцооноос дэд хороотой ТУЗ-ийн тогтолцоонд шилжжээ. Энэ нь тодорхой хугацаанд хянан шалгах зөвлөлтэй байхын хажуугаар ТУЗ нь дэд хороотой байхыг шаардсан эрх зүйн орчинг өөрчилсөн сайн талтай.<sup>15</sup> Ийнхүү дэд хороо бүхий ТУЗ-ийн хяналтын тогтолцоог сонгосноор Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь хараат бус гишүүнийг хэрхэн тодорхойлох,<sup>16</sup> ямар чиг үүрэгтэй дэд хороо зөвлөхгүй байгуулах,<sup>17</sup> эрх бүхий албан тушаалтны итгэмжлэгдсэн үүрэг тодорхой байх<sup>18</sup> зэрэг зохицуулалт шинээр, эсхүл өөрчлөгдсөн байдлаар хийх шаардлага урган гарч байгаа юм.

## ГУРАВ. ШҮҮХНИЙН ОРОЛЦОО

1999 оны Компанийн тухай хуулийн төслийг анхлан боловсруулахад A Self-Enforcing Model of Corporate Law гэсэн өгүүлэл онолын гол тулгуур болгосон байдаг.<sup>19</sup> Менежерийн шийдвэр гаргах чөлөөт байдлыг хадгалахын хажуугаар олон хувьцаа эзэмшигчтэй компанийн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах боломжтой эрх зүйн хувилбар нь дээр дурдсан компанийн хуулийн загвар юм гэж тэд үзсэн. Гол санаа нь шилжилтийн улсуудад АНУ, Герман гэх мэт хөгжилтэй орнуудын компанийн хуулийг импортлох нь зохимжтой бус гэдэгт үндэслэдэг бөгөөд үүнийгээ тэд тайлбарлахдаа шилжилт хийж байгаа улсуудад зах зээл, соёл, институцийн үл оршин байгаа байдал, эсхүл эдгээрийн сул тал нь өндөр хөгжилтэй улсуудын хууль тохирохгүй байх байдалд хүргэнэ, иймээс тухайн нөхцөлд тохирсон хуулийг боловсруулах явдал хамгийн зөв арга юм гэсэн байдаг. Тухайлбал, шилжилтийн улсууд дахь шүүхийн тогтолцоо маргааныг ном журмынх нь дагуу шийдэхгүй, эсхүл шийдэх мэдлэг, чадвар дутна гэж үзэж байгаа юм.

Нэгэнт компанийн эрх зүйн маргааныг шүүх шийдвэрлэх мэдлэг чадвар дутмаг, институцийн хувьд найдвартай биш учраас шүүхэд аль болох хандахгүй байхаар, шүүхэд маргаан очсон ч хэм хэмжээ нь маш тодорхой буюу ойлгомжтой (bright-line rule), шүүх хэрэглэхэд алдаа гарахааргүй байхаар хуулийг боловсруулах зарчмыг иш үндэс болгох ёстой гэж тэд үзсэн. Нөгөө талаас компани дахь аливаа ашиг хонжоо хайсан (insider

<sup>15</sup> Эрх зүйн энэ орчин 2007-2011 он хүртэл үргэлжилжээ. Талруулбал, Компанийн тухай хууль (1999), Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо. Компанийн засаглалын кодекс (2007), Амарсанаа Б (2010/1-2) Монголын эрх зүй дэх хуулийн этгээдийн ойлголт ба эрх зүйн шинэтгэл // Эрх зүй сэтгүүл (18-19) т. 63-64.

<sup>16</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-79.1.

<sup>17</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-81.2.

<sup>18</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-84.4.

<sup>19</sup> 109 Harv. L. Rev., 1911 (1996).

opportunisin) үйл хөдлөлөөс компанид хамааралгүй томоохон хөрөнгө оруулагчдын (outside shareholders) эрх ашгийг хамгаалахуйц байдлаар компани дахь шийдвэр гаргах үйл явцыг зохион байгуулахыг оролдсон байдаг нь энэ загварын нэг амин сүнс болсон. Зарим жижиг хувьцаа эзэмшигчдийн ТУЗ дэх төлөөллийг хангах боломжийг олгож байгаа кумулятив арга, сонирхлын зөрчилтэй хэлцлийг хувьцаа эзэмшигчид эсхүл ТУЗ зөвшөөрөх механизмыг оруулах байдлаар үүнийг зохицуулах нь зүйтэй гэсэн байдаг.

Шүүхийг хэт "тойруулан", түүнээс зугтсан байдал өөрөө сул талыг бий болгож буй юм. Бидний өнөөдрийн танин мэдсэн төвшин маань шүүх зайлшгүй байх гэсэн ойлголт билээ. Харин бизнесийн аливаа хэрэгт аль шийдвэр бизнесийн хувьд зөв байсныг тогтоох чадвараар шүүгч бизнесменээс илүү байж чадахгүй гэдэгтэй шүүхийн шийдвэр гаргах хэмжээ хязгаар холбогдохыг үгүйсгэхгүй юм. Энэ бол шүүхийн бизнесийн шийдвэрийг нягтлан үзэх гол зарчим, хүрээ хязгаар байх ёстой юм. Бизнесийн маш олон маргаан шүүгчийг шударга ёсны үүднээс хандах шаардлагагүй байдлаар өрнөдөг. Зөвхөн шүүгч бизнесменээс илүү бизнесийн шийдвэр гаргах чадваргүй гэдэг зарчим л шүүхийн бизнесийн хэрэг маргааныг шийдвэрлэхэд тавигдах хязгаар байж болох юм.

Харин Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 100.1 дэх заалтыг үзвэл Компанийн тухай хуулийг зөрчлийг шүүгч тогтоож, улмаар шийтгэл оногдуулах боломжтойгоор хуульчилснаар Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үндэс болсон Компанийн тухай хуулийн үндсэн онолд тодорхой хэмжээгээр үндэслэхээ больсоныг харуулж байна.

## ДӨРӨВ. ТӨРИЙН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь төрийн оролцоо, тодруулбал, төрийн зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороонд компанийн дотоод асуудал, үйл ажиллагаанд оролцох боломжийг олгосноороо зарчмын шинжтэй өөрчлөлт хийжээ. Гэхдээ эдгээр нь хувьцаат компанийн тухайд хамааралтай эрх хэмжээ байна. Тухайлбал, дараах байдлаар төрийн байгууллагын эрх хэмжээ өргөжжээ:

- Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 26.6 дугаар зүйлийн дагуу хуульд заасан үндэслэлээр хувьцаат компанийг татан буулгах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл эрхтэй этгээд болсон байна;



- Компанийн өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа хууль зөрчиж үүнийгээ засах арга хэмжээ аваагүй тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо тухайн компанийг шүүхийн журмаар татан буулгах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрх;<sup>20</sup>

- Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш тодорхой хугацааны дотор гаргаж хүргүүлэхийг үүрэг болгох эрх;<sup>21</sup>

- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргаагүй бол тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болсныг нийтэд мэдээлэх эрх;<sup>22</sup>

- Компанийн хуралд оролцоогүй, эсхүл оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хурлын хуульд заасан тодорхой үндэслэлээр Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргах боломжтой болсон;<sup>23</sup>

- Хуульд заасан тохиолдолд захиргааны шийтгэлийг ногдуулах эрхтэй болжээ.

## ТАВ. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Компанийн санхүүгийн эрх зохицуулалтад дараах өөрчлөлт оржээ.

- Компанийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа; эзэмшигч ямар санал өгсөн, санал өгсөн эсэхээс үл хамааран тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй болсон;<sup>24</sup>

- Компанийн өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлсэн хөрөнгө гэсэн ойлголтыг ялгаж хуульчилсан;<sup>25</sup>

- Хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгийн харьцааг заасан;<sup>26</sup>

- Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хязгаарыг заагаагүй;<sup>27</sup>

- Хувь нийлүүлсэн хөрөнгийг өөрчлөх тохиолдлыг хатуу заасан;<sup>28</sup>

- Хувь нийлүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор дампууруулах тухай асуудлыг шийдвэрлэх процесс өөрчлөгдсөн;<sup>29</sup>

<sup>20</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-31.5.

<sup>21</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-46.14.

<sup>22</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-59.7.

<sup>23</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-70.2.

<sup>24</sup> Компанийн тухай хууль (1999)-25.6, Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-25.6.

<sup>25</sup> Компанийн тухай хууль (1999)-31.1, Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-30.1, 30.2.

<sup>26</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-30.3.

<sup>27</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-30.4.

<sup>28</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-31.2.

<sup>29</sup> Компанийн тухай хууль (1999)-32.2, Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-31.3-31.5.

- Нэг төрлийн хувьцаа нжил үнэтэй байхаар заасан;<sup>30</sup>
- Хувьцаа бүр саналын нэг эрхтэй ерөнхий зарчим өөрчлөгдөж хуульд заасан тохиолдолд энэ ерөнхий зарчмаас гажихаар болсон;<sup>31</sup>
- Давуу эрхийн хувьцаа гаргах асуудлыг ТУЗ <sup>32</sup>шийддэг байсныг энгийн хувьцаа эзэмшигчид шийдэхээр болсон;<sup>33</sup>
- Энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хөрвөх үнэ зах зээлийн үнээс доош байж болохгүй<sup>34</sup> байсныг сүүлийн нэг сарын жигнэсэн дундаж үнээс доогуур байж болохгүй болгож өөрчилсөн;<sup>35</sup>
- Опционы үнийн доод хязгаарыг тооцох аргыг өөрчилсөн;<sup>36</sup>
- Гаргасан энгийн хувьцааны нэгээс дээш хувьтай тэнцэх бүхэл тооны хувьцааг нэгтгэхийг хориглосон.<sup>37</sup>

Манай 2002 оны Иргэний хуулийг боловсруулахад тодорхой хэмжээгээр оролцсон гэгддэг Германы профессор Рольф Книпер 1999 оны Компанийн тухай хуулийг шүүмжилсэн байдаг. Түүний гол үндэслэгээ нь Монгол мэтийн зах зээлийн харилцаа хэлбэржих шатандаа явж байгаа улс орнуудад үнэт цаасны зах зээлд үндэслэсэн ийм нарийн зохион байгуулалттай хууль биш харьцангуй консерватив хандлагатай хууль зохимжтой гэсэн санаа байгаа юм.<sup>38</sup> Үнэндээ манай Компанийн тухай хуулийн санхүүжилт, үнэт цаас гэх мэттэй холбоотой санхүүгийн асуудлыг зохицуулсан хэсэг нь ойлгоход тийм ч хялбар биш юм. Профессор Книпер Германы зохицуулалтыг илүүд үзсэн бөгөөд Гүрж гэх мэт улсуудад үүнийгээ хэрэгжүүлсэн байдаг. Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хийсэн компанийн санхүүгийн эрх зүйн зохицуулалттай холбоотой дээр дурдсан нэмэлт, өөрчлөлтүүд түүний энэ санаатай ихээхэн зөрчилдөж байгаа юм. Нөгөө талаас Монгол Улсад зах зээлийн харилцаа хэлбэржин тогтсон гэж үзэж түүний энэ шүүмжлэл хүчингүй болсон гэж тооцох магадлал ч байхыг үгүйсгэхгүй юм.

## НЭГТГЭВЭЛ

Дээр дурдсан өөрчлөлтийг ийнхүү товчоор авч үзвэл Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь онолын хувьд ч, компанийн хяналтын

<sup>30</sup> Компанийн тухай хууль (1999)-33.4, Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-32.4.

<sup>31</sup> Компанийн тухай хууль (1999)-33.5, Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-32.6.

<sup>32</sup> Компанийн тухай хууль (1999)-76.1.4.

<sup>33</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-35.9.

<sup>34</sup> Компанийн тухай хууль (1999)-40.4.

<sup>35</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)39.4.

<sup>36</sup> Компанийн тухай хууль (1999)-41.3, Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-40.3.

<sup>37</sup> Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-51.2.

<sup>38</sup> Профессор Рольф Книпертэй хийсэн ярилцлага. (Б.Амарсанаа, Японы Нагояа хот) 2006/10/28.



## Монголын хууль тогтоомжийн шинэтгэлийн түүхийн асуудалд



**МУИС-ийн Хууль зүйн  
сургуулийн Эрх зүй, төрийн  
онол, түүхийн тэнхмийн эрдэм  
шинжилгээний ажилтан,  
докторант Б.Батбаяр**

### ОРШИЛД НУРШИХЫН УЧИР

Монголын эрх зүйн түүхийн ерөнхий чиг хандлага, хууль тогтоомжийн хөгжлийн түүхээс харвал Монгол Улсад хууль тогтоомжийг шинэтгэх үйл явц “энгийн”-ээс улам бүр “боловсрон” хөгжиж ирсэн дүр зураг харагддаг.

Тухайлбал, Эзэнт гүрний үед үйлчилж байсан Их засаг хуулиас хойш өнөөг хүртэлх Монголын хууль тогтоомжийн хөгжлийн ерөнхий дүр зургийг дор схемчлэн авч үзье.

|  |                                     |                                                          |               |
|--|-------------------------------------|----------------------------------------------------------|---------------|
|  | Эзэнт гүрний үеийн<br>Монгол        | - Их засаг<br>- Юаны цаазууд                             | 1206-<br>1368 |
|  | Улс төрийн бутралын<br>үеийн Монгол | - Алтан ханы цааз<br>- Үйсэн цаазууд<br>- Их цааз (1640) | 1368-<br>1634 |
|  | Манжийн эрхшээлийн<br>үеийн Монгол  | - Халх журам<br>- ЗТГМТЗЯЯХЗБ<br>- Монгол цаазын бичиг   | 1634-<br>1911 |

|      |                     |                                                                                                                                            |                                  |
|------|---------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------|
| I.   | Хаант Монгол Улс    | - Зарлигаар тогтоосон<br>Монгол Улсын Хууль<br>зүйлийн бичиг<br>- Богдын лүндэн, зарлиг<br>- ЗГ-ын тогтоол,<br>шийдвэр<br>- дүрэм, журмууд | 1911-<br>1919                    |
|      |                     |                                                                                                                                            | 1921-<br>1924                    |
| II.  | БНМАУ               | Үндсэн хууль, түүнд<br>нийцүүлэн гаргасан<br>бусад хууль тогтоомж                                                                          | 1924                             |
|      |                     |                                                                                                                                            | 1940                             |
|      |                     |                                                                                                                                            | 1960                             |
| III. | Өнөөгийн Монгол Улс | Нэмэлтийн хуулийн<br>дагуу                                                                                                                 | 1990-<br>1992                    |
|      |                     | Шинэ Үндсэн хуулийн<br>дагуу                                                                                                               | 1992-<br>1997                    |
|      |                     | Эрх зүйн шинэтгэлийн<br>хөтөлбөрийн дагуу                                                                                                  | 1998-<br>2007                    |
|      |                     |                                                                                                                                            | 2008<br>оноос<br>өнөөг<br>хүртэл |

Эзэнт гүрний үеэс хойш 1910-аад он хүртэл 700 гаруй жилийн хугацаанд Монгол Улс нь хэмжээгүй эрхт хаант засгийн хэлбэрээр оршин тогтнож, мөн эл хугацаанд хууль цааз нь нийгмийн хөгжлийн хувьсал өөрчлөлтөд зохицон, ерөнхийдөө заншлын эрх зүйн уламжлалт чиг хандлагыг баримжаалан тухай тухайн үеийнхээ нийгмийн харилцааг зохицуулан хөгжсөөр иржээ.

Харин 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн тунхагласнаар нийгмийн харилцааг манжийн хуулиар бус өөрийн хуулиар зохицуулах шаардлага шинэ төрийн өмнө тавигдсан бөгөөд үүнийгээ ч бодит ажил болгоход чиглэсэн олон зүйл арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Ийнхүү Богд хаант засгийн үед хууль тогтоомжийн шинэтгэлийн анхны алхамыг хийж эхэлсэн байдаг. Нөгөө талаар аливаа шинэтгэл “хуучныг халах, шинээр

бий болгох" гэсэн цөм утгыг илэрхийлдэг. Энэ үүднээс авч үзвэл хууль тогтоомжийн шинэтгэлийн анхны шат яалт ч үгүй тусгаар тогтнолоо сэргээн байгуулсан хаант Монгол Улсын үед холбогдож байна.

Үүний дараа 1921 онд ардын хувьсгал ялснаар Богдыг хэмжээт эрхт хаанд өргөмжилж, шинээр байгуулагдсан төр мөн л хуучин тогтолцоог халж, шинэ тогтолцоо бүрдүүлэх, улмаар 1924 онд анхны Үндсэн хуулиа баталж, түүнд нийцүүлэн бусад хуулийг шинээр боловсруулан, батлан гаргаж, хуучин эрх зүйн тогтолцоог үндсээр нь өөрчлөн халснаар хууль тогтоомжийн шинэтгэлийн дараагийн үеийг эхлүүлсэн гэж үзэж болно.

1990 онд тоталитари дэглэмийг халж, үүний үндсэнд Үндсэн хуулийн нэмэлтийн хууль, түүнийг дагасан 30 гаруй хууль, улмаар 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлан мөрдсөнөөр хууль тогтоомжийн шинэтгэлийн дараагийн томоохон үе эхэлсэн билээ.

Дээр дурдсанаас үзвэл, хууль тогтоомжийн шинэтгэлийг дараах байдлаар хуваан ангилж болох юм.

*I. Тусгаар тогтнолоо сэргээсэн цөийн хууль тогтоомжийн шинэтгэлийн үе*

I.1. 1911-1919

I.2. 1921-1924

*II. Бүгд найрамдах байгуулалт шилжсэн цөийн хууль тогтоомжийн шинэтгэлийн үе*

II.1. 1924-1940

II.2. 1940-1960

II.3. 1960-1989

*III. Ардчилсан нийгэмд шилжсэн цөийн хууль тогтоомжийн шинэтгэлийн үе*

III.1. 1990-2007

III.1.1. 1990-1992

III.1.2. 1992-1997

III.1.3. 1998-2007

III.2. 2008- одоог хүртэл

*Өнөөдөр, эрх зүйн шинэтгэлийг:*

1. хууль тогтоомжийг шинэтгэх;
2. хууль тогтоох, түүний гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх;
3. хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх;
4. эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх;

5. нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлэх<sup>1</sup> зэрэг хүрээг хамарсан цогцолбор үйл явц хэмээн Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид тодорхойлсон байдаг бөгөөд дараа дараагийн судлаачид эдгээр үндсэн чиглэлийг дэмжин баримталсаар ирээ.

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид багштан эрх зүйн шинэтгэлийн гол цөм болох хууль тогтоомжийн шинэтгэлийн анхдугаар шатыг<sup>2</sup> хууль тогтоомжийн хувьсал, хөгжил тухайн нийгмийн харилцаанаасаа хамаардаг, мөн эргэж нөлөөлдөг шүтэлцээг гол шалгуур болгон 1990 оноос эхлүүлэн авч үзжээ.

Харин энэхүү илтгэлд монголын хууль тогтоомжийн шинэтгэлийн эхлэлийг 1911 оноос эхлүүлэн авч үзсэн нь, Б.Чимид багшийн саналыг үгүйсгэж байгаа хэрэг биш, харин асуудлыг өөр өнцгөөс авч үзсэнд оршиж байгаа бөгөөд оршил болгон нуршсаны учир энэ болой.

Иймд сэдвийн хүрээнд хууль тогтоомжийн шинэтгэлийн эхний үе болох Тусгаар тогтнолоо сэргээсэн үеийн хууль тогтоомжийн шинэтгэлийн үе, түүний дотор 1911-1919 оны үеийг хамрах хууль тогтоомжийн шинэтгэлийн үйл явц хэрхэн явагдсан хийгээд хэрэгжсэн тухайд товч авч үзье.

Үүнд дараах 3 үндсэн асуудлыг хөндсөн.

- Манжийн эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжийг халах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- Үндэсний эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- ЗТМУХЗБ-ийг боловсруулах шаардлага;
- ЗТМУХЗБ-ийг боловсруулан, Улсын хурлаар хэлэлцсэн нь;
- Хүрсэн үр дүн, дүгнэлт.

## I. МАНЖИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХАЛСАН НЬ

Монголчууд 1911 онд үндэсний тусгаар тогтнолоо сэргээсний дараа Манж Чин Улсын төр, эрх зүйн тогтолцоог халах, тухайн үед дагаж мөрдөж байсан манжийн хууль тогтоомжийг хүчингүй болгон, өөрийн үндэсний онцлогийг тусгасан төр, эрх зүйн тогтолцоотой болох, үүгээрээ тусгаар улс гэдгээ баталгаажуулах зэрэг олон зүйл зорилтыг дэвшүүлэн тавьж байв.

<sup>1</sup> Чимид Б. (2008) Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Хоёрдугаар дэвтэр. Уб, 15-16.

<sup>2</sup> Чимид Б. (2008) Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Хоёрдугаар дэвтэр. Уб, 17 дахь талаас дэлгэрүүлэн үзэе үү.

Ийм ч учраас 1911 оны 12 дугаар сарын 29-нд Богд Жавзандамба хутагтыг улсын хаанд өргөмжилж, Богд хааны зарлигаар Монгол Улсын таван яамыг, 1914 онд Улсын дээд, доод хурлыг, тэрчлэн аймаг хошуудын хурал, яам, тамгын газар, отог, аравны захиргаад, мөн шүүх, цэрэг, цагдаагийн тогтолцоог байгуулж, улмаар 1919 он гэхэд Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг хэмээх 65 дэвтэр төрөлжүүлэн нэгтгэсэн суурь хуулийг эцэслэн баталж, түүнийгээ үндсэн эх сурвалжаа болгон, эрх зүйн шинэ тогтолцоог бүрдүүлжээ.

Тусгаар улс болсны дараа Монголчууд өөрсдийн үндэсний эрх ашгийг эрхэмлэсэн хууль цааз тогтоох, хууль тогтоомжийн шинэтгэл хийх зайлшгүй нөхцөл байдал үүссэнийг ухамсарлаж байсан бөгөөд энэ үүднээс юуны түрүүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нэг нь Манжийн хууль цаазыг халах явдал байв.

Энэ тухай судлаач Б.Содовсүрэн агсан Манжийн хууль цаазыг халах ажил хоёр үе шаттайгаар хэрэгжсэн, үүнд: 1. 1911-1915 онуудад Монгол дахь Манжийн засаг захиргааг халах, төрийн аппаратыг цэгцлэх, эдийн засаг-санхүүгийн шинэ бодлого явуулах, сургууль байгуулах, шүүхийн систем, цааз хуулийг шинэтгэх, 2. 1915-1918 онуудад Монгол Улсын Хууль зүйлийн эмхтгэлийг бэлтгэж, улсын дээд, доод хурлаар хэлэлцүүлж, Богд хаанаар батлуулж, улмаар олшруулах арга хэмжээ авсан<sup>3</sup> хэмээжээ.

Тухайн үеийн түүхэн нөхцөл байдлаас үүдэн манжийн хууль цаазыг шууд халах боломжгүй байсан, тиймээс ч Богдын Засгийн газар шинэ хууль цааз зохиохын наана аливаа эрүү шүүлтийн хэргийг шүүж шийтгэхэд дөнгө дөнгөлөх, ташуур занчих, торгож шийтгэх, таслан дуусгах зэрэг хэргийг Манжийн хуулийг баримтлан шийтгэж хаяа үл болохыг нь зохисыг үзэж жич хянан тогтоож байхаар шийдвэрлэж<sup>4</sup> байжээ. Ер нь Манжийн хууль тогтоомжийг халах, өөрчлөх талаар гарсан баримт<sup>5</sup> нэлээдгүй бий бөгөөд энэ удаад тэдгээрийг бүгдийг дурдах нь илүүд учир та бүхэн “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл (1206-2009) 16 боть бүтээлийн хоёрдугаар ботиос уншиж танилцана биз ээ.

Ийнхүү XX зууны эхээр монголчууд тусгаар тогтнолоо сэргээснээр тухайн үед үйлчилж байсан манжийн хууль цааз хүссэн хүсээгүй монголын эрх зүйд байраа тавьж өгөх нийгэм, улс төр, оюун санааны урьдчилсан нөхцөл бүрэлдэн бий болжээ. Энэ нь улс орны дотоод, гадаад түүхэн

<sup>3</sup> Содовсүрэн Б. (1989) *Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз (1911-1920)* Ув, 41.

<sup>4</sup> (2010) *Шүүх яамнаас аливаа хэргийг шийтгэхэд манжийн хуулийг мөрдөн гүйцэтгэх тухай зарласан бичиг*. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Хоёрдугаар боть (1911-1926.V сар) Ув, 28.

<sup>5</sup> (2010) *Шүүх яамнаас аливаа хэргийг шийтгэхэд манжийн хуулийг мөрдөн гүйцэтгэх тухай зарласан бичиг*. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Хоёрдугаар боть (1911-1926.V сар) бүтээгээс дэлгэрүүлэн үзэж болно.



нөхцөл байдал, монголчуудын олон жилийн далд тэмцлийн үр дүнд бэлтгэгдэж байсан бодит шинжтэй байв.

Ямартай ч Монгол Улс нь бие даасан тусгаар улсын хувьд бусад улсын хуулийг хэрэглэж таарахгүй бөгөөд энэ үүднээс манжийн хууль тогтоомжийг халах, тэгснээр өөрийн гэсэн үндэсний хуультай болох шаардлага нийхүү тулгаржээ.

## II. ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ТОГТООЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРУУЛСАН НЬ

### *ЗТМУХЭБ-ийг боловсруулах шаардлага*

Тусгаар тогтнолоо сэргээсэнтэй холбогдон түүнийгээ батлан хамгаалах, бэхжүүлэх үзэл санаа тухайлбал, Монгол Улсын хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, нийгэм, улс төрийн байгуулал, хууль цааз, эдийн засаг, соёлын хувьд бие даах чадвар зэрэг туурга тусгаар улсын үндсэн хэв шинжийг бүрдүүлэх үзэл санаа тухайн үеийн монголын тэргүүний дэвшилт үзэл бүхий хүмүүсийн анхаарлыг зүй ёсоор татаж байсан бөгөөд үүнийгээ ч бодит ажил болгоход чиглэсэн арга хэмжээ авч эхэлжээ.

Монгол Улсын тусгаар тогтнолоо батлан хамгаалах гадаад бодлого нь хөрш хоёр их гүрэнтэй харилцан, дипломатын болон цэрэг зэвсгийн хүчээр тусгаар тогтнолоо хамгаалах, гуравдахь хүчирхэг улсын ашиг сонирхлыг бий болгож, тусгаар тогтнолоо хамгаалан бататгах, сэргээх хэрэгт тусламж, дэмжлэг олох, дэлхийн голлох улсуудтай харилцан тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлж, найрамдлын болон худалдааны гэрээ байгуулах, шашин шүтлэг нэгтэй бага буурай улстай тусгаар тогтнолоо харилцан зөвшөөрч, бие биеэ дэмжих, үндэсний тусгаар тогтнолыг олон улсын эрх зүйн үүднээс үндэслэн баталгаажуулах<sup>6</sup> зэрэг чиглэлээр явагдаж байсан бол дотоод хүчин зүйл нь үндэсний эв нэгдлийг бататгах, бие даасан тусгаар тогтносон улсын хэв шинж, бэлгэдлийг бүрэлдүүлэх, батлан хамгаалах хүчин чадлыг зузаатгах, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын хүрээнд шинэтгэл хийж, улс орны хүч боломжийг нэмэгдүүлэх<sup>7</sup> зэрэг цогц хүчин зүйлээр нөхцөлдөж байсан бөгөөд эдгээрийг хуулиар зохицуулах шаардлага тулгарч байв.

Нөгөө талаар өмнөх үеийн нийгмийн хоцрогдол, эрх мэдэл бүхий дээд ангийнхны үзэл бодол, тухайн үеийн монголын нийгмийн байдал, манжийн эрх зүйн тогтолцоог халж, өөрчлөн шинэчлэх зайлшгүй нөхцөл байдал үүссэн бөгөөд энэ талаар монголын сэхээлэг хэсгийнхэн өөрсдийн

<sup>6</sup> (2008) Монгол Улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: хувьсал, өөрчлөлт (XX зуун) У6, 18

<sup>7</sup> (2008) Монгол Улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: хувьсал, өөрчлөлт (XX зуун) У6, 29-30.

санаа бодлоо янз бүрийн арга хэлбэрээр илэрхийлж байв. Эдгээрээс бусдын эрх зүйн соёлоос авч хэрэгжүүлэх ямар боломж байгааг өгүүлсэн баримтууд ихээхэн сонирхолтой.

Тухайлбал, 1914 онд тухайн үеийн бичгийн нэрт түшмэл Ч.Дэмчигдорж хууль цаазны шинэчлэл хийж шинэ хууль зохиохын чухлыг заасан өргөх бичиг Улсын хурлын газар өргөсөн тухай, мөн Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн дуртган даалгасны дагуу эрдэмтэн Ж.Цэвээний туурвисан “Улсын эрх” хэмээх бүтээлд гадаад олон улсуудын төрийн тогтолцоо, парламентат ёс, эзэн хааны эрх, нутгийн захиргааны эрх хийгээд аливаа улсын засаг төрийн эх үндэс болсон хүний эрхийн асуудлыг нэлээд нухацтай авч үзсэн байдаг. Өрнийн эрх зүйн соёл сэтгэлгээнээс суралцах, түүнийг монголын нөхцөлд хэрхэн тохируулж авах, шинэтгэлийн үр дүнд бий болсон эдгээр үзэл санааг хэрхэн хуульчлан тогтоох зэргийг тухайн үеийн дэвшилт үзэлтнүүд өөр өөрийн байр сууринаас хандаж өгүүлжээ.

Мөн санхүү, татвар, төрийн төсөв зардал хэмнэх арвилах, үндэсний болон гадаад худалдааг хөгжүүлэх, үндэсний банк байгуулах, мөнгөн тэмдэгттэй болох, дамын худалдаа хориглох, сургууль соёл байгуулах гэх мэт эдийн засаг, соёл боловсролын хүрээнд авч хэрэгжүүлсэн санаа, санаачлага ихээхэн гарч байсан бөгөөд эдгээр нь хууль тогтоомжийн шинэтгэлд зохих нөлөө үзүүлснийг дурдах хэрэгтэй.

Ийнхүү тусгаар улс өөрийн хэргээ өөрөө мэдэж, ард олноо удирдан жолоодоход өөрийн үндэсний хуультай болох ёстой гэсэн үзэл санаа нь Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийг боловсруулах нэн тэргүүний зорилт болж байсан бол удаад нь тухайн үеийн нийгэм, улс төр, соёл, гадаад дотоод хэд хэдэн хүчин зүйл шийдвэрлэх нөлөө үзүүлжээ.

*ЭТМУХЗБ-ийг боловсруулан, Улсын хурлаар хэлэлцсэн нь*

Юуны өмнө Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн төслийг хэдий үеэс боловсруулж эхлээд, хэдийд эцэслэн баталсан бэ гэдэг асуудал зүй ёсоор анхаарал татаж байна.

Судлаачдын судалгаанаас авч үзвэл, Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийг боловсруулж баталсан ерөнхий цаг хугацааг хэд хэдэн өөр үед авч үзжээ. Энэ нь:

1. 1915-1918 он гэх дийлэнх судлаачдын санал;
2. 1913 оны сүүлээс 1918 он гэх О.Батсайхан, Э.Лонжид нарын судлаачийн санал;
3. 1914 буюу 1918 он гэх В.Н.Маркелов, Б.Я.Владимирцов нарын

судлаачийн санал;

4. 1911-1919 он гэх судлаач Б.Содовсүрэнгийн санал.

Дээрх саналаас 1911-1919 оны үед хамаатуулан авч үзэх саналыг дэмжиж буй бөгөөд ингэхдээ олноо өргөгдсөний тэргүүн он өвлийн дундад сарын хорин таванд Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам эрхлэн одоо Монгол өөртөө тусгай улс болон тулгар төр байгуулж, Чин Улсын хууль дүрэм, суртлыг хэрэглэхгүй болсны тулд Монголын олон яамд шинэ тамга нээн явуулах тухай Богдод айлтган ёсоор болгуулж хэргийг шийтгэн гүйцэтгэснээр үндсэндээ шинэ хууль зүйлийн бичгийг зохиох үндэс суурь тавигдсан хэдий ч хараахан шууд боловсруулж эхлээгүй түүхэн нөхцөл байдалтай холбон авч үзэж 1913 оноос эхлүүлэн авч үзэх саналтай байна. Харин хууль тогтоох үйл ажиллагааны эцсийн шатыг 1919 оноор дуусгавар болгон үзэх бөгөөд энэ талаар хойно тодруулан авч үзнэ.

Одоо мэдэгдэж буйгаар Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичигт шууд холбогдох 1915-1920 он хүртэлх хугацаанд гарсан Улсын дээд, доод хурлын 60 орчим баримт байна. Үүнээс он тус бүрээр гаргавал, 1915 оны 3, 1916 оны 1, 1917 оны 14, 1918 оны 32, 1919 оны 1, 1920 оны 1 баримт байна. Эдгээрийн ихэнх нь 1918 онд хамаарч буй бөгөөд тол төлөв хууль зүйлийн бичгийн заалт, дэвтрийг хэлэлцсэн, хэлэлцэхийг хойшлуулсан зэрэг асуудалд холбогдож байна. Гэхдээ эдгээр баримт нь тухайн асуудлаар хэлэлцсэн үйл явцыг бүрэн тусгаагүй, хэлэлцээд гарсан шийдвэрийг бичсэн байгаа нь цааш нарийвчлан судлахад нэлээд бэрхшээл учруулж байна.

Дээрхээс үзвэл Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийг Улсын дээд, доод хурлаар хэлэлцүүлсэн баримт Монгол Улсын Үндэсний төв архивт бүрэн хэмжээгээр хадгалж үлдээгүй бололтой. Ямартай ч Монгол Улсын Үндэсний төв архивт буй Улсын дээд, доод хурлын баримтаас хууль зүйлийн бичгийг хэлэлцэж эхэлсэн баримт 1916 оноос эхэлж буй. Түүнд Улсын Дээд хурлын газраас хууль зохиож бүхий хуулиас энэ завсраа зохиож төгсгөсөн эссэн, хэрэв төгсөөгүй ахул хичнээн зүйлийг хэрхэн зохиосныг дараагийн Дээд хуралд толилуулах ба мөн сайд ноёдын биес хуралдан ирж хамтаар хэлэлцэн шийтгэх зүйл буй учрыг Дээд хурлын газраас цохож тушаасан үүнийг хуулийг зохиож бүхий сайд ноёд түшмэд нарт хуудсаар явуулаад байцаан үзэж гүйцэтгэн шийтгэх ажаамуу хэмээн дурджээ.

1916 оны өвөл хууль зохиох комиссынхон хууль шинэтгэн зохиоход шүүх хууль, монгол хуулийн алиныг гол болгох ба бичиг хэргийн түшмэлийг ялгаварлах эсэхийг тогтоолгохоор шинэ хуулийг зохиохуйд

тулгарлан тогтоож үл чадах зүйл ангийг Монгол хуулиар гол болгож, дутагдахыг нь шүүх цаазнаас нөхөн авч хэрэглэх ба бас ёслол, цэрэг, сангийн тухайг өөрийн хуулиас авч гүйцэтгэн, алах, цөлөх ялын хэргийг урьд айлтгаад тогтоосон хэргийн ёсоор журамаан дагаж шийтгүүлэн жич тэргүүн, дэд сайдууд, эрхэлсэн түшмэл нарт зэрэг дэв байгуулж, түшмэлийг бичиг, цэргийн хэмээн ялгаварлан тогтоовоос зохимой хэмээн цохож ирсэн ёсоор бүрнээ зохион гүйцэтгэвээс зохих бөлгөө. Гагцхүү үүний дотор Монгол хуульд заасан зүйл цөөн, шүүх цаазын бичгээс аван иш татаж хэрэглэлтэй зүйл маш үлэмж болохуй нь харин ч шүүх хуулийг гол болговоос зохих мэт боловч хольцуулан зохиохуйд ялын нэр, цаазын санаа тасархайяа өөр бөгөөд харилцан нийлүүлэхүйд будлиан адбиш үлэмж болохын дээр манай монголчуудад угаас муж зохиож, гацаа хүй байгуулан, бүгд захирагч сайд, цагдан засагч сайд, фү, сян-ий мэдэгч, гацаа хүйн даргын зэрэг тушаал тавьсангүй бөгөөд энэ зэргийн захирах орныг хэрхэн хувьсган тогтоохыг тулгарлан үл чадах ба түшмэлийг бичиг, цэргийн хэмээн ялгаварлан хэлэлцэхэд Монгол хошуу язгуураас Манж Цахарын адил үүрд цалин идэх жинхэнэ цэрэг, цэргийн түшмэлгүй, хошуу сумны түшмэл цөм бичиг, цэргийн хэргийг хавсран шийтгэсээр ирсэн нь энэ үе ялгавартай болгож хошууны түшмэдийг цэргийн түшмэл хэмээн нэрийдье гэвч бичгийн хэрэгт оролдсон тушаал бус хэмээн ялгахад бэрх төдийгүй мөн ер Манж хятадын адил хүртэх цалин, бууруулах зэрэггүйн тулд хошууны түшмэлийг бичиг, цэргийн хэмээн ялгахгүй хавсран шийтгэх тушаал болговоос ямар болов хэмээн санагалзсан учрыг гаргаж шүүх цаазаас иш татаж авалтай зүйлийг түүж бичсэн дэвтрүүдийг Улсын хурлын газраа өргөжээ.

Энэхүү бичгийг үзэх аваас хууль зохиох комиссынхон хууль зүйлийн бичгийг зохиохдоо манжийн хуулийг эш татахаасаа монгол хуулиа гол болгохыг илүүтэй чухалчилж байсныг илтгэхийн зэрэгцээ энэ тухай хууль зүйлийн бичгийг Улсын дээд, доод хурлаар хэлэлцсэн нэлээд хэдэн баримтад тодорхой тусгажээ.

Улсын дээд, доод хурал Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн заалт, дэвтэр бүрийг бүрэн бус тоогоор 1916 онд 3 удаа, 1917 онд 19 удаа, 1918 онд 34 удаа тус тус хэлэлцсэн байх бөгөөд тэдгээрт хууль зохиох комиссын гишүүдийн ирүүлсэн хууль зохиохуйд шүүх, Монгол цаазын алийг гол болгох, сайд, эрхэлсэн түшмэлд дэв байх эсэх, эрүүгийн дотор цөлөх хэдэн зэргийг хэрхэн хувьсган тогтоох гэх мэт хууль зохиохтой холбогдсон олон зүйл асуудлыг хэсэг хэсгээр нь дамжуулан хэлэлцээд заримыг нь битүүлэг тул залруулан ирүүлэхийг даалгах, заримыг нь уг төлөвлөсөн ёсоор гүйцэтгэвээс зохино хэмээн

зөвшөөрч хууль зохиох түшмэдэд илгээх, заримыг нь дараагийн хуралд авч хэлэлцье хэмээх зэргээр шийдвэрлэжээ.

Улсын дээд, доод хурлын баримтад тулгуурлан хууль зүйлийн бичгийг хэрхэн хэлэлцэж, шийдвэрлэсэн тухай зарим асуудлыг товч үзье.

1916 оны 8 дугаар сард Улсын дээд хурлын газраас хуулийг энэ завсраа зохиож төгсгөсөн эссэн, хэрэв төгсөөгүй ахул хичнээн зүйлийг хэрхэн зохиосныг дараагийн дээд хуралд толилуулах, мөн сайд, ноёдын биес хуралдан ирж хамтаар хэлэлцэн шийтгэх<sup>8</sup> хэрэгтэй хэмээн хууль зохиох комиссынхонд даалгажээ.

Ингээд 1916 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Улсын доод хурал хуучин хуулийг хөнгөтгөн тогтоох асуудлыг хэлэлцсэн бөгөөд үүнд хууль зохиох комиссын түшмэдээс ирүүлсэн хуучин хуулийг хөнгөтгөн тогтоохоор төлөвлөсөн эрүүгийн зургийг үзэж хянаваас ийнхүү тогтоохууд арайхан хөнгөн мэт бөгөөд муу самуун ард цаазын асар хөнгөнд эрэмших гэм гарах болуужин хэмээн эргэлзэх боловч тус тус дээд хурлаас лавлан тогтоолгоё<sup>9</sup> гэсний дагуу 2 өдрийн дараа Улсын дээд хурал хянан үзжээ.

Улсын дээд хурал хууль зохиох комиссын боловсруулсан төслийг, доод хурлын цохсоны хамт үзэж хэлэлцээд энэ зүйлийн хорин эрүүгийн зургийг эгүүлэн хүргүүлж сайтар хянуулан гүйцэтгэж даруй ирүүлээд жич тогтоон хянуулсуй<sup>10</sup> хэмээн шийдвэрлэжээ.

Мөн Улсын доод хурал 1917 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр шинэ хууль зүйлийн бичгийн заалтуудыг дахин хэлэлцсэн бөгөөд үүнд хууль зохиох комиссынхны ирүүлсэн хууль зохиохууд шүүх, Монгол цаазын алийг гол болгох ба сайд эрхэлсэн түшмэлд дэв байх эсэх, жич эрүүгийн дотор цөлөх хэдэн зэргийг хэрхэн хувьсган тогтоохыг эрсэн<sup>11</sup> зэргийг үзээд, манай улс шүүх, Монгол хуулийг гол болгон шүүх хуулиас дав дув хэрэглэхийг нэмэн оруулж зарлан тархааж шүүх хуулийг хянан Шүүх яамны зэрэг газраа хадгалж удирдан хэрэглэвээс ямар. Сайд эрхэлсэн түшмэлд эрхгүй дэв байлтай. Цөлөх алах ялыг одоогийн айлтгаад явуулсан хэргийг хянан тогтоолтой болов уу. Яамны түшмэлийг бичгийн, хошууны түшмэлийг цэргийн хэмээн нэрийдэж завсарт харилцан хэрэглэвээс ямар<sup>12</sup> гэсэн санал өргөж нийлэлцэх эсэхийг Дээд хуралд толилуулан тогтоолгоё гэжээ.

<sup>8</sup> УТА. Хм-А-1, Д-1, Хн-3, х.84, эх. Монгол Улсын 1911, 1902 хурал I. Баримт бичгийн эмгэгтэй (1914-1916) Эмгэгтэй Гэрлэвдэр. Ж. Далгэрмаа. Ү. Жавзандаулам. Э. Уб. (2003), 253.

<sup>9</sup> УТА. Хм-А-1, Д-1, Хн-3, х.31, хуулга. Дурдсан бүтээл, 215.

<sup>10</sup> УТА. Хм-А-1, Д-1, Хн-3, х.14, хуулга. Дурдсан бүтээл, 225.

<sup>11</sup> УТА. Хм-А-1, Д-1, Хн-3, х.32, хуулга. Монгол Улсын 1911, 1902 хурал II. Баримт бичгийн эмгэгтэй (1917-1918) Эмгэгтэй Гэрлэвдэр. Ж. Далгэрмаа. Ү. Жавзандаулам. Э. Уб. (2005), 31.

<sup>12</sup> УТА. Хм-А-1, Д-1, Хн-3, х.32, хуулга. Дурдсан бүтээл, 31.

Энэ мэтээр 1917 онд Улсын доод хурал хууль зохиох комиссын гишүүдээс ирүүлсэн битүү хулгайн хэргийг хуульд хэрхэн оруулах<sup>13</sup>, шинэ хууль зүйлийн эрүүгийн заалтууд<sup>14</sup>, түүний ялын хэмжээ<sup>15</sup> зэргийг хэлэлцэн Дээд хуралд хянан хэлэлцүүлэхээр тогтоожээ.

1918 онд Улсын доод хурал нь хууль зүйлийн бичгийн талаар нийт 9 удаа хэлэлцжээ. Энэ хугацаанд шинэ хууль зүйлийн дөрвөн, тав, зургаа, долдугаар дэвтэр, наймаас арван тавдугаар хүртэл дөрвөн анги товхисон найман дэвтэр, мөн хууль зохиох комиссын лавлан тогтоолгохоор өргөсөн арван зүйл санал, битүү хулгайн хэрэг, пүнлүү ба хэрэглэл олгох, гяндан байгуулах, ёслол үйлдэх, майдар бурхан залах журам зэргийг хуульд хэрхэн оруулах талаар хэлэлцсэн бөгөөд хууль зохиох комиссын ирүүлснийг хянан үзээд, ...хянаваас зүйтэй тул чингэсүгэй хэмээх санаагүй... хэмээн Улсын дээд хуралд толилуулахаар өргөжээ. (зургаан удаагийн хэлэлцсэн баримтад ямар нэгэн санал дэвшүүлээгүй байна)

Харин хууль зохиох комиссын гишүүдийн ирүүлсэн:

1. Олон ван гүнгүүдийн пүнлүүний торгыг бүрнээ хасах, эсхүл торгонд зохиыхыг үзэж мөнгө таацуулан олгох, бас эх зохиох түшмэл, жинхэнэ бичээч, сав хэрэглэлийн нярав нарт хэрэглэл нэмэн олгуулах, бас Ховл, Улиастай хоёр газарт суух сайдуудын газраа нутгийн ойрыг үзэж аливаа хүнд ялсныг цаазаар аваачих ба жич ялсныг хорих гяндан байгуулах эсэх хэмээсэн гурван зүйл.

2. Ерөнхийлөн шийтгэх ба тэргүүн сайдаас эрхэлсэн дэслэсэн түшмэл, ёслолыг удирдагч түшмэлд хүртэл уг тушаалын дэв дараалан хөтөч олгуулах ба эх зохиох түшмэл жинхэнэ бичээчийн хөтөчийг уг хэвээр явуулбаас тэнхцэж болох болов уу. Бас Дөрвөд хоёр аймгийн олон ван гүнгүүдийн хатан гэргий, жич туслагч тайж сүмийн да лам нарт олгуулж бүхий пүнлүүний торгыг хэрхэн болгох,

3. Найман сарын шинийн наймны Улсын Доод хуралд Богд эзний их ёслол явуулах өдөр тохиолдох тухай бүр олон лам ноёдыг хуралдан ирүүлэх учир хууль зүйлд оруулах нэг хэрэгт үзэж хянаваас, эдүгээгийн таван анги, дөрвөн жасаа болгон чингэж ёслолыг гүйцэтгэхээр төлөвлөн бичсэн нь зүйтэй мэт. Гэвч тэргүүн сайдаас хоёр хуралд хэлэлцүүлбэ гэсэн гурван удаагийн хэргийг хянан үзээд:

- гагцхүү эх зохиох түшмэл, жинхэнэ бичээч, сав хэрэглэлийн нярав нарт хэрэглэл нэмэгдүүлэх эсэхийг Дээд хуралд толилуулъя;

- Дөрвөдийн хоёр аймгийн олон ван гүнгүүдийн хатан гэргий туслагч тайж лам нарт олгуулах пүнлүүний торгыг бүсэд аймаг хошуудаас онц

<sup>13</sup> УТА. Хм-А-1. Д-1. Хн-4. х.26, хуулга. Дурдсан бүтээл. 34.

<sup>14</sup> УТА. Хм-А-1. Д-1. Хн-4. х.28, хуулга; УТА. Хм-А-1. Д-1. Хн-4. х.30, хуулга; Дурдсан бүтээл. 36, 37.

<sup>15</sup> УТА. Хм-А-1. Д-1. Хн-4. х.30-31, хуулга. Дурдсан бүтээл. 38.

болгохыг хэрэгсэхгүй болговоос ямар;

• гагцхүү Майдар бурхан залж эргүүлэх ёслолд хуучин удаагаар Нийслэлийн доторх бүхий олон хамба хутагт сайд ноёд түшмэдийг жагсаан бараа болж бусад дөрвөн их ёслолыг дөрвөн жасаа зохиож гүйцэтгүүлэх аль нэгнээр болгох гэж тодорхой санал дэвшүүлжээ.

Хууль зүйлийн бичгийн талаар авч хэлэлцсэн Улсын доод хурлын баримтаас үзвэл тус доод хурал нь асуудлыг хэлэлцэж, санал боловсруулан дээд хуралд өргөн мэдүүлэхээс бус эцсийн шийдвэр гаргаж байсангүй.

Улсын дээд хурал 1917 онд 9 удаа, 1918 онд 10 удаа хууль зүйлийн бичигт холбогдох асуудлыг хэлэлцэж, зохих шийдвэр гаргажээ. Үүнд, хууль зохиож буй сайд түшмэдээс ирүүлсэн хэргийг дараагийн хуралд хэлэлцүүлэхээр 6 удаа хойшлуулсан байх бөгөөд энэ нь хараахан учир битүүлэг тул залруулан ирүүлэх, хуралд саатал гарсан, тэргүүн сайдууд бүрдээгүйгээр янз бүрийн шалтгаанаас болжээ.

Дээд хурал хууль зохиох комиссын боловсруулсан төсөл, доод хурлын цохсон саналыг хянан үзэж, хянаваас зүйтэй тул ёсоор явуулбаас зохимуй, дахин хянан тогтоолговоос зохих тул эгүүлэн хүргэж гүйцэтгүүлбэ, нэг мөр болгон гүйцэтгэн шийтгүүлсгэй гэх зэргээр шийдвэрлэж байснаас гадна мөн өөрсдийн саналыг тусган, нэр дурдсан яамдад бичиг илгээж байв.

Ийнхүү дэвтр дэвтрээр нь хэлэлцсэн Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг 65 дэвтрийг 1919 онд эцэслэн дуусгасан бөгөөд Улсын хурлын газраас Дотоод яамнаа илгээсэн 1919 оны нэгэн бичигт “үүний урьд хүргүүлсэн шинэ хуулийн дэвтрийн дараах гучин дөрөвдүгээрээс дөчин наймдугаар хүртэлх, жич хүний амь, хулгай худлын зэрэг арван дөрвөн дэвтрийн залгамж жаран гуравдугаар, дөрөвдүгээр, тавдугаар эдгээр арван найман дэвтрүүдийг урьд ёсоор хянаж тэргүүн сайдуудтанаа толилуулан тогтоосны тулд эл дэвтрийг Дотоод яамнаа хүргүүлэн явуулаад түүгээр бичүүлэн ажаамуу. Үүний тул илгээв” хэмээжээ.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийг боловсруулах, хэлэлцэх, батлах, нийтлэх үйл ажиллагаа ийнхүү дууссан бөгөөд түүнийг хэзээ, хэрхэн дагаж шийтгүүлсэн хийгээд үйлчилж байсан эсэх тухай асуудалд судлаачид өнөө хэр бүрэн дүүрэн хариулт өгөөгүй байна.

Тухайлбал, түүхч Ц.Пунцагноров бүтээлдээ ...тэр комиссын ажиллагаа маш удааширсан бөгөөд тэдний бичсэн хуулиуд гарч амжаагүй байхад нь автономит засаг устгагджээ<sup>16</sup>, Оросын судлаач В.Н.Маркелов 1918

<sup>16</sup> Пунцагноров Ц. (1955) *Монголын автономит цэийн түүх* Уб, 108, Урангуа.Ж. (2006) *XX зууны эзлэн цэийн Монгол Улс (1911-1919)* Уб, 108.

онд гарч журамлагдаагүй гэх үндэстэй<sup>17</sup>. И.М.Майский Хууль зүйлийн бичиг маань монголын автономийг устгаснаар эдүгээ амьдралд хял тавьж амжаагүй байгаа<sup>18</sup> гэсэн нь хэрэг дээрээ үйлчлээгүй гэсэн санааг илэрхийлж байна.

Мөн Г.Совд энэ хууль нь тухайн үеийн улс орны дотоод, гадаад нөхцөл байдлыг тусгаж, системчлэн боловсруулсан хуулийн хувьд түүх, соёлын ихээхэн ач холбогдолтой боловч хүчин төгөлдөр хууль болон үйлчилж чадаагүй онцлогтой<sup>19</sup> гэжээ.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийг үйлчлэх хүртэл нийгмийн харилцааг Жинхэнэ дагаж явах хууль дүрмээр зохицуулж байсан<sup>20</sup> хэмээн судлаач Ж.Урангуа, Б.Баярсайхан нар бүтээлдээ тэмдэглэсэн нь 1918 он хүртэл Хууль зүйлийн бичгийг үйлчлээгүй гэж үзсэн бололтой.

Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар мөн Хууль зүйлийн бичгийг 1915-1918 оны хооронд боловсруулж дууссан учраас он цагийн эрхээр монголын нийгмийн амьдралд бүрэн утгаараа хэрэгжиж чадаагүй<sup>21</sup> хэмээн тэмдэглэжээ.

Ер нь Хууль зүйлийн бичгийг үйлчилж байсан эсэх тухайд судлаачдын байр суурийг авч үзэхэд дийлэнх хэсэг нь үйлчилсэн гэдэгт эргэлзэж буйгаа илэрхийлсэн байдаг. Харин Хууль зүйлийн бичгийг дагаж мөрдөж байсан хэмээн цөөн судлаач бүтээлдээ тэмдэглэжээ. Үүнд, судлаач Б.Содовсүрэн хууль зүйлийн бичгийн олонх хэм хэмжээ нь монголын хаант төрийн нийгмийн харилцаанд нэгэнт хэрэгжиж биелсэн учраас уг хэм хэмжээг эмхтгэлд оруулах замаар хуулийн тогтвортой хэлбэрт оруулсан өвөрмөц байдал ажиглагдаж байна<sup>22</sup> гэсэн бол судлаач О.Амархүү Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг 65 дэвтрээр бий болж, нийгмийн харилцааны тодорхой төрөл тус бүрээр “дэвтэр” хэмээн ангилагдан батлагдаж, үйлчилсэн хугацааны хувьд 1915-1920 оныг хамарсан<sup>23</sup> гэжээ.

Монгол Улсын Хууль зүйлийн бичгийг дэвтэр дэвтрээр нь боловсруулан хэлэлцэж, эцэст нь Богд хаанаар дэс дараалан батлуулж ирсэн түүхэн

<sup>17</sup> Мирский В.М. (1960) *Уголовное право МНР* М., 42. Дам шилэв

<sup>18</sup> Майский И.М. (2001) *Орчин үеийн Монгол (автономит Монгол XX зууны гарал дээр)* Орос хэлнээс орчуулсан Ц.Отгон. Уб, 331.

<sup>19</sup> Совд Г. (2005) *Монголын эрх зүйн түүхэн эх сурвалжийн товчоон. Газар, улсрлалга, эрх зүй (түүхээр өгчлэл)*. Уб, 371.

<sup>20</sup> (2004) Жинхэнэ дагаж явах хууль дүрэм (эх бичгийн судалгаа), галиглаж, үгийн хэллээ үндсэн, эх бичгийн судалга хийсэн Урангуа Ж, Баярсайхан Б, Уб, 43 дэх тал

<sup>21</sup> Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. (2011) *Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн үндэслэл. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл* Уб, 238.

<sup>22</sup> Содовсүрэн Б. (1989) *Хувьсгалын өмнөх монголын төр ба хууль цааз (1911-1920)*. Уб, 44.

<sup>23</sup> Амархүү О. (2009) *Монголын орчин цагийн экологийн эрх зүй. Нэмж засварласан хоёр дахь удаагийн хэвлэл* Уб, 91.



үйл явц, нөгөө талаар тухайн үеийн нийгмийн нөхцөл байдалтай уялдан гарч ирсэн эрхийн харилцааны ихэнх нь хэрэгжиж (зарим нь Хууль зүйлийн бичгийг батлахаас өмнө хааны шийдвэр, дүрэм, журмаар нэгэнт зохицуулагдаж байсан, зарим нь Хууль зүйлийн бичгийг баталсны дараа хэрэгжсэн) биелсэн зэргээс үзвэл ямар ч байсан Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг нь үйлчилж байсан нь лавтай.

Нөгөө талаар 1921 оны ардын хувьсгалаар гадаадын түрэмгийлэгчдийг улс орноосоо хөөн зайлуулж, төрийн тусгаар тогтнолоо сэргээж, Богд хааныг хэмжээт эрхт хаанд өргөмжилснөөр шинээр тунхаглагдсан Монгол төрийн тогтолцоо нь хүүчин нийгмийн эрх зүйн тогтолцоо хийгээд хууль тогтоомжийг тухайн түүхэн нөхцөл байдалдаа тохируулан халах, өөрчлөн хэрэглэх нь зүй ёсны асуудал байв.

Ийм ч учраас өмнө нэгэнт хэрэгжиж, нийгмийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг үе шаттай халах, өөрчлөх асуудлыг дэс дараатай авч хэрэгжүүлжээ.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийн бүтэц, тогтоомжийн онцлогоос шалтгаалан бүхэлд нь нэг удаагийн актаар бүрмөсөн халж хүчингүй болгож болохгүй<sup>24</sup> байсан бөгөөд энэ нь шинэ төрийн өмнө тавигдсан зорилттой ч нийцэж байв.

Судалгаанаас үзэхэд хууль зүйлийн бичиг дэх төрийн дээд, төв байгууллагуудын зохион байгуулал, эрх үүрэг, ноёд түшмэд, феодал язгууртны цол хэргэм, зэрэг дэв, эрх ямба, зарим алба татвар, цалин пүнлүү зэрэгтэй холбоотой зүйлүүдийг 1920-оод оны эхээр халсан бол дундуур ба сүүлчээр нь төрийн орон нутгийн ба шүүхийн байгууллага, гааль, түрээс, өртөө, ял шийтгэлтэй холбоотой зүйлүүдийг, 1930-аад оны эхээр засаг захиргааны хуваарь, өмч хөрөнгөтэй холбоотой зүйлүүд, дундуур ба сүүлчээр нь гэр бүл, сүм хийд, лам нар, шашны ёс журамд холбогдох зүйлүүдийг тус тус зонхилон халснаас<sup>25</sup> үзвэл Хууль зүйлийн бичгийн зарим хэм хэмжээ ардын хувьсгалаас хойш ч үйлчилж байсныг илтгэж байна.

## ДҮГНЭЛТ

XX зууны эхээр Монголчууд Манж Чин Улсын олон жил үргэлжилсэн ноёрхлыг унагаж, төрийн тусгаар тогтнолоо сэргээн, Богд хааныг шашин төрийн төргүүнээр өргөмжилсөн бөгөөд тусгаар тогтнолоо олон улсад хүлээн зөвшөөрүүлэх олон чухал зорилт дэвшүүлж байсны нэг нь өөрийн

<sup>24</sup> Дашням И. (2002) *Монгол оронд дундад үеийн эрх зүйн тогтолцоог халж, шинэ үеийн эрх зүйн актыг тогтолцоо бүрэлдэн тогтсон нь (1921-1940)*. Ув, 22.

<sup>25</sup> Дашням И. Дурдсан бүтээл, 23.

үндэсний хуультай болох явдал байв.

Энэ үндсэн дээр Манжийн эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжийг шат дараатайгаар халж, тухайн үеийн эрдэмт түшмэдийн бүрэлдэхүүн бүхий хууль зохиох комисс, Улсын дээд, доод хурал, олон яамдын оролцоотойгоор Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг 65 дэвтрийг боловсруулан хэлэлцэж, Богд хаанаар батлуулснаар XX зууны Монголын эрх зүйн хөгжлийн үндэс суурийг, мөн монголын хууль тогтоомжийн шинэтгэлийн эхлэлийг ийнхүү тавьжээ.

Монголчууд 1911-1919 онд Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичгийг хэлэлцэн баталж, дагаж мөрдүүлснээр тухайн үед ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭТГЭЛИЙГ бүрэн утгаар нь хэрэгжүүлж чадсан төдийгүй үүгээр Монгол Улсад ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭТГЭЛИЙН ЭХНИЙ АЛХАМ 1911 онд тавигджээ.

○○○○○

○○○○○

○○○○○

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХАМГААГАХ  
WWW.NLI.GOV.MN

## БНХАУ-ын “нэг улс-хоёр систем” дэх эрх зүйн онцлог асуудал

ХЗҮХ-ийн Олон улсын эрх  
зүйн секторын эрдэм  
шинжилгээний ажилтан,  
магистр (LLM) Б.Энх-Амгалан



2012 оны 3 дугаар сард хуралдсан Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн их хурал (БХАТИХ)-д БХАТИХ-ын тэргүүлэгч У Бан Гуо “Хятадын эдийн засаг өрнөдийн замаар хөгжихгүй, харин өөрийн онцлогийг тусгасан социалист хувилбараар замнаа” хэмээн мэдэгдсэн. Энэ нь Хятадын түүхэн удирдагч Дэн Сяо Пиний үзэл номлолын залгамж илэрхийлэл боллоо.

Дэн Сяо Пиний “Хятадын онцлогтой социализм” байгуулах онолын чухал хэсэг нь “Нэг улс-хоёр систем”-ийн онол. Тэрээр хэлэхдээ “Манай социалист тогтолцоо бол Хятадын онцлогтой социалист тогтолцоо, энэхүү онцлогийн нэгэн чухал агуулга нь Хонконг, Макао, Тайваний асуудлыг шийдвэрлэх “Нэг улс-хоёр систем” юм. Энэ бол шинэ зүйл. Үүнийг Америк гаргаж ирээгүй, Япон гаргаж ирээгүй, Европ мөн гаргаж ирээгүй, түүнчлэн Зөвлөлт Улс гаргаж ирээгүй. Харин Хятад Улс гаргаж тавьснаараа энэ бол Хятадын онцлог” хэмээсэн байдаг.<sup>1</sup>

### ТОДОРХОЙЛОЛТ<sup>2</sup>

“Нэг улс-хоёр систем” гэдэг нь “Нэг улсад хоёр төрлийн систем оршин байх” гэсэн утгын товчлол бөгөөд Хятадын удирдагч асан Дэн Сяо Пиний Хятад нэгдмэл улс байх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс

<sup>1</sup> “Дэн Сяо Пиний түүвэр зохиол” III боть, 218.

<sup>2</sup> <http://baike.baidu.com/view/20523.htm-эс> дэмсгүүж уншина уу.

дэвшүүлсэн үзэл санаа ба Хонконг, Макао гэсэн тусгай захиргааны хоёр бүст хэрэгжсэн төдийгүй, өнөөгийн байдлаар Хятадын Засгийн газраас Тайванийн асуудалд баримталж буй гол бодлого юм.

1982 онд батлагдсан “БНХАУ-ын Үндсэн хууль”-ийн 31 дүгээр зүйлд Тусгай захиргааны бүсийн талаар тусгайлсан зохицуулалтыг хийснээр “Нэг улсад хоёр төрлийн систем оршин байх” зарчмыг суурь хуульд тусгаж, “Нэг улс- хоёр систем”-ийн үзэл сэтгэлгээ албан ёсоор хэлбэржсэн. 1984 оны 5 дугаар сард БХАТИХ —ийн 6 дахь сонгуулийн II чуулганд хэлэлцсэн “Засгийн газрын үйл ажиллагааны тайлан”-д “Нэг улс-хоёр систем”-ийн онолыг дэвшүүлж батлуулснаар “Нэг улс-хоёр систем” хууль зүйн хүчин чадал бүхий бодлого болжээ.

“Нэг улс-хоёр систем”-ийн дагуу төр засаг социалист тогтолцоог баримталж, Хонконг, Макао нь Хятадын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тусгай захиргааны бүс болохын хувьд хуучин байсан капиталист тогтолцоо болон амьдралын хэв маягийг өөрчлөхгүйгээр урт удаан хугацаагаар хөгжин дэвжихэд үндсэн учир оршино.

### “НЭГ УЛС-ХОЁР СИСТЕМ” ДЭХ ХЯТАДЫН ЭРХ ЗҮЙ

1997 оноос хойш Хятадад эрх зүйн өөр өөр тогтолцоо оршин байгаа нь Хятадын эрх зүйн шинэ онцлог болсон. Хятад-Их Британи, Хятад-Португалийн хоорондын тохиролцоо ёсоор Хятадын Засгийн газар 1997 онд Хонконг, 1999 онд Макао-г эргүүлэн авч, тусгай захиргааны бүсийг тус тус байгуулсан. Ингэхдээ “Нэг улс-хоёр систем”-ийн онолын дагуу эх газрын социалист эрх зүйн системийг хэвээр хадгалахын зэрэгцээ тусгай захиргааны бүсийн өөрийн эрх зүйн тогтолцоог халалгүйгээр хамтдаа оршин тогтнох болсноор “Нэг улс-хоёр систем” дэх Хятадын эрх зүйн хөгжил, шинэчлэлийн асуудал гарч ирсэн юм. Хонконгийн эрх зүйн Англи-Саксоны эрх зүйн бүлд, харин Макогийн эрх зүй нь эх газрын эрх зүйн бүлд хамаардаг.

“Нэг улс-хоёр систем” тогтолцооны Хятадын эрх зүйд оруулсан томоохон өөрчлөлтийг томъёолж үзвэл:

1. Эрх зүйн нэг тогтолцоо оршиж байсныг өөрчилж, нэг улсын дотор өөр өөр эрх зүйн бүлүүд оршин байх нөхцөлийг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл, Хонконг, Макогийн хуучин хууль тогтоомжийг хэвээр үлдээсэн төдийгүй тэдгээр нь өөрсдийн эдийн засаг, улс төр, соёлыг хөгжүүлэх зорилгоор хууль батлах эрхтэй. Ингэснээр тус бүр өөрийн бие даасан эрх зүйн тогтолцоотой, батлан гаргасан хуулиуд нь хэдийгээр суурь хууль боловч Хятадын эрх зүйн системийн бүрдэл хэсэг мөн болдог;

2. Тэрбум гаруй хүн амтай эх газрын Хятадад социалист эрх зүйн систем үйлчилж байгаа бол тусгай захиргааны бүст тэдгээрийн хуучин эрх зүй үйлчилсээр байгаа;

3. Тусгай бүс эрх зүйн тогтолцооны хувьд Хятадын үндсэн эрх зүйн тогтолцооны нөлөө ба хязгаарлалтад байсаар байна гэж үздэг. Баталсан Үндсэн хуулийн заалтыг удирдлага болгон БХАТИХ-аас баталсан тусгай захиргааны Үндсэн хууль<sup>1</sup>-тай тусгай захиргааны бүсээс баталсан аливаа хууль тогтоомж зөрчилдөх ёсгүй;

Дүгнэхэд "Нэг улс-хоёр систем"-тэй Хятадын эрх зүй нь эх газрын Хятадын социалист эрх зүйн тогтолцоо голлосон өөр эрх зүйн тогтолцоо холмдож, зэрэгцэн оршсон онцлог тогтолцоо болон хувирсан. Ийнхүү харьяалагдах эрх зүйн бүлийн хувьд өөр өөр бүлийн онцлогийг хадгалсан "Хятадын онцлогтой социалист эрх зүйн тогтолцоо" үүссэн юм.

## "НЭГ УЛС-ХОЁР СИСТЕМ" ДЭХ ХЯТАДЫН ЭРХ ЗҮЙН ОНЦЛОГ

Дээрх байдлын нөлөөгөөр Хятадын эрх зүйд дараах онцлог асуудал бүрэлдсэн. Эдгээрийг тоймлоход:

- Нэг. "Нэг улс-хоёр систем" дэх хууль тогтоох онцлог;
- Хоёр. "Нэг улс-хоёр систем" дэх эрх зүйн эх сурвалжийн онцлог;
- Гурав. "Нэг улс-хоёр систем" дэх хууль тайлбарлах онцлог;
- Дөрөв. "Нэг улс-хоёр систем" дэх хуулийн хэрэглээний онцлог;

*Нэг. "Нэг улс-хоёр систем" дэх хууль тогтоох онцлог.*

Энэхүү асуудалд нэгдмэл нэг улсын нийтлэг зарчмын үүднээс хандахын сацуу "хоёр систем"-ийн шаардлагыг хангах хэрэгтэй болсон. Иймээс "Хонконгийн тусгай захиргааны бүсийн Үндсэн хууль"-д тусгай захиргааны бүс нь хууль тогтоох эрхтэй болохыг заасан байдаг. Энэ нь хэдийгээр хууль тогтоох эрх мэдлийн асуудал мэт боловч төв болон орон нутгийн хоорондын харилцааны асуудлыг мөн хөндсөн. БНХАУ-ын Үндсэн хуульд заасны дагуу БХАТИХ ба түүний Байнгын хороо төрийн хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг бол орон нутгийн эрх бүхий байгууллага зөвхөн орон нутгийн чанартай тогтоол, дүрэм гаргадаг. Харин "Хонконгийн тусгай захиргааны бүсийн Үндсэн хууль"-д зааснаар Хонконгийн тусгай захиргааны бүс нь хууль тогтоох эрхтэй. Энэ бол тус бүсийн өөрийн удирдлагын чухал хэсэг бөгөөд энэхүү хууль тогтоох

<sup>1</sup> "Хонконгийн тусгай захиргааны бүсийн Үндсэн хууль" 1990 онд баталгааж, 1997 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. "Макаогийн тусгай захиргааны бүсийн Үндсэн хууль" 1993 онд баталгааж, 1999 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

эрх нь шинэ ойлголт юм. Өөрөөр хэлбэл энэхүү эрх нь хууль тогтоох хамгийн дээд эрх биш бөгөөд орон нутгийн захиргааны байгууллагын дүрэм журам гаргах эрхээс бас өөр. Үүнийг Хятадын эрдэмтэн судлаачид хятадын эрх зүйн онцлог төдийгүй хятадын бас нэгэн нээлт хэмээн үзэж байна.

*Хоёр. "Нэг улс-хоёр систем" дэх эрх зүйн эх сурвалжийн онцлог*

Хятадын Үндсэн хууль ба бусад холбогдох хуульд заасны дагуу эрх зүйн эх сурвалж нь Үндсэн хууль, хууль, хэм хэмжээний акт, орон нутгийн шинжтэй захиргааны акт гэсэн төрөлтэй байна. Харин Хонконгийн тусгай захиргааны бүсийн эрх зүй нь БНХАУ-ын Үндсэн хуулийг үндэслэн баталсан Хонконгийн Үндсэн хууль, Хонконгийн тусгай захиргааны бүсийн баталсан хууль, өмнө байсан хууль, дүрэм журам, хэвшүүлсэн эрх зүйн хэм хэмжээ, заншлын эрх зүйгээс бүрддэг. Макаогийн тусгай захиргааны бүсийн тухайд БНХАУ-ын Үндсэн хуулийг баримтлан баталсан Макаогийн тусгай захиргааны бүсийн Үндсэн хууль, тус тусгай бүсээс баталсан хууль, өмнө байсан хууль, тогтоол, захиргааны хэм хэмжээний акт, бусад зохицуулах баримт бичгүүдийг багтаасан.

Эдгээрээс харахад "Нэг улс хоёр систем" дэх эрх зүйн эх сурвалж нь нэгдмэл боловч бас бие даасан, олон шатлалт, олон төрөлт, эх сурвалжийн бүтцээс харахад хууль тогтоомжоос гадна хэвшүүлэн хэрэглэх хэм хэмжээ, заншлын эрх зүй мөн багтаж байна. Энэ нь агуулгын хувьд баялаг хэрнээ ярвигтай, эрх зүйн эх сурвалжийн олон төрлийг бүрдүүлж байна.

*Гурав. Хууль тайлбарлах онцлог*

Хятадад БХАТИХ ба түүний Байнгын хороо нь Үндсэн хууль ба бусад хуульд тайлбар хийх эрхтэй бөгөөд хуулийн дээд шатны байгууллага хууль хэрэглэх явцдаа мөн тайлбар хийж болно. Дээд шатны захиргааны байгууллага, түүний яамд захиргааны хэм хэмжээний актад тайлбар хийдэг. Орон нутгийн захиргааны байгууллага орон нутгийн шинжтэй захиргааны актад тайлбар хийж болно. Харин Хонконгийн тусгай захиргааны бүст зөвхөн шүүхийн тайлбар байдаг. Энэ тохиолдолд Хонконгийн Үндсэн хуульд заасны дагуу хууль тайлбарлах асуудалд дараах зохицуулалт хийгдсэн. Үүнд:

Хонконгийн Үндсэн хуулийг тайлбарлах эрхийг БХАТИХ-ын Байнгын хороо эдэлнэ. Гэхдээ тайлбар хийхийн өмнө аль болох Хонконгийн бодит нөхцөл байдал ба тэдний хүсэл зоригт нийцүүлэх үүднээс Хонконгийн Үндсэн хуулийн хорооноос саналыг хүлээн авсан байна.

БХАТИХ-ын Байнгын хороо нь Хонконгийн шүүх Үндсэн хуулийнхаа тухайд өөрийн тусгай захиргааны бүсийн удирдлагын хүрээний зүйл заалтад шууд тайлбар хийх эрх олгодог.

Хонконгийн тусгай захиргааны бүсийн шүүх хэргийг шийдвэрлэхдээ өөрийн үндсэн хуулийн зүйл заалтад тайлбар хийж болно. Гэхдээ Үндсэн хууль дахь төв Засгийн газрын удирдлагын ажил үүрэг эсхүл төв захиргаа ба Хонконгийн тусгай захиргааны бүсийн хоорондын хамааралтай зүйл, заалтад тайлбар хийх шаардлагатай тохиолдолд, түүнчлэн тэрхүү зүйл, заалт хэргийг шийдвэрлэхэд нөлөөтэй бол давж заалдах эрхгүй эцсийн шийдвэр гарахаас өмнө Хонконгийн дээд шатны шүүхээс БХАТИХ-ын Байнгын хороонд хандаж тайлбар авна.

Ерөнхийдөө, Хонконгийн шүүх хэргийг шийдвэрлэхдээ Хонконгийн хууль тогтоох байгууллагаас баталсан хууль ба өмнө байсан хуулийг тайлбарлах эрхтэй. Гэхдээ Үндсэн хуультайгаа зөрчилдөх ёсгүй.

Макаогийн захиргааны тусгай бүсийн хувьд хууль тайлбарлахад Хонконгоос болон Эх газрын Хятадаас ялгаатай. Гэхдээ Макаогийн Үндсэн хуульд Хонконгийн Үндсэн хуультай адил зохицуулалтыг хийсэн байдаг.

- "Нэг улс хоёр систем" дэх хуулийн хэрэг. 13-ийн онцлог

Мөн л эрх зүйн өөр өөр бүл, өөр өөр тогтолцооны асуудлаас болоод хууль хэрэглэхэд асуудал тулгарсан. Хамгийн чухал нь Үндсэн хуулийн асуудал юм. БНХАУ-ын Үндсэн хуулийг тусгай захиргааны бүст хэрэглэх үү гэдэг асуудал яригдсан. Эрх зүйн онолын хувьд аливаа улсын Үндсэн хууль гэдэг утгаараа тухайн улсын нэгдмэл байдлын бэлгэ тэмдэг болдог. Үндсэн хуулийг хэрэглэх асуудал бүх улс орон даяар нийтээр дагаж мөрдөх асуудал болно. Харин "Нэг улс-хоёр систем"-ийн хувьд БНХАУ-ын Үндсэн хууль тусгай бүст үйлчлэх асуудал БНХАУ-ын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйл заалт<sup>4</sup>-аар хязгаарлагдах уу гэдэг асуудал гол зангилаа юм. Мөн эрх зүйн өөр тогтолцооноос хамаараад, тусгай захиргааны бүст социалист тогтолцооны бодлого зохицуулалт бүхэлдээ тохирохгүй, түүнчлэн "нэг улс-хоёр систем"-ийн зарчмаар бол тусгай захиргааны бүс нь хуучин капиталист тогтолцоогоо хэвээр хадгалах ёстой. Эндээс Үндсэн хуулийн зарим заалт бас хэрэглэгдэхгүй юм. Энэ нь онолын төдийгүй практикийн асуудал болно. "Нэг улс-хоёр систем"-ийн зарчмыг үндэс болговол БНХАУ-ын Үндсэн хуулийг бүхэлдээ тусгай бүст хүчин төгөлдөр байхын зэрэгцээ зарим зүйл заалтыг

<sup>4</sup> БНХАУ-ын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйл. Төрөөс шаардлагатай үед тусгай захиргааны бүсийг байгуулж болно. Тусгай захиргааны бүс дотор хэрэгжүүлэх тогтолцог бодит нөхцөл байдлыг харгалзан, БХАТИХ-аар хууль заасны дагуу бүрдүүлнэ.

бас хэрэглэж болохгүйг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Энэ бол БНХАУ-ын Үндсэн хууль ба тусгай бүсийн Үндсэн хуулийг баримтална гэсэн ойлголт. БНХАУ-ын Үндсэн хуулийг баримтлан БХАТИХ-аас БНХАУ-ын тусгай захиргааны бүсийн Үндсэн хуулийг баталж, тусгай захиргааны бүсийн тогтолцоо, үндсэн бодлого, чиглэлийг баталгаажуулна. БНХАУ-ын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн агуулгаар тусгай захиргааны бүсийн тогтолцоо, үндсэн бодлого, чиглэл нь нийгэм, эдийн засгийн тогтолцоо, оршин суугаа иргэдийн үндсэн эрх, эрх чөлөө, засаг захиргааны удирдлага, хууль тогтоох ба хуулийн байгууллагын тогтолцоо зэрэгт тусгай захиргааны бүсийн Үндсэн хуулийг хэрэглэнэ. Энэ нь БНХАУ-ын Үндсэн хууль нь тусгай бүсийн Үндсэн хуулийн хууль зүйн үндэслэл болох үүднээс БНХАУ-ын Үндсэн хуулийн дээд хүчин чадлыг илтгэхийн зэрэгцээ тусгай бүст Үндсэн хуулийн зарим зүйл, заалтыг хэрэглэхгүй гэдэг талаас нь ярихад тусгай захиргааны бүсийн Үндсэн хуулийн хууль зүйн хүчин чадлыг бас илтгэх уян хатан ойлголт юм.

## ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүлээр “Орчин үеийн Хятадын эрх зүйн онцлог”-т “Нэг улс-хоёр систем” дэх эрх зүйн онцлог асуудал багтаж байгааг тодорхойлж бичлээ. Нэг хөгжлийг нөгөөгөөр сольж нураалгүй нэгдмэл хөгжилд хүрэх үзэл санааг олж дэлгэрүүлсэн “Нэг улс-хоёр систем”-ийн онол Хятадын эдийн засгийн хөгжилд өндөр ач холбогдол өгсний гол түлхүүр нь “Нэг улс-хоёр систем” дэх эрх зүйн зохицуулалт мөн бөлгөө.

○○○○○

○○○○○

○○○○○



**Хил дамнаж хэрэглэгчтэй байгуулсан цахим хэлбэр бүхий  
гэрээний маргаанд шүүхийн харьяаллыг нэгдмэл байдлаар  
тогтоох боломж\***

**Япон Улсын Кюсюгийн их сургуулийн,  
Хууль зүйн сургуулийн төгсөгч,  
магистр (LLM) Хуо Шу И**

---



*Товч агуулга*

Интернэтийн хил хязгааргүй хэрэглээ нь аливаа бизнесийг дэлхийн өнцөг булан бүрт буй хэдэн сая хэрэглэгчид хүргэх бололцоо олгодог. Тэр тусмаа дэлхийн зах зээлд бага зардлаар нэвтрэн орох боломж, нөхцөлийг бүрдүүлдэг тул онлайн бизнесийг өөрсдийн бизнесийн эхлэл болгон ашиглах нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд татгалзаж болшгүй боломж байдаг. Бараа, үйлчилгээ худалдах, худалдан авах асуудлыг багтаасан цахим арилжаа ирээдүйд улам эрч хүчээ авах нь эргэлзээгүй. Эдгээр олон давуу талын хажуугаар эрх зүйн хувьд тодорхой бус, цаашид хэлэлцэх шаардлагатай олон асуулт урган гарч байгаа юм. Онлайнгаар бизнес эрхлэхэд тулгарч буй нэг бэрхшээлтэй асуудал нь маргаан шийдвэрлэх шүүхийн харьяалалын асуудал билээ. Газар зүйн хил хязгаарыг баримтлан шүүхийн харьяалал тогтоодог үндсэн бөгөөд уламжлалт үзэл баримтлалыг Интернэт эргэлзээтэй, будлиантай болгож байна. Улам хөгжиж байгаа технологийн хурдтай нийцүүлэн шүүхийн болон хэрэглэх хуулийг сонгох асуудлаа янз бүрээр өөрчлөх зэргээр уас орнууд

\* Энэхүү өгүүллийг ХЗҮХ-гийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр (LLM) Н.Минхтуяа англи хэлнээс хөрвүүлэв.

оригинал хийх, зүйн харилцаа гаргаж байгаа нь үнэг. Хил дамнасан бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн харилцаанд (B2C) цахим худалдааны хэлцэл хийхэд шүүхийн харьяаллыг нэгдмэл байдлаар тогтоох талаар хэд хэдэн эрх зүйн санаачлага гарч байжээ. Гэвч энэ асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй. Иймд энэ өгүүлэлдээ хэрэглэгчийг хамгаалах, эрх зүйн тодорхой байдал бий болгох талаар B2C харилцаанд хэрэглэгдэх цахим худалдааны эрх зүйн зохицуулалтаараа амжилт гаргасан буюу дэлхийд цахим зах зээлээрээ тэргүүлж байгаа АНУ болон Европын Холбооны туршлагад дүн шинжилгээ хийснээ толилууля.

*Гол хэрэглэгдэж буй нэр томъёо*

B2C (бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн харилцаа), Internet Jurisdiction (интернэтийн хууль тогтоомж), Consumer Contracts (хэрэглэгчтэй байгуулсан гэрээ), Electronic Commerce (цахим худалдаа), Consumer Protection (хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах), Legal Certainty (хууль зүйн тодорхой байдал)

## ОРШИЛ

*Урьдчилан тааварлаж болохуйц байдал болон уян хатан байдлын хэрэгцээ*

Цахим худалдааны харилцааг даяарчлан хөгжүүлэхэд шүүхийн харьяаллыг урьдчилан тааварлаж болохуйц, тохиромжтой байдлаар гэрээнд тусгах нь чухал. Одоогоор олон улсын эрх зүйд хэрэглэгч өөрийн харъялал (home forum)-ын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж чаддаггүй. Олон улсын хувийн эрх зүйн урьдчилан тааварлаж болохооргүй энэхүү мөн чанар нь харгалзан үзвэл "ероол руу унагах" буюу шударга бусаар бизнесээ эхлүүлэх тулгарах тул шүүхийн харьяаллын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болно.<sup>1</sup> Гэхдээ энэ бол нэг талд ашигтай эсвэл үр дүнг нь тооцоолоогүйгээр асуудалд хандана гэсэн үг биш юм. Жишиг эрх зүйг хэрэглэдэг АНУ-ын хувьд энэ асуудлыг шийдвэрлэхдээ олон нийтээрээ хамтран шүүхэд нэхэмжлэл гаргах (class action suit) боломжийг нь хязгаарлах үүднээс хэрэглэгчтэй байгуулж буй гэрээнд тухайн хэрэглэгч өөрөө хэрэглэх хуулиа сонгох эсвэл сонголт хийхээс өмнө ямар хууль хэрэглэх, аль улсын шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх боломжтой байгааг ойлгуулсан байдлаар гэрээний заалтыг арижааны байгууллагууд анхнаасаа зорилготойгоор оруулдаг.<sup>2</sup> Цахим гэрээний мөн

<sup>1</sup> LORNA E. GILLIES, ELECTRONIC COMMERCE AND INTERNATIONAL PRIVATE LAW-A STUDY OF ELECTRONIC CONSUMER CONTRACTS (Ashgate Publishing Limited 2008).

<sup>2</sup> Vaden v. Discover Bank, 396 F.3d 366, (4th Cir. 2005).

чанаараас үүдэлтэй эдгээр бэрхшээл болон шүүхийн харьяалал, хэрэглэх хуулийг тогтооход төвөгтэй байгаа байдал зэргээс үзвэл эрх зүйг хооронд нь уялдуулах онцгой шаардлага байгааг харуулж байна. Хэлэлцээр хийгч талууд хоорондоо тохиролцоход тэнцвэргүй түвшинд байгаа байдал, цахим зах зээлийн үсрэнгүй хөгжил зэргийг бодохоор ийнхүү уялдуулах ажил амаргүй байх нь ойлгомжтой. Арай энгийнээр аваад үзэхэд, урьдчилан таамаглаж болохуйц байдлыг бий болголоо гэхэд В2С харилцаан дахь цахим худалдааны гэрээний талаар өөр хоорондоо уялдсан, түгээмэл шинжтэй дүрэм, журам бий болох юм. Олон эрдэмтэд, судлаачдын судлагаагаар ийнхүү уялдуулан нийцүүлэх нь их ач холбогдолтой хэмээн хүлээн зөвшөөрч, энэ ажлын чухлыг онцолсон байна. Тухайлбал, олон улсын хувийн эрх зүйн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байсан уламжлалт онолуудын талаар тэр дундаа "партикуляризм" буюу нэг зүйлийг тухайлан авч үзэх болон "юниверсализм" буюу ерөнхийлөн авч үзэх онолын талаар эрдэмтэн Лорны И.Геллис тэмдэглэхдээ "цахим худалдааны гэрээнд хэрэглэх хууль, маргаан гарсан тохиолдолд маргаанаа шийдвэрлүүлэх шүүхийн харьяаллыг тогтоох журмыг хөгжүүлэхэд "партикуляризм"-ын онолыг үргэжлүүлэн хэрэглэх нь одоо нэгэнт цагаа өнгөрөөжээ" хэмээсэн байдаг.<sup>1</sup> Онлайнаар хийж буй хэрэглэгчийн гэрээнд янз бүрийн, уян хатан биш, үндэсний хэмжээнд хэрэглэдэг арга замудаас илүүтэй хоорондоо нягт тодорхой байдлаар уялдсан журам нэн шаардлагатай байна. Учир нь даяаршсан, хүрээ хязгаар нь тодорхой биш зах зээлд орж үйл ажиллагаа явуулахаасаа өмнө бизнесийн тооцоо хийж, тодорхой зохицуулалтын горим, журмыг тогтоохыг хүсэхийн зэрэгцээ хууль зүйн хувьд тодорхой байдлыг маш өндөр түвшинд хангасан хэрэглэгчдийн сэтгэл ханамж, итгэлийг төрүүлэх нь бизнес эрхлэгчдэд юу юунаас чухал болсон.

*Одоо байгаа хууль тогтоомжжоо шинэчлэн өөрчлөх замаар хэрэглэгчтэй байгуулж буй цахим гэрээний эрх зүйн хэм хэмжээг уялдуулах ажлын цндсийг тавих нь*

Фосетт, Харрис болон Бридж нар цахим худалдааны орчинд хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээний шинэчлэл, түүнийг боловсронгуй болгох 3 загварыг тодорхойлсон байдаг. Эдгээр загварт "1-рт шүүхэд хуулийг боловсронгуй болгох үүргийг оногдуулж, ердийн эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, 2-рт ердийн эрх зүйн хэм хэмжээг төрөлжүүлэх байдлаар хуулийг шинэчлэн өөрчлөх, 3-рт цахим худалдааны хэрэгт хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээний тусгай дэглэмийн төсөл боловсруулах

<sup>1</sup> Gillies, мөн тэнд 4 дүгээр ишлэл, 50 х.

замаар хуулийг шинэчлэх"<sup>4</sup> зэрэг орно.

Эдгээр гурван загвар нь хил дамнасан цахим худалдааны эрх зүйн ээдрээ төвөгтэй байдлыг зохицуулахад тэр бүр үр өгөөжтэй байж чаддаггүй. Эхний загварын хувьд шүүхэд хуулийг тайлбарлах, хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэснээр эргээд тэрээр хуулийг шинэтгэх, хөгжүүлэх, боловсронгуй болгох ажлыг төвөгтэй болгосон. Үүний үр дүнд тодорхойгүй байдал үүсч, хууль хэрэглэх талаар нэгэн хэвийн бус, эргэлзээтэй байдал бий болж байгаа юм. Эрх зүйн шинэтгэл хийх, хуулийг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулахад шүүхийн зүгээс боломж бололцоотой байсан ч гэсэн ийнхүү боловсронгуй болгох ажлыг хийх нь хугацаа шаардсан, үр өгөөж багатай ажил болох магадлал их. Энэ байдал "шүүхэд хуулийг боловсронгуй болгох үүрэг ногдуулсан"<sup>5</sup> АНУ-ын жишиг эрх зүйд маш сайн туссаныг харуулах бөгөөд бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн харилцаан дахь цахим худалдааны асуудлуудыг дээд шүүхээс тогтоосон жишиг эрх зүйгээс ангид байдлаар шийдвэрлэхдээ шүүх бүр янз бүрийн хандлага баримталж улмаар урьдчилан тааварлаж бодохуйц байх тэр зарчим үгүйсгэгдэнэ. Гуравдахь загвар нь "цахим худалдаатай холбоотой хэрэг маргаанд хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээний тусгай дэглэм"<sup>6</sup> ийн төслийг санал болгодог. Энэ загварын хувьд тулгарч буй бэрхшээлтэй асуудал бол харилцаа холбоонд гарч буй шинэ технологиудыг цахим худалдаанд ашиглах боломжгүй байдалд хүргэдэгт оршино. Эрх зүйн шинэ дэглэмийг бий болгох нь хялбар зохицуулалт байх боловч түүний хөгжил нь технологийн үсрэнгүй хөгжлийг гүйцэхгүй, түүний ард байсаар байх болно. Нэмж хэлэхэд, интернеттэй холбоотойгоор бий болж буй технологийн нарийн төвөгтэй, үсрэнгүй хөгжиж байгаа дэвшлийг гүйцэн интернет орчинг зохицуулах, харьяаллыг тогтоох, хэрэглэх хуулийн асуудлыг шийдвэрлэх зэрэг нь үнэндээ боломжгүй бас маш хэцүү ажил гэдэг нь ойлгомжтой. Кибер орон зайн харьяаллын асуудлыг шийдвэрлэхийн тулд зайлшгүй биелүүлэх үүрэг хүлээлгэсэн дүрэм, журам тогтоох оролдлогыг Америкийн Баарын Холбооноос ажил хэрэг болгон эхлүүлж, уг орон зайг бий болгож буй технологийг тайлбарлах, зохицуулахыг чармайсаар байна.<sup>7</sup> Тус Холбооноос авч хэрэгжүүлж буй ажлын хүрээнд шүүхээс батлагдаагүй, албан ёсны болоогүй байгаа, технологийн шийдлийг ашигласан, үсрэнгүй хөгжсөн техникийн нэр

<sup>4</sup> J.J. FAWCETT ET AL., INTERNATIONAL SALE OF GOODS IN THE CONFLICT OF LAWS 589 (Oxford University Press 2005).

<sup>5</sup> Дээрхтэй адил.

<sup>6</sup> Дээрхтэй адил.

<sup>7</sup> ACHIEVING LEGAL AND BUSINESS ORDER IN CYBERSPACE: A REPORT ON GLOBAL JURISDICTION ISSUES CREATED BY INTERNET, THE BUSINESS LAWYER, VOL.55, (2000), [http://works.bepress.com/cgi/viewcontent.cgi?article=1000&context=margaret\\_stewart](http://works.bepress.com/cgi/viewcontent.cgi?article=1000&context=margaret_stewart)

томъёог тайлбарлах ажлыг идэвхитэй өрнүүлжээ.

Практикт хэрэглэж буй дүрэм журмаа шинэчлэн өөрчлөх замаар шинэтгэл хийх нь илүү үр дүнтэй бас биелэгдэж болохуйц явдал байж болох бөгөөд энэ тал дээр зөвшилцөлд хүрэх нь тийм ч хүнд биш юм хэмээн эрдэмтэд санал, бодлоо солилцсон байдаг.<sup>8</sup> Хэдийгээр эрдэмтэд ийнхүү санал нэгдэж байгаа ч энэ өгүүллийнхээ хүрээнд дурдсан загваруудаас хоёр дахь загвар нь цахим хэлбэрээр хэрэглэгчтэй байгуулж буй гэрээнийн хувьд хэрэглэх уян хатан, хоорондоо уялдаа бүхий хуулийн талаарх хамгийн үр дүнтэй сайн загвар хэмээн батлахыг зорьлоо. Өөрөөр хэлбэл, Европын Холбооноос баталсан Брюссель I Журам болон олон улсын хувийн эрх зүйн асуудлаар хийгдсэн Гаагийн хэлэлцээрийн зорилготой миний нотолгоо нийцэж байгаа юм. Дээрх хэлэлцээрүүдэд оролцож буй улс гүрнүүд нь практикт хэрэглэгдэж байгаа хэрэглэх хуулиа сонгох журмын талаар өөрчлөлт шинэчлэл хийхээр “партикуляризм”-аас зайлсхийх, өөр хоорондоо эрх зүйгээ уялдуулах талаар зөвшилцөлд хүрэхийг эрмэлзэн нэгэн чигт тэмүүлж эхэлсэн. Хэдийгээр уян хатан хэм хэмжээ бий болгох талаар хийгдэж байсан Гаагийн хэлэлцээрүүдийн чармайлт амжилтад хүрч чадаагүй ч үр ашгийг, жам ёсоороо хөгжих бололцоотой, даяаршсан, онлайн буюу цахим зах зээлийг бий болгоход тулгарч буй эрх зүйн асуудлыг шийдвэрлэх арга зам бол бодит байдалд хэрэглэж байгаа тухайн харилцаанд хэрэглэх хуулийг сонгох, шүүхийн болон бусад хэрэглэх хуулийн харьяаллын асуудлыг хоорондоо уялдсан, түгээмэл шинж чанартай хэм хэмжээгээр зохицуулах нь зүйтэй хэмээн үзэж байна.

## НЭГ. ЭРХ ЗҮЙН УЯН ХАТАН, ХООРОНДОО НИЙЦСЭН БАЙХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЧАРМАЙЛАТ-ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДЛААР ГААГИЙН ХУРЛУУД (Hague Project)

“Гарын үсэг зурсан улс орнуудын хувьд нийтлэг хэрэглэгдэх харьяаллын журмыг бий болгох”<sup>9</sup> талаар олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хийсэн хүчин чармайлтын хамгийн анхны оролдлого нь “Иргэний болон арилжааны хэргийн асуудлаар гадаадын шүүхийн шийдвэр, маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тухай” Гаагийн конвенц (цаашид Гаагийн конвенц гэх) байсан. Гаагийн конвенцийг анх 1992 онд

<sup>8</sup> Cillies, мөн тэнд 4 дүгээр ншил.

<sup>9</sup> Олон улсын хувийн эрх зүйн тухай Гаагийн хурал, Иргэний болон арилжааны асуудлаарх гадаадын шүүхийн шийдвэр болон шүүхийн харьяаллын тухай конвенцийн анхны төсөл (Тусгай Комиссоос 10/30/1999 баталсан).

АНУ санаачилсан бөгөөд янз бүрийн харьяалаар шийдсэн шүүхийн шийдвэрийг биелүүлэх, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор баталж байсан.<sup>10</sup> 1999 оны аравдугаар сард тусгай комисс анхны төслийг бэлдэж дууссан тэр үеэс конвенцийг батлуулах анхны алхам хийгдсэн. Эхний төслийн талаар маш олон санал, шүүмж гарч байсан ба ялангуяа АНУ-ын зүгээс энэ байдал хүчтэй гарч байсан аж.<sup>11</sup> Учир нь тус төслийн 7 дугаар зүйлд заасан хэрэглэгчтэй байгуулах гэрээний тухай заалт нь өмнө батлагдсан Брусселлийн Конвенц<sup>12</sup>-ийн 9 дүгээр зүйлийн хуулбар байсан ба энэ нь АНУ-д хэвшин тогтсон харьяаллын асуудлаарх хэм хэмжээнээс<sup>13</sup> тэс ондоо, түүний эсрэг утгатай байсан. 7 дугаар зүйлд хэрэглэгч өөрөө хэрэглэх хуулиа эсвэл маргаанаа шийдүүлэх шүүхийн харьяалаа чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой, заавал биелүүлэх хэм хэмжээг бүрэн агуулж чадсан эсэхэд АНУ маш их эргэлзэж байсан ба болгоомжтой хандсан. Маргаан үүсэхээс өмнө хэрэглэгчийн зүгээс маргаан гарсан тохиолдолд уг асуудлыг шийдвэрлүүлэх шүүхийг өөрөө бие даан сонгох эсэхэд АНУ болон Европын улс орнууд өөр байр суурьтай байсан.<sup>14</sup> Түүнчлэн АНУ мэдэгдэхдээ энэ төслийг хэрэгжүүлэх нь Үндсэн хуулиар тогтоосон эрх зүйг дээдлэх зарчим, шаардлагыг зөрчсөн явдал болно гэжээ.<sup>15</sup> Иймд АНУ болон Европын улс орнуудын харьяаллын асуудлаар зарчмын шинжтэй энэхүү ялгаа нь уг төсөл амжилтад хүрээгүй гол шалтгаан болж, уг ажлыг цааш үргэжлүүлэхийн тулд төслийг өөрчлөх шаардлага тулгарсан. Энэ талаар Фаусто Покар "1999 оны төсөл нь хэт түргэн маш их асуудлыг шийдвэрлэхийг оролдсон учраас амжилтад хүрээгүй" гэж цохон өгүүлсэн байдаг.<sup>16</sup> 2001 оны 6 дугаар сард Гаагийн дипломат хурал нь тааламжгүй тэмдэглэл хөтөлснөөр дуусгавар болсон юм. Хэдийгээр 2001 онд хийгдсэн дараагийн төсөл<sup>17</sup> нь конвенцийн хэрэглэгдэх хүрээг улам

<sup>10</sup> Худалдааны яамны АНУ-ын Патентын болон Барааны тэмдэгийн газар, RIN 0651-AB25, Иргэний болон арилжааны асуудлаарх гэгээдмийн шүүхийн шийдвэр болон шүүхийн харьяаллын тухай конвенцийн анхны төслийн хэлэлцүүлгийн тэмдэглэлийг үүссэн өргөзөл <http://www.uspto.gov/web/offices/com/sol/notices/prdconjud.html> (сүүлд нэвтэрсэн огноо 01/24/2010).

<sup>11</sup> Jeffrey D Kovar, US Department of State Assistant Legal Adviser for Private International Law, letter to Alasdair Wallace, Head of International and Common Law Services Division, Lord Chancellor's Department (Sep. 2000) <http://www.cptech.org/ecom/jurisdiction/kovarletter.html> (сүүлд нэвтэрсэн огноо 01/24/2010).

<sup>12</sup> 1999 оны төсөл болон Брусселл Конвенц аль аль нь хүрэх газар нутгийн харьяалаар асуудлыг шийдвэрлэх арга хэрэгжсэн. Хэрэглэгчтэй байгуулсан гэрээний тухай заалтууд уг төсөл болон конвенцид яг адил байна.

<sup>13</sup> Мөн тэнд 124 дүгээр ишлэл.

<sup>14</sup> Мөн тэнд 124 дүгээр ишлэл. Jeffrey D Kovar stressed in his letter to the convention: "We are not sanguine that any mandatory rule on choice of court clauses entered into by consumers could be included in this convention without ensuring that a significant group of countries would face difficult and divisive domestic opposition."

<sup>15</sup> Мөн тэнд 124 дүгээр ишлэл.

<sup>16</sup> The Hague Preliminary Convention on Jurisdiction and Judgments, Edited by Jausto Pocar & Costanza Honorati.

<sup>17</sup> <http://www.cptech.org/ecom/jurisdiction/hague.html> хаягцаас конвенцтой танилцана уу.

нарийсгасан, шинэчилсэн хувилбар байсан боловч зарим нэг, тухайлбал, цахим худалдаатай холбоотой чухал асуудлуудад талууд зөвшилцөлд хүрч чадаагүйн улмаас бас л хэрэгжээгүй. Хэрэгцээ нь улам өсч буй цахим худалдааны хувьд хэрэглэгчтэй байгуулах гэрээнд хэрэглэх хууль болон маргаан шийдэх шүүхийн харьяаллын асуудлыг тусгасан 7 дугаар зүйлийн талаарх хэлэлцээр өнөөх сөрөг байдлыг дахиж үүсгэв. Учир нь Европын улс, орнууд хэрэглэгчийн эрх ашгийг илүүд үздэг систем, харин АНУ бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг илүүд үзэж хэрэглэгчтэй байгуулж буй гэрээний асуудалд ханддаг байдал үл ойлголцлын үндэс болж байв. 2001 онд болсон бага хурлын дараа АНУ-ын зүгээс маргаан гарахаас өмнө хэрэглэх хууль, маргаан шийдүүлэх харьяаллын асуудлаа сонгож, үүнийг хэрэглэгчтэй хэлэлцээр хийхгүй шууд гарын үсэг зурдаг гэрээний хувьд заавал биелэгдэх шинжтэй байх ёстой гэх заалтын талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Урд засгийн эрхийг барьж байсан Клинтонь засаг захиргааны хариуцагатай албан тушаалтан Барбара С Уэлбэрри гэгч өгүүлэхдээ "Европын улс, орнуудад тогтсон эрх зүйн уламжлал ёсоор бол гэрээнд юу гэж зааснаас үл хамааран хэрэглэгч нь маргаанаа өөрийн оршин байгаа газрын шүүхээр шийдвэрлүүлэхийг зөвшөөрдөг. Гэтэл дэлхийн аль ч өнцөг булангаас хэн ч чөлөөтэй нэвтрэх боломжтой ийм онцгой мөн чанартай бизнес хийж буй АНУ-ын интернэтээр бизнес эрхлэгчдийн хувьд дээрх уламжлал асуудал дагуулдаг."<sup>18</sup> Мэдээж хэрэг "хэрэглэгчийн эрх ашгийг" илүүтэй хамгаалах асуудлыг онцолдог Европын улс орнуудын хувьд энэхүү хамгаалалтын түвшинг бууруулах нь тааламжтай санагдахгүй нь тодорхой, энэ тухай өмнө хийгдэж байсан Оттавагийн уулзалтын<sup>19</sup> үед ч дурдагдаж байсан.<sup>20</sup> Гэхдээ 2001 онд хийгдсэн төсөл бүхэлдээ нуран унаагүй, хэлэлцээрт оролцсон улс гүрнүүд нэг асуудалд санал нэгдсэн. "Хэрэв аж ахуйн нэгжүүд хэрэглэгчийн байнга оршин суудаг улсын хуулийг хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд хэрэглэхээс татгалзсан бол хэрэглэгчийн өөрийн улсын шүүхээр асуудлыг шийдвэрлүүлэх боломжгүй" гэдэг дээр нэгдмэл байр суурьтай болсон. Хил дамнанас цахим худалдаа эрхлэх сонирхолтой худалдагч талын хувьд энэ заалт ихээхэн үр ашигтай байсан гэдгийг дурдах нь зүйтэй. Энэ нь зөвхөн өөрийн улсын нутаг дэвсгэрт бизнес явуулж байснаа олон улсын түвшинд бизнесээ өргөжүүлэх сонирхолтой,

<sup>18</sup> Anandashankar Mazumdar, Jurisdiction Diplomatic Conference Draws Out Problems Implicated by Proposed Jurisdiction Treaty. BNA.

<sup>19</sup> ELECTRONIC COMMERCE AND INTERNATIONAL JURISDICTION Оттава, 02/28-ноос 03/01/2000 хүртэл (<http://www.cptech.org/ecom/hague/ottawa2000sum.pdf> сүүлд нэвтрэсэн огноо 01/25/2010)

<sup>20</sup> James Love, Hague Diplomatic Conference ends, Badly for now. (06/20/2001) (АНУ болон Европт хэрэглэгчтэй байгуулсан гэрээг хэрхэн зохицуулсан байдаг талаар дурссан).

эрх зүйн тодорхой байдалтай, аж ахуй эрхлэгчдийг дэмжсэн заалт болж чадсан. Мөн түүнчлэн гадаадын худалдагчдаас онлайн хэлбэрээр бараа бүтээгдхүүн авах боломжийг хэрэглэгчдэд бүрдүүлж чадсанаараа илүү замбараагүй баталгаагүй болсон. Тухайлбал, хэрэв Францад байгаа хэрэглэгч онлайнгаар Америкт байгаа худалдагчаас бараа худалдан авлаа гэж үзвэ. Энэ тохиолдолд Гаагийн конвенцийн дагуу уг хэрэглэгч маргаан гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлүүлэхээр Францад нэхэмжлэл гаргах баталгаа байхгүй. Хэрэглэгчийн хувьд байгуулж буй гэрээнд маргаан гарахаас өмнө хэлэлцэх эрхгүйгээр маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтоосон нь учирч буй бэрхшээлүүд дотроос хамгийн томоохон нь юм. Өөр нэг бэрхшээл нь тухайн цахим хуудас ажиглуулагчид "зайлшгүй шаардлагатай арга хэмжээ авсан"<sup>21</sup> гэдгийг ямар хэмжээгээр, ямар байдлаар тодорхойлох вэ гэсэн асуудал. Бүр тодруулбал, бараа, бүтээгдэхүүнийхээ сурталчилгаа, үзүүлж буй үйлчилгээгээ өөрийн хамаарах улсын хэл дээр танилцуулах нь шаардлагатай арга хэмжээ авч буйг харуулах хангалттай байдал мөн үү, хэрэглэгч маргаанаа шийдвэрлүүлэх шүүхээ гэрээ байгуулахаас өмнө сонгох, бизнес эрхлэгчийн хувьд ашиггүй өөр улсын шүүхийг сонгохоос хамгаалах зэргийг зарим технологийн дэвшлийн туслалцаатай шийдвэрлэх үү гэдэгт АНУ болон Европын улс орнуудын хувьд маргаан шийдвэрлүүлэх шүүхээ сонгох, түүний харьяаллыг тогтоох асуудал дээр зарчмын хувьд зөрүүтэй. Энэхүү бэрхшээлийн улмаас олон улсын хэмжээнд шүүхийн харьяаллын асуудлыг уялдуулах Гаагийн хурлын хүчин чармайлт талаар болсон.

## ХОЁР. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙГ СОНГОХ ЗӨВШИЛЦЛИЙН ТУХАЙ ГААГИЙН КОНВЕНЦ

Иргэний болон худалдааны талаарх гадаадын шүүхийн шийдвэр, түүний харьяаллын тухай Гаагийн конвенц нь өөрийн зорилгод хүрч чадаагүй тул хурлыг зохион байгуулагчдын зүгээс "иргэний болон арилжааны асуудлаар гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх, харьяаллын талаар нэгдсэн журам тогтоох"<sup>22</sup> асуудлаар 2005 онд өөр конвенцийн төслийг бэлтгэжээ. Уг конвенцийн нэр нь "Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай" юм. Урьд гаргасан алдаагаа давтахгүйг хичээж 2005 оны конвенцийг 2001 оны конвенцтэй харьцуулахад мэдэгдэхүйц хэмжээгээр хамрах хүрээг нь хязгаарлаж

<sup>21</sup> Summary of the Outcome of the Discussion in Commission II of the First Part of the Diplomatic Conference 6 – 20 June 2001 Interim Text.

<sup>22</sup> Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай (Convention on Hague Choice of Court). 06/30/ 2005.



өгсөн. Ямар нэг улс орон уг конвенцод гарын үсэг зураагүй байгаа учраас уг баримт бичиг хараахан хэрэгжиж эхлээгүй. "Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай" Гаагийн конвенцийн ирээдүй тун бүрхэг харагдаж байгаа боловч 2001 оны конвенцийн бүтэлгүйтэл хамгийн их маргалдсан асуудлаар цахим харилцааг зохицуулах нэгдмэл хэм хэмжээг бий болгох, цахим гэрээнээс үүдсэн маргааныг шийдвэрлэх шүүхийн харьяалалыг тогтоох хэм хэмжээг тодорхой болгохыг зорьсон. Харамсалтай нь ВЗС буюу бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн харилцаанд хийгдэж буй цахим гэрээнийн хувьд уг конвенц хэрэглэгдэх нь бага байх болно. Учир нь тус конвенцийн 2 (а) дугаар зүйлд хэрэглэгчийг уг конвенц үйлчлэх бусад маргаан үүсгэж буй субъектүүдтэй адилтгаж үзэлгүй хассан. Тус конвенцод хэрэглэгч гэдгийг "өөрийн гэр бүлийн эсвэл өрхийн өмнөөс үйлдэл хийгч хувь хүн"<sup>23</sup> гэж тодорхойлсон бөгөөд конвенцийн хамрах хүрээний гадна хэрэглэгчийн гэрээг албаар орхигдуулсан.

## ДҮГНЭЛТ

Хил дамнасан шинжтэй хэрэглэгчтэй байгуулсан гэрээний шүүхийн харьяаллын асуудлыг уялдуулах ажил амаргүй. Бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн (ВЗС) харилцаан дахь цахим худалдааны өсөлтийг дэмжих чармайлт гаргахдаа дэлхийн улс орнууд гол нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг бий болгосон, итгэл хүлээсэн, хил дамнасан тоон систем бүхий хэлцлийг зохицуулах уян хатан, нэгдмэл багц хэм хэмжээг бий болгон батлах зайлшгүй шаардлагатай байгаа гэдгийг ойлгосон. Нэг талаас авч үзвэл аж ахуйн нэгжүүд тэр дундаа вэб хуудас ашиглан үйл ажиллагаагаа сурталчлан явуулдаг жижиг дунд бизнес эрхлэгчдийн хувьд дэлхийн аль нэг өнцөг булангаас уг вэб хуудас руу нь нэвтрэх боломжтой байгаагийн төлөө бүх улс орны шүүхэд дуудагдан маргаан шийдвэрлүүлэх нь боломжгүй бөгөөд ийм байдалд хүргэхгүй байх баталгаа хэрэгтэй байгаа юм. Нөгөө талаас хэлэлцээ хийхэд давуу биш байр суурьтай байдаг хэрэглэгчдийн хувьд аливаа нэг маргаан гарахад уг маргаанаа шийдвэрлүүлэх шүүхийн харьяалал нь тэдний хувьд тодорхой байх шаардлагатай. Шүүхийн практикт интернетийн үйл ажиллагаанд хамааралтай хэрэг, маргааныг шүүхээс шийдвэрлэж байгаа олон жилийн туршлагын үр дүнд Америкийн Нэгдсэн Улс дахь хил дамнасан цахим харилцааг зохицуулах хэм хэмжээг бий болгосон. Харин Европын улс, орнуудын хувьд эрх зүйн ялгаатай зохицуулалт бүхий хууль тогтоомжуудыг

<sup>23</sup> Дээдсийн зэм. 2 (а) дугаар зүйл.

шинэчлэн өөрчлөх болон өөр өөр улс үндэстний эрх зүйн ялгаатай хэм хэмжээнүүдийг нийцүүлэх оролдлого хийж цахим харилцаанд дагаж мөрдөх хэм хэмжээг бий болгох арга хэмжээ авдаг. Бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн (B2C) харилцаан дахь цахим худалдаатай холбоотой маргааныг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг үндэстэн дамнасан түвшинд тогтоох асуудлыг зохицуулах тал дээр Европын арга нь илүү үр дүнтэй байна. Ямар нэг төрөлжүүлсэн хууль тогтоомжийг баримтлахгүйгээр шүүхийн удирдлага дор тухайн нэг хэрэгт гол анхаарал хандуулж, технологийн тодорхой шийдлийг хүлээн зөвшөөрсөн арга зам хэрэглэх, дээд шүүхээс жишиг тогтоох зэрэг байдал нь хууль зүйн хувьд тодорхой байдал, эрх зүйн орчинг урьдчилан харах бололцоог тодорхойгүй, баталгагүй болгож, хэрэглэгчдийг хамгаалалтгүй орхидог. “Эрх зүйг хөгжүүлэх үүргийг шүүхэд хүлээлгэх нь”<sup>24</sup> АНУ өөрийн бүх мужид хэрэглэгдэх нэгдмэл нэг стандартыг тогтоох, түүнийг хөгжүүлэхэд бүрэн түлхэц болж чадахгүй байгаа хэдий ч байнга нэмэгдэж буй технологийн хурдыг гүйцэхийг эрмэлзэн шүүхээс янз бүрийн хууль ёсны арга, техник ашиглан маргааныг шийдвэрлэхийг зорьж байгаа нь сайшаалтай.

Эрх зүйн тодорхой байдал болон урьдчилан тааварлаж болохуйц байдалаас гадна цахим орчинд хангалттай хэмжээнд хэрэглэгчдэд эрх зүйн хамгаалалт бий болгож чадаагүйн улмаас АНУ-ын авч хэрэгжүүлдэг арга зам мухардалд орж байна гэж дүгнэж байна. АНУ-д шүүхэд байнга эмчиллэлийн тэргэлтэй нэхэмжлэл үүсгэх тэр нь хангалдаг бөгөөд эдгээр нь тодорхой стандартуудыг зөрчдөггүй байна. Энэ байдал нь хэрэглэгчдэд хүндрэлтэй байдаг ба үүссэн маргааныг шийдвэрлүүлэхдээ ямар харьяалаар ямар шүүхэд хандах тухайд асуудал үүсгэдэг. Ихэнх тохиолдолд хэрэглэгчийн нэхэмжилж буй мөнгөн дүн бага хэмжээтэй байдаг бөгөөд хэрэв хэрэглэгчийн хувьд өөрийн харьяалагдаж буй улсдаа мараанаа шийдвэрлүүлж чадахгүйд хүрвэл байдал түүний хувьд ашиггүйгээр эргэнэ. Энэ нь дэлхийн бүх хэрэглэгчийн ашиг сонирхлыг хамгаалсан байгууллага болон энэ талаар судалгааны ажил эрхэлдэг хэн бүхэнд хамааралтай. Trans Atlantic Consumer Dialogue (цаашид гэх TACD) буюу Атлантын хэрэглэгчдийн байгууллага нь АНУ болон Европын Холбооны хэмжээнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар нэлээд нэрд гарсан байгууллагад тооцогддог. Тус байгууллагаас хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах бодлогыг илүү сайжруулах талаарх зөвлөмж<sup>25</sup> гаргасан. TACD нь нөхөн төлбөр авах боломжийг хэрэглэгчдэд нээлттэй

<sup>24</sup> Мин танд 7 дугаар ншлэл.

<sup>25</sup> Resolution on Defending Consumer Rights and Fair Business Practices in the Digital Environment (Apr. 2010) [http://www.tacd.org/index2.php?option=com\\_docman&task=doc\\_view&g Дээрхтэй адил=261&Itemid=Дээрхтэй адил=40](http://www.tacd.org/index2.php?option=com_docman&task=doc_view&g Дээрхтэй адил=261&Itemid=Дээрхтэй адил=40) хаягмаас үзэх боломжтой.

болгохоос татгалзаад буй АНУ-ын Засгийн газрын практикт хэд хэдэн зөвлөмж өгсөн байдаг. ТАСД нь хэлэлцээ хийх боломжгүй, шударга бус, гэрээний нөхцөл нь аюулгүй цахим зах зээл болон олон улсын хамтын ажиллагааг ямар нэг шатлалгүй байх хандлагыг хөгжүүлэхэд, ийм практик бий болоход маш том саад тогтор болно гэдгийг сануулж энэ талаар асуудал өрнүүлдэг.

Европын Холбооны зүгээс авч буй арга хэмжээ нь хэдийгээр сул талтай ч энэхүү байдлыг арилгах үүднээс цаашдаа арга хэмжээ авч, зохицуулалтыг боловсронгуй хийсэн бөгөөд үүнд олон улсын нэгдсэн шийдвэрийг гаргах байдлаар тусгажээ. Брюссель 1 Журмын хувьд уян хатан шинжтэй биш, илүү тодорхой, тайлбар шаардагдахааргүй, нэг утгаар ойлгогдохоор бичигдсэн зохицуулалттай. Холбогдох байгууллагаас хийсэн тайлбарын дагуу хэрэглэгчтэй байгуулж буй гэрээнд хатуу заалтууд оруулж өгөх нь гэрээг хязгаарлагдмал байдлаар тайлбарлахаас бусад тохиолдолд урьдчилан таамаглаж болохуйц эрх зүйн тодорхой байдлын түвшинг баталгаажуулж өгдөг юм. Түүнчлэн хэлэлцээ хийж буй хоёр тал тэгш бус эрх мэдэлтэй байдгийг анхааралдаа авахын зэрэгцээ цахим худалдааг нэмэгдүүлэхийн тулд Европын Холбоонын зүгээс бизнесээс хэрэглэгч рүү чиглэсэн харилцаанд хэрэглэгч итгэлтэйгээр оролцох явдлыг хангах, уг харилцаанд оролцохоос өмнө хэрэглэгч маргаан гарсан тохиолдолд маргаанаа шийдүүлэх шүүхийн харьяаллаа сонгох интернэтийн харьяаллыг тодруулахад онцгой ач холбогдол өгөх болсон.

Гаагийн хэлэлцээр амжилтгүй болсон ч гэсэн түүнээс сургамж авч цахим худалдааны эрх зүйн шийдвэрлэгдээгүй олон асуудлыг шийдвэрлэхийн тулд улс орнууд чармайлт гарган уг хэлэлцээрийн тавьсан зорилгыг биелүүлэх, энэхүү Гаагийн хэлэлцээрийн оролдлогыг дахин сэргээж авч үзэх нь чухал байна. Хил дамнасан цахим худалдааны тоон системийн орчинг илүү таатай эрх зүйн зохицуулалттай болгоход Европын улс, орнуудын авч хэрэгжүүлж байсан арга замыг удирдлага болгох нь зөв зүйтэй юм.

○○○○○

○○○○○

○○○○○

## Хүч хэрэглэсэн гэмт явдлын төрөл



Дотоод хэргийн их сургуулийн  
эрдэм шинжилгээний ажилтан,  
докторант Г.Оюунболд


Нийгмийн гэрээний үндсэн дээр үүсэж бий болсон иргэдийн хоорондын харилцаа нь ёс зүй (ethic), хүндлэл, дэг журам, аж төрөх ёс хэмээх ухагдахуунаар зохицуулагддаг. Магадгүй энэ нь зан заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаж, яваандаа хууль түүнийг зөрчсөн үед хүн өөрийн зөвшилцөөр шийдвэрлэж, шийтгэж ирсэн гэмт явдлын нэг байж болох юм. Хүмүүс аж төрж байгаа орчиндоо аюулгүй байх, тайван амьдрах баталгаа хүсэхийн хэрээр өөрсдийн байгуулсан төр, засгаас энэ баталгааг шаардах болсон юм.

Хүнд байгалиас заяасан инстинкт нь (animal instinct) асуудлыг хүчээр шийдвэрлэх хандлага бөгөөд ерөөс хүн бий болсон цагаас амьдралын хэрэгцээ шаардлагын үүднээс шударга бус аргаар өмч хөрөнгө олж авах, бусдыг гэмтээх, зодох, хүчирхийлэх зэргээр хэрэгцээгээ хангаж байв.

Тодруулбал<sup>1</sup> хүнд янз бүрийн хэрэгцээнүүд байх бөгөөд анхдагч хэрэгцээгээ нөхөж байж дараа нь дунд, дээд шатны хэрэгцээгээ хангах (Maslow, 1970, 1987) ба Маслоу хэрэгцээний шатлалыг дэвшүүлж анхдагч хэрэгцээ нь суурь хэсэгт, дээд хэрэгцээ нь орой хэсэгт байх пирамид байдлаар загварчилсан. Мөн хүн өөрийн суурь хэрэгцээгээ хангах явдал нь эрүүл саруул, сэтгэл хангалуун амьдрах амьдралын гол нөхцөл болдог гэж үзээд амьдралын амин гол хэрэгцээний байнгын хомсдол дутагдал нь хүний биологийн түлхээсийг идэвхжүүлэх ба өөрөөр хэлбэл түрэмгий,

<sup>1</sup> Батболд.Ш (2010) Сэтгэл судлал, сонголтнууд У6, 121.

харгис хэрцүгий зан, уур хилэнг хөдөлгөдөг гэжээ.



Физиологийн ба аюулгүй байдлын хэрэгцээ нь доод шаталд хамаарах бөгөөд эдгээр хэрэгцээг хангасны дараа нийгмийн гишүүн болж өөрийн хувь нэмрээ оруулдаг байна. Дараа нь хүн өөрийгөө хүндлүүлэхэд чиглэж эхэлдэг. Маслоугийн үзсэнээр хүндэтгэл нь өөрийнхөө үнэ цэнийг мэдрэх хэрэгцээтэй холбоотой бөгөөд бусад хүний үнэ цэнэ, эрхийг мэдсэнээр хэрэгжих боломжтой гэж үзсэн.

Судлаачид хүний хэрэгцээг ерөнхийд нь 5 ангилж үзсэн бөгөөд үүнд:

1. Амьдралын амин чухал хэрэгцээ;
2. Эд хөрөнгийн хэрэгцээ;
3. Нийгмийн хэрэгцээ;
4. Оюуны хэрэгцээ;
5. Ухаалаг бус хэрэгцээ зэрэг болно.

Криминологийн шинжлэх ухаанд хүч хэрэглэсэн гэмт явдал онцгой судлагдахуун байсаар ирсэн төдийгүй түүхэн эх сурвалжуудад тэмдэглэн үлдсэн нь баялаг. Манай улсын хувьд гэмт явдлын анхны ангилалтыг энэ салбарын эрдэмтэд болох Н.Жанцан, С.Жанцан, Тажебакед, Н.Баатаржав нар анх хийсэн байдаг.<sup>2</sup> Социалист эрх зүйн тогтолцооны үед буюу 1960—аад оны эхэн үеэс гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах ажил эрчимтэй хөгжиж, 1973 онд “Гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэн”-г байгуулан олон тооны судалгаа хийжээ. Орчин үед ч криминологийн шинжлэх ухаан энэ асуудалд анхаарал хандуулж ХЗҮХ-гээс 2004 онд Гэмт явдлын талаар хийсэн суурь судалгаа<sup>3</sup> явуулсныг дурдаж болно. (Д.Зүмбэрэлхамаар ахлуулсан 35 хүний бүрэлдхүүнтэй багийн судалгаа)

Хүч хэрэглэсэн гэмт явдлыг тухайн улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлт, төрлийг харгалзан ангилах нь бий. Тухайлбал барууны

<sup>2</sup> Жанцан, С. (1995) Гэмт явдал судлал, Жанцан, Н. (2004) Криминология.

<sup>3</sup> Ред. Зүмбэрэлхамаар, Д. (2005) Монгол Улсын хэмжээнд 1990-2004 онд бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, дүгнэлт гаргах ажлын хэргийн судалгааны тайлан.

орнуудад хүч хэрэглэсэн идэвхтэй үйлдэл болох халдлага, довтолгоо хийсэн байх шинжийг эн тэргүүнд харгалзан үзэж галт зэвсэг бүхий довтолгоо үүн дотроо дээрмийн болон хүний амь насанд халдах зорилго бүхий үйлдлүүд, бие махбодийн халдашгүй байдалд халдсан идэвхтэй үйлдэл болох хүчирхийлэл гэсэн үндсэн хоёр ангилалд авч үзэж байна.<sup>4</sup> Гэтэл зарим улс орон тухайлбал, Австралид хүн хулгайлах хууль бусаар хорих, барьцаалах гэмт хэргийг, харин шинэ Зеландад шантааж, дарамтлах хэргийг нэмж оруулсан байх жишээтэй байна. Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцооны онцлогоос үл хамааран хүч хэрэглэсэн гэмт явдал нь:

- Хувь хүний эсрэг чиглэсэн;
- Өмч, эд хөрөнгө эсвэл бие махбодид халдсан;
- Хохирол учруулсан;
- Халдлага үйлдсэн идэвхтэй зан үйл байх гэсэн шинжүүдийг нэн

тэргүүнд харгалзан үзэж байна.

Харин нийгмийн дэг журам (public disorder)<sup>5</sup> зөрчсөн байх шинжид хувь хүний бие махбодь, өмч хөрөнгө, сэтгэл санаа шууд халдлагад өртдөггүй учраас энэ нь судлаачдийн дунд олон талын маргаан дагуулдаг. ОХУ-ын эрдэмтэд<sup>6</sup> хамтын аж төрөх ёс, нийгмийн дэг журмыг зөрчсөн танхай балмад авиртай холбон үзэж, үүнийг төрийн эрүүгийн бодлогоор зохицуулан гэмт хэрэгт тооцох ёстой хэмээн үздэг бол барууны криминологичид зөрчлийн хэмжээнд авч үздэг нь гэмт хэргийн сургааль, төрийн эрүүгийн бодлогын чиг баримжаатай холбоотой юм. .

## НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ БАРИМЖААТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ГЭМТ ЯВДЛЫГ АНГИЛАХ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ТАЛААР БОДЛОГО

Эрүүгийн хууль тогтоомж 1960-1980-аад оны сүүл үе хүртэл харьцангуй тогтвортой, социалист эрх зүйн хэв маягийг бүрэн тусгасан, Эрүүгийн байцаан шийтгэх хууль мөрдөн шүүх онцлогтой байв. Энэ үед гэмт хэрэг үйлдсэн бүхий л хүмүүсийг “хуучин нийгмийн үлдэгдэл” тул тэдгээртэй хүчтэй тэмцэл явуулж үндсэндээ гэмт хэргийг устгах тухай үзэл суртлыг тухайн үеийн нам, төрийн удирдамжийн баримт бичигт тусгаж байв.<sup>7</sup> Тухайлбал, “Танхайрах гэмт хэрэг үйлдэгчидтэй тэмцэх

<sup>4</sup> <http://www.criminal-law-lawyer-source.com/terms/violent.html>

<sup>5</sup> [http://en.wikipedia.org/wiki/Public\\_order\\_crime](http://en.wikipedia.org/wiki/Public_order_crime)

<sup>6</sup> <http://ru.wikipedia.org/wiki/Хулиганство>

<sup>7</sup> ХЗҮХ, ЭЗХС, (2011) *Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн төлөвлөлт 1911-2011 он хүртэл судалгааны ажлыг, Үндэсний архивын газрын сан хөмрөгөөс авсан МАХН-ын Төв хорооны баримт бичгүүдийн эмхэтгэлийн хуулбаруудас. Суд.*

ажлыг эрчимжүүлэх тухай" МАХН-ын төв хорооны тогтоол гарч, хатуу чанд цээрлүүлэх чиглэл баримталдаг байсан. Өөрөөр хэлбэл нам гэмт явдалтай тэмцэх бодлого стратегийг тодорхойлож, зарим тохиолдолд түүнээс гаргасан эрх зүйн акт Эрүүгийн хуулиас илүү хүчин чадалтай үйлчилж байсан.

Hooliganism<sup>8</sup>. Хулиганизм буюу Танхайрах гэмт явдал нь хүч хэрэглэсэн гэмт явдалд тооцогддог. Хэдийгээр гадны зарим улсын төрийн эрүүгийн бодлого болон эрүүгийн хууль тогтоомжид танхайрах явдлыг гэмт хэрэг гэж үздэггүй ч манай улсын хувьд зөвхөн энэ чиглэлээр дагнан криминологийн судалгаа хийж, доктор хамгаалсан эрдэмтэд цөөнгүй бий. Түүнчлэн энэ нь "танхайрах гэмт явдал судлал" гэсэн тусгайлан "школ" буюу онол, үзэл баримтлал боллоо хөгжжээ.

Энэ төрлийн үйлдлийг зөвхөн зөрчлийн хэмжээнд авч үзэж байгаа эсвэл гэмт хэрэгт тооцож байгаагаас хамааран тухайн нийгэмд гарч байгаа гэмт явдлын гаралт, хэлбэлзэл өөрчлөгдөж байдаг. Тухайлбал, Англи Улсад хөлбөмбөгийн танхай" (football hooliganism) гэсэн тусгайлан зөрчлийг (delict) судалдаг, түүнээс урьдчилан сэргийлэх бодлогыг англи хүний менталитет, хөлбөмбөгийн фанатуудын сэтгэл зүйн дүр төрх, бүртгэл зэрэгт үндэслэн явуулдаг байна. Гэтэл танхайрах зөрчил нь ОХУ-д захиргааны зөрчил судлал буюу "административный деликтолог" <sup>10</sup> гэсэн криминологийн бие даасан салбар боллоо хөгжсөн байх жишээтэй. Ямар хүрээнд танхайрах гэмт хэрэг, зөрчил гэж ялгаж байгаагаас хамааран эрүүгийн ялын төлөв байдал, тэр дундаа хорих болон хорихоос өөр төрлийн ял, шоронгийн дүүргэлт, хоригдлын тоо (prison population) <sup>11</sup> гардаг нь анхаарал татсан асуудал юм.

Тухайлбал, Монголд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаа нийт хүмүүсийн 30 гаран хувийг зөвхөн танхайрах тэр дундаа зэвсгийн чанартай зүйл хэрэглэж танхайрах гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлэх явдал эзэлж байгаа нь нийгэмд энэ төрлийн гэмт явдал илүү хор аюултай, харгис хэргүй гарч байгаа мэт харавч нөгөө талаас авч үзвэл Эрүүгийн хуульд энэ төрлийн гэмт хэргийн объектив талыг тусгасан байдал, Улсын дээд шүүхийн тайлбараас шалтгаалж гэмт хэргийн шинжийг ялимгүй агуулсан үйлдлийг хүнд гэмт хэрэгт тооцож (аягаар хүн цохисон, айлын цонх хагалсан гэх мэт) байх жишээтэй. Төрийн Эрүүгийн бодлогын нэг хэсэг болох Эрүүгийн хууль нь гэмт явдал тэр дундаа хүч хэрэглэсэн

<sup>8</sup> <http://en.wikipedia.org/wiki/Hooliganism>

<sup>9</sup> Steve Frusdick, Peter E. Marsh "Football hooliganism". Willan Publishing, 2005

<sup>10</sup> Сүхбаатар Ч.Нямсүрэн Захиргааны деликтологийн асуудлыг анх удаа хөндөн авч үзсэн байдаг.

<sup>11</sup> Монгол Улс 100 мянган хүнд ногдох хоригдлын тоогоор дэлхийд 49 дүгээр байрт жагсаж байгаа нь Азидаа хамгийн өндөр үзүүлэлт байна. [www.prisonstudies.org](http://www.prisonstudies.org)

гэмт явдлын дүр зургийг бодитоор тодорхойлоход нийнхүү бэрхшээл учруулж байна.

## ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгааныг авч үзэхийн өмнө хууль цаазын түүхэн уламжлал, эрүүгийн болон захиргааны хууль тогтоомжид тусгагдсан байдлыг тодорхойлох нь зүйтэй. 1206 оноос хойш үйлчилж байсан бичмэл хэв хууль болон энэ талаар гарсан судалгааны бүтээлээс шүүн үзэхэд танхайрах, хүчиндэх зэрэг үйлдэлд хүлээлгэх хариуцлага 1918 он хүртэл тодорхойгүй байна. Энэ нь монголчууд нүүдлийн амьдарлын хэв маягтай, төвлөрсөн, суурин амьдралд шилжих хүртэл урт удаан хугацааг туулсантай холбоотой. Хүн ам төвлөрсөн, хот суурин газар дэг журам, хамтын аж төрөх ёс гэсэн ойлголт нийтийн эрх ашгийг илэрхийлдэг. Тухайн дэг журмыг зөрчих үйлдлийг танхайрал хэмээн үзэж хариуцлага хүлээлгэдэг нь суурин амьдралтай бүх л улсад тогтсон хандлага байж. Монгол Улс Манжийн дарлалаас ангижирч Үндэсний ардчилсан хувьсгал ялах хүртэл Их Хүрээ, Ховд, Улиастай зэрэг хэдхэн газарт суурин амьдрал төвлөрч, их төлөв лам нарын харилцааг тодорхой зарлиг, дүрмээр зохицуулан балмадаар танхайрч, архидаг согтуурсан үйлдэлд хариуцлага хүлээлгэдэг байв. Нийгмийн давхаргын дийлэнх хувийг лам нар эзэлж байсан нь тухайн үеийн Монгол Улсын нийгмийн онцлогийг харуулдаг. Өргөн удам газар нутагтай Монгол Улсын хувьд иргэд хоорондын харилцаа зан заншлын хэм хэмжээн дээр тулгуурладаг байсан ба найр наадамд агсам тавьсан, хүнийг элвээр хараан зүхсэн, нударга зөрүүлсэн эрийг шийтгэнэ гэхээсээ илүүтэй “эр хүнд байх ёстой зүйл” гэж хүлээж авдаг сэтгэлгээ тогтсон байлаа.

Монгол орноор 1918-1919 онд аялж одоогоор мэдэгдэж байгаа анхны хүн амын тооллогыг хийсэн оросын судлаач офицер И.Майский өөрийнхөө тайлан бүтээлдээ монголчуудын зан төлөвийн талаар нэлээдгүй зүйл бичиж үлдээсэн байдаг. Тэрбээр “Би монголын эрх зүйг тодорхойлох санаатай материал цуглуулж явахдаа учир сайн ойлгох хүмүүсээс хүчингийн хэргийг яаж шийтгэдэг талаар асуухад тэд ерөөсөө түгдрээд хариулж чаддаггүй байлаа” гэсэн нь<sup>12</sup> ихээхэн сонирхолтой.


Монгол хүний сэтгэлгээний онцлог буюу менталитетын талаар олон дүгнэлт байдаг ч судлаач Ж.Гэрэлбадрахын “...Менталитетын суурь өөрчлөлт Монголд хоёр удаа болсон байна. Үүний нэг дэх нь XIX зууны сүүлч, XX зууны эхээр Монгол Улс уламжлалт нийгмээс орчин

<sup>12</sup> Майский И. *Автономия Монгола XX зууны гараан дээр*. Орчуулагч Отгон Ц. (2005).



үеийн нийгэмд шилжих үед нийгмийн асар их донсолгооны үед болжээ. Энэ үед “уламжлалт” монгол хүний хэв маяг “социалист монгол (*Ното Советicus гэсэн нэр томъёог*<sup>13</sup> Тимофеев Николай Васильевич гэж хүн гаргаж ирсэн) хүн” болон өөрчлөгджээ. Энэ дашрамд дурдахад манайд тогтсон зөвлөлт маягийн нийгмийн байгуулал нь орчин үеийн нийтээр хүлээн зөвшөөрсөн ангиллаар орчин үеийн буюу модерн нийгмийн байгуулалд хамаардаг. Удаах суурь өөрчлөлт нь 1990-ээд оны өөрчлөлт, шинэчлэлээр эхэлж одоо үргэлжилж байна. Энд “социалист” монгол хүн “капиталист” монгол хүн болон өөрчлөгдөх үйл явц болж байна. Уламжлалт, социалист, капиталист гурван хэв маяг хүний амьдралын гурваас дөрөвхөн үеийн дотор солигдсон нь монгол хүний менталитет, тухайлбал, үнэт зүйлс, эрхэмлэл, зан араншинг ихээхэн зөрчилтэй, тодорхойгүй, чиг баримжаагүй болгож, нийгмийн харилцааг үлэмж зөрчилтэй бөгөөд ихээхэн онцлогтой болгож байгаа юм” гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх үндэстэй байна.

Тухайлбал, Монгол Улсад 1988 онд 6614 гэмт хэрэг бүртгэгдсэн бол үүнээс хойш тасралтгүй өсөж 1997 онд 24657 гэмт хэрэг бүртгэгдэж 3,4 дахин өссөн байв.<sup>14</sup>



Ийм маягаар Монгол Улсад гарч, бүртгэж байгаа гэмт хэрэг дунджаар жилд 21 мянга орчим үзүүлэлттэй байгаагийн гол шалтгаан нийгмийн хүчин зүйлтэй шууд холбоотой юм. Өнөөгийн байдлаар гарч байгаа гэмт хэргийн 60 орчим хувийг хулгай, 30 орчим хувийг хүч хэрэглэсэн гэмт явдал эзэлж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн бүлэглэлтийг авч үзвэл “Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”, “Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг”, “Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг”, “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”.

<sup>13</sup> [http://ssmlib.ru/t/timofeev\\_n\\_w/homo-sovieticus.html](http://ssmlib.ru/t/timofeev_n_w/homo-sovieticus.html)

<sup>14</sup> ЦЕГ-ын Мэдээлэл Судалгааны Төв (2007) Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг (1968-иас 2006 он хүртэл).

“Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” зэрэг олон бүлэгт хүч хэрэглэсэн гэмт явдлыг хуульчилжээ.

Хэдий тийм ч тухайлан хувь хүнд хүч хэрэглэн халдсан гэмт хэргүүдийг өөр өөр бүлэгт хуваарилан авч үзсэн нь ойлгомжгүй байдаг. Хүн алах, гэмтэл учруулах гэмт хэрэг, хүчиндэх, дээрэмдэх хэргүүд өөр бүлэгт хамаардаг.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Криминологийн шинжлэх ухаанд хүч хэрэглэсэн гэмт явдлыг зөв ангилан, төрөлжүүлэх нь Эрүүгийн хуулийн Тусгай ангид гэмт хэргийг бүлэглэхэд тустай төдийгүй гэмт хэргийн статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх, энэ гэмт явдлын төлөв байдлыг үнэн, зөв тодорхойлоход онцгой ач холбогдолтой юм. Түүнчлэн гэмт хэрэгтэй тэмцэх стратегийг боловсруулахад криминологийн судалгааны үндэслэлтэй санал, зөвлөмжүүд бодлого боловсруулагчдад нөлөөлөх чиглэлтэй байвал зохино гэж үзэж байна.

- Хүч хэрэглэсэн гэмт явдал нь Эрүүгийн хуулийн зүйл, хэсэгт харилцан адилгүй, системчлэлгүй хуульчлагдсанаас уг гэмт явдлын төлөв, байдлыг бодитой тогтооход бэрхшээл учруулж байна.

- Нийгмийн уламжлалт хандлага тэр дундаа гэмт хэрэгтэй тэмцэл явуулахад социалист хэв загварын сэтгэлгээ, хуульчдын олж авсан хуучин мэдлэг саад болдог. Тиймээс хандлагаа өөрчлөх, шинэ мэдлэг олгоход чиглэсэн сургалт явуулах шаардлагатай.

- Орчин үеийн төрийн эрүүгийн бодлогын нэг хэсэг нь криминологийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чиглэх учиртай. Энэ хүрээнд гэмт явдлын төрлийг тодорхой болгох.

Монгол Улсад хүч хэрэглэсэн гэмт явдлыг доорх байдлаар ангилах саналтай байна. Үүнд.

- Хүний бие, махбодийн эсрэг хүч хэрэглэсэн гэмт явдал буюу хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг чиглэсэн гэмт хэрэг;

- Хүний сэтгэл санааны эсрэг хүч хэрэглэсэн гэмт явдал буюу доромжлох, гүтгэх, захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих, заналхийлэх, далайлган сүрдүүлэх гэмт хэрэг;

- Бэлэгсийн гэмт явдал буюу хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг;

- Өмчийн эсрэг хүч хэрэглэсэн гэмт явдал буюу дээрэмдэх, булаах;

- Гэр бүлийн хүчирхийлэл буюу ахуйн хүрээнд гардаг зөрчил,



## Иргэний хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон улсын тэмдэгтийн хураамж



МУИСийн Хууль зүйн сургуулийн  
Иргэний эрх зүйн тэнхмийн ахлах  
багш, докторант Д.Хуяг

### НЭГ. УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ

Аливаа этгээд зөрчигдсөн буюу маргаж байгаа эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирголоо хамгаалуулж, сэргээлгэх шүүхэд нэхэмжлэл (гомдол, хүсэлт) гаргахдаа Улсын тэмдэгтийн хураамж төлөх үүрэгтэй бөгөөд Улсын тэмдэгтийн хураамж төлөх хувь хэмжээ нь тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарна. Шүүхээс иргэний хэрэг маргааныг шийдвэрлэхэд зайдшгүй хөрөнгө, мөнгө, зардлын тухай асуудал гардаг ба Улсын тэмдэгтийн хураамж нь шүүхийн зардлын нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Улсын тэмдэгтийн хураамж нь улсын төсөвт төвлөрсний үндсэн дээр шүүхийн төсвөөр дамжин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс гарах зардалд зарцуулагдана. Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоох, гаргуулах, төлөхтэй холбогдсон харилцааг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль ба Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тус тус зохицуулна.

2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр батлагдсан (2011-06-09 өдөр өөрчлөлт орсон) Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлд “Төрийн эрх бүхий байгууллага энэ хуульд заасан үйлчилгээ

үзүүлсэний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг Улсын тэмдэгтийн хураамж гэнэ" гэж өргөн утгаар авч үзсэн бол НХШХШ тухай хуулийн 57 дугаар зүйлийн 1-д "Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохигчоос төлж байгаа мөнгөн хөрөнгийг Улсын тэмдэгтийн хураамж гэнэ" гэж тодорхойлжээ.

Улсын тэмдэгтийн хураамж гэдэг ойлголтын талаар хуульч, судлаачид дараах тодорхойлолтуудыг өгчээ.Үүнд:

- Дэд доктор Л.Бямбаа. "Эрх зүйн маргааныг шүүх хянан шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааны зардалд зориулж хуулиар тусгайлан заасан хэмжээгээр хэргийн зохигчдоос төлж байгаа мөнгөн төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамж гэнэ".<sup>1</sup>

- ОХУ-ын дэд доктор В.В.Молчанов "Улсын тэмдэгтийн хураамж нь хуулиар тогтоосон ОХУ-ын бүх нутаг дэвсгэрт заавал төлөх төлбөр ба хууль зүйн ач холбогдол бүхий үйлдэл хийх, баримт бичиг гаргаж өгөх, шүүхээс иргэний хэрэг хянан шийдвэрлэх, шүүхээс гаргасан баримт бичгийн хуулбарыг зохигчид өгөхтэй холбогдсон төлбөр юм";<sup>2</sup>

- Дэд доктор М.И.Масленникова "Улсын тэмдэгтийн хураамж нь иргэн, хуулийн этгээдээс гаргуулдаг, тэдний ашиг тусын тулд хуулиар тусгайлан эрх олгосон байгууллагын үйл ажиллагааны ба эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичгийг олгосонтой холбогдон авч байгаа улсаас тогтоосон мөнгөн хураамж";<sup>3</sup>

- Дэд доктор Р.Е.Гукасян "Иргэний хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон улсын орлогод оруулж байгаа мөнгөн хураамжийг Улсын тэмдэгтийн хураамж гэнэ".<sup>4</sup>

## ХОЁР, ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХАД УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ ТӨЛҮҮЛЭХИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛ

### 4. Эерэг тал

1. Шүүхэд хууль зүйн үндэслэлгүй нэхэмжлэл гаргаж шүүхийн ажилд чирэгдэл учруулж, шаардлагагүй зардал гаргуулахаас урьдчлан сэргийлэх;

2. Нэхэмжлэл гаргагчийн хариуцлагыг дээшлүүлэх;

3. Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтийн нэг хэсэг болж улсаас

<sup>1</sup> Амарсайхан Ц., Бямбаа Л. (2008) *Иргэний эерэг шүүхээс хянан шийдвэрлэх тухай хуулийн эзлэлзэнгүй тайлбар* Уб, 166.

<sup>2</sup> Ред. Треушников М.К (2008) *Гражданский процесс* М, 185.

<sup>3</sup> Ред. Яков В.В (1999) *Гражданский процесс* М, 161.

<sup>4</sup> Ред. Шахриян М.С (1996) *Гражданское процессуальное право* М, 91.

шүүхийн үйл ажиллагаанд төсөвлөсөн мөнгөний зарим хэсгийг нөхөн төлүүлэх (энэ өгүүлэлийн хавсралт судалгаа 1-4-ийг үзнэ үү);

4. Гадаадын улс орнуудын иргэний процессын хуулийн жишиг нийтлэг үндэслэлд нийцэж байгаа. Жишээ нь ОХУ, ХБНГУ, АНУ-ын иргэний процессын ба бусад хуульд нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргахад Улсын тэмдэгтийн хураамж төлөх тухай заалтууд байдаг.

#### Б. Сөрөг тал

1. Эрх нь зөрчигдсөн этгээд шүүхэд хандсан тохиолдолд “Шүүхийн хамгаалалт хүртээмжтэй байх” гэсэн эрх зүйн зарчмыг зөрчиж болзошгүй.

ГУРАВ. МОНГОЛ УЛСАД УРЬД БАТЛАН МӨРДӨЖ БАЙСАН 1926,1952,1967,1994 ОНЫ ИРГЭНИЙ ПРОЦЕСССЫН ХУУЛИУДАД УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ ТӨЛСӨН ТУХАЙ ЗААСАН НЬ

1926 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталсан “Монгол Ард Улсын Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх” тухай хуулийг анхны процессийн шинжтэй хууль гэж үзэж болох ба уг хуулийн 45 дугаар зүйлд “Шүүн таслах газарт тусгай дүрмийн ёсоор хураалгавал зохих аливаа татвар зэргийг хэрэг мэдүүлэхийн хамт төлөвөөс зохино. Хэрэв үнэхээрийн төлж чадахгүй бол хэрэг дуусахыг хүртэл татвар хураахыг алгуурдавал зохино.”<sup>5</sup>

1952 оны 5 дугаар сарын 27-ны өдөр баталсан “Иргэний байцаан шийтгэх хууль”-ийн 22 дугаар зүйлд “Шүүхийн байгууллагуудад гаргасан нэхэмжлэлийн өргөдөл, шүүхийн шийдвэрийн давж заалдсан гомдол хийгээд шийдвэрийн хуулбар ба бусад бичгийг олгосон зэргээс тэмдэгтийн татварыг хураана. Үүнд:

А. 150 хүртэл төгрөгийн нэхэмжлэлээс 2 төгрөг;

Б. 150-аас 750 хүртэл төгрөгийн нэхэмжлэлээс бүх нэхэмжлэлийн 2 хувь;

В. 750-аас дээш төгрөгийн нэхэмжлэлээс бүх нэхэмжлэлийн 3 хувь;

Г. Эд хөрөнгөний чанартай биш нэхэмжлэлийн өргөдөл ба шүүхийн шийдвэрийг давж заалдсан гомдлоос 3 төгрөг;

Д. Хэргийн шийдвэрийн хуулбар ба бусад баримт бичиг зэргийг олговол 2 төгрөг тус тус хураана.”<sup>6</sup>

<sup>5</sup> Энхбаяр,С Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (1926,1952,1967,1994,2002он) эмхтгэл У6, 31.

<sup>6</sup> Энхбаяр,С Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (1926,1952,1967,1994,2002он) эмхтгэл У6, 68-69.

1967 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан "Иргэний байцаан шийтгэх хууль"-ийн 72 дугаар зүйлд нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч Улсын тэмдэгтийн хураамжийг гаргуулахаар заахын зэрэгцээ шүүхийн шийдвэрийг давж заалдах өргөдлөөс Улсын тэмдэгтийн хураамжид 5 төгрөг гаргуулахаар заасан байна. 1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль" баталж шүүхэд нэхэмжлэл гаргахад төлөх Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг Иргэний процессын хуулинд биш тусдаа хуулиар зохицуулах болсон ба харин 1994 оны 5 дугаар сарын 9-ний өдөр баталсан "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль"-д зохигч давж заалдах гомдол гаргасан тохиолдолд Улсын тэмдэгтийн хураамж төлөх тухай заалт тусгаагүй, харин 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль"-д зохигч давж заалдах ба хяналтын шатаар гомдол гаргасан тохиолдолд Улсын тэмдэгтийн хураамж төлөх, хялбаршуулсан журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэсэн бол Улсын тэмдэгтийн хураамжийг 50 хувиар бууруулан төлөх зэрэг шинэлэг заалтууд тусгасан.

Мөн 2002 оны ИХШХШ тухай хуульд Улсын тэмдэгтийн хураамжийг зохигчид буцаан олгох ба буцаан олгохгүй байх дараах үндэслэлийг тусгажээ.

Улсын тэмдэгтийн хураамжийг зохигчид буцаан олгох үндэслэл нь:

1. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзвал;
2. Давж заалдах ба хяналтын журмаар гомдол гаргасан этгээд гомдлоосоо шүүх хуралдааны өмнө татгалзвал;
3. Давж заалдах ба хяналтын шатны шүүхэд зохигчийн гаргасан гомдол үндэслэлтэй болох талаар шүүхээс хийсэн дүгнэлт.

Нэхэмжлэгчээс урьдчилан төлсөн Улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй байх үндэслэл нь:

1. Нэхэмжлэгч, гуравдагч этгээд, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй үндэслэлээр шүүх нэхэмжлэлийг буцаасан ИХШХШ тухай хуулийн 59.6 ба 100.2 дахь хэсэг;
2. Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлагаа багасгасан (нэхэмжлэлийн шаардлагын тухайн хэсэг хангагдаагүй байхад);
3. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан (нэхэмжлэл хангагдаагүй байхад).

Шүүхээс иргэний хэрэг шийдвэрлэх явцад Улсын тэмдэгтийн хураамж гаргуулах, хуваарилах, төлүүлэхтэй холбогдсон шүүхийн практикийг

судлан үзэхэд дараах алдаа зөрчил гарчээ. Үүнд:

1. ИХШХШ тухай хуулийн 63.1.2-т эд хөрөнгө гаргуулах тухай нэхэмжлэлд нэхэмжилж байгаа эд хөрөнгийн үнийн дүнгээр нэхэмжлэлийн үнийн дүнг тооцно гэсэн заалт байхад нэхэмжилж байгаа эд хөрөнгө нь үнэлж болох эд хөрөнгө байхад үнэлж болохгүй эд хөрөнгө гэж үзээд 250 тыгрөг төлүүлсэн (Сүхбаатар дүүргийн шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 299 дүгээр шийдвэртэй хэрэг);

2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд зааснаар нэхэмжлэгч нэхэмжлэл гаргахдаа Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх ёстой байхад Улсын тэмдэгтийн хураамж төлүүлсэн. (Сүхбаатар дүүргийн шүүхийн 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 259 дүгээр шийдвэртэй хэрэг);

3. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд заасан нэхэмжлэл Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх байхад Улсын тэмдэгтийн хураамж төлүүлсэн;

4. Хөдөлмөрийн хуульд заасан ажлаас үндсэлэлгүй халагдаж нөхөн олговор авах тухай нэхэмжлэл нь томдлоор хэлэлцэх хэрэг байхад урьдчилан улсын тэмдэгтийн хураамж гаргуулахаар шийдвэрлэж байсан. (Баянгол дүүргийн шүүхийн 2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1135 дугаартай шийдвэртэй хэрэг)

Мөн Улсын тэмдэгтийн хураамжийн талаарх хуулийн зохицуулалтыг шүүхийн практикт хэрхэн хэрэглэж байгаа тухай Дээд шүүхийн 2006 оны зөвлөмж, Нийслэлийн шүүхийн 2008 оны мэдээлэл, 2009 оны зөвлөмжөөс үзэхэд шүүхүүд улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ улсын тэмдэгтийн хураамжийн хууль ба ИХШХШ тухай хуулийн заалтыг хэрэглэдэггүй, хуулийн нэр томъёог буруу бичих, хуулийн зүйл, хэсэг, заалтыг зөв баримталдаггүй, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, улсын тэмдэгтийн хураамжийг буруу тооцож, буруу хуваарилсан, нэхэмжлэгч улсын тэмдэгтийн хураамж дутуу төлсөн байхад нөхөн гаргуулаагүй, илүү төлсөн байхад буцааж олгоогүй, нэхэмжлэгч улсын тэмдэгтийн хураамж зөв төлсөн байхад дутуу төлсөн гэж нэмж гаргуулсан, эсхүл буцаасан, хариуцагчаас улсын тэмдэгтийн хураамжийг гаргуулж нэхэмжлэгчид олгохдоо дутуу тооцсон, эсхүл илүү тооцсон, нэхэмжлэгч улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй байхад хуваарилсан, зөв тооцож хуваарилаагүй, огт хуваарилаагүй орхисон, зохигчдоос хэнээс тэмдэгтийн хураамж гаргуулснаа нэр зааж шийдээгүй, хэргийн оролцогч биш этгээдээс тэмдэгтийн хураамж гаргуулахаар заасан, улсын тэмдэгтийн хураамжийн дүнг буруу бичсэн, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байхад улсын тэмдэгтийн хураамжийг буцаан



олгоогүй, давж заалдах гомдолд улсын тэмдэгтийн хураамж дутуу, илүү эсхүл огт төлөөгүй байхад гомдлыг хүлээн авсан, хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргахдаа улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй байхад улсын төсөвт үлдээхээр шийдвэрлэсэн, улсын тэмдэгтийн хураамжаас үндэслэлгүйгээр чөлөөлсөн зэрэг олон төрлийн алдаа гаргаж байжээ.

## ДҮГНЭЛТ, САНАА

ИХШХШ тухай хууль ба Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн заалтууд, Улсын тэмдэгтийн хураамж гаргуулсан шүүхийн практикийг судлан үзэхэд дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1. ИХШХШ тухай хуульд заасан шүүхэд нэхэмжлэл гаргахад Улсын тэмдэгтийн хураамж төлвөл зохих этгээдэд “Маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд” гэсэн заалт нэмэх;

2. ИХШХШ тухай хуулийн 59.6-д нэхэмжлэлийг шүүх буцаах тухай заах ёстой байхад “нэхэмжлэгийг” шүүх буцаасан гэж алдаатай бичсэнийг залруулах;

3. ИХШХШ тухай хуулийн 116.2-т “шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна” гэж шүүхийн шийдвэрт тавих үндсэн хоёр шаардлагыг заасан ба хэргийг хяналтын шатаар дээр дурдсан үндэслэлийн нэг болох шийдвэр хууль ёсны болсон эсэх буюу шийдвэрийг зөвхөн эрх зүйн үндэслэл талаас нь (материаллаг болон процессын хуулийг зөв хэрэглэсэн эсэх) хянаж байгаа учир хэргийг Дээд шүүх хяналтын шатаар хянуулах гомдол гаргахад (Дээд шүүхийн Иргэний хэргийн танхим) Улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн 50%-иар төлдөг болох заалтыг ИХШХШ тухай хуульд оруулах;

4. ИХШХШ тухай хуулийн 176.5 дахь заалтаас үзэхэд хэргийг Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж хянуулахад урьдчилан Улсын тэмдэгтийн хураамж төлөх тухай байхгүй, энэ нь тухайн хэргийн хувьд эцсийн шийдвэр гарахгүй удаж чирэгдэл учирхад нөлөөлөх талтай тул Улсын тэмдэгтийн хураамж төлүүлэх тухай заалт ИХШХШ тухай хуульд нэмж оруулах;

5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7.1.2-т эд хөрөнгийн бүс, түүнчлэн үнэлж болохгүй нэхэмжлэлд Улсын тэмдэгтийн хураамж 70200 төгрөг төлөхөөр заасан нь үндэслэл муутай болсон. Учир нь 1993 оны 07 дугаар сарын 15-ны өдөр баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар дээрх төрлийн нэхэмжлэлийн Улсын тэмдэгтийн хураамж

250 төгрөг төлдөг байгаад шинээр 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд Улсын тэмдэгтийн хураамжийг 550 төгрөг гэж өөрчлөн зааснаа уг хуульд 8 сарын дараа 2010 оны 06 дугаар сарын 09-ний өдөр оруулсан өөрчлөлтөөр 70200 төгрөг болгож огцом нэмсэн нь одоогийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50% болж шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдол болгонд Улсын тэмдэгтийн хураамжид 70200 төгрөг төлүүлэхээр болжээ. Энэ нь зарим төрлийн нэхэмжлэлийн хувьд жишээ нь нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийн дагуу алга болж оргон зайлсан хариуцагчийг эрэн сурвалжуулах, бусдын нэр төрийг гутаасан мэдээ тараасан тохиолдолд нэр төрөө сэргээлгэх нэхэмжлэл гаргах зэрэг хэргүүдийн нэхэмжлэлд 70200 төгрөг төлөх нь зохисгүй болжээ.

Хаявралт №1

**Монгол Улсын төсөв ба шүүхийн төсвийн харьцуулсан судалгаа  
(2006-2011 он)**

| Он   | Улсын төсөв         | Улсын дээд шүүх | Шүүхийн ерөнхий төсөв | Шүүхийн төсөв    | УТ-өөс ШТ-ийн эзлэх хэмжээ (хувьар) |
|------|---------------------|-----------------|-----------------------|------------------|-------------------------------------|
| 2006 | 1.161.197,1 сая төг | 352,0 сая төг   | 3.789,14 сая төг      | 4.141,5 сая төг  | 0,39%                               |
| 2007 | 1.725.971,7 сая төг | 533,9 сая төг   | 6.056,5 сая төг       | 6.590,9 сая төг  | 0,38%                               |
| 2008 | 1.815.584,4 сая төг | 957,8 сая төг   | 12.325,3 сая төг      | 12.283,1 сая төг | 0,73%                               |
| 2009 | 2.200.942,8 сая төг | 850,5 сая төг   | 9.854,4 сая төг       | 9.819,3 сая төг  | 0,53%                               |
| 2010 | 2.101.200,0 сая төг | 971,3 сая төг   | 1.114,2 сая төг       | 12.113,5 сая төг | 0,50%                               |
| 2011 | 3.609.784,5 сая төг | 1.114,3 сая төг | 13.161,8 сая төг      | 14.309,1 сая төг | 0,40%                               |

Хавсралт №2

**Монгол Улсын шүүхээс 2002-2003 онд шийдсэн иргэний хэрэг,  
2004-2011 онд шийдсэн иргэн ба захиргааны хэрэгт нэхэмжлэл  
гаргахдаа төлсөн ба зохигчид буцаан олгосон  
Улсын тэмдэгтийн хураамжийн судалгаа**

| Он          | Улсын хэмжээнд                                      |                                           | Анхан шатны шүүх                                               |                                                                          |
|-------------|-----------------------------------------------------|-------------------------------------------|----------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|
|             | Иргэний хэрэгт<br>төлүүлсэн нийт УТХ<br>(төгрөгөөр) | Нийт буцаан олгохоор<br>шийдвэртэлсэн УТХ | Улс, орон нутгийн<br>төсөвт оруулахаар<br>шийдвэрлэ<br>сэн УТХ | ИХШХШТХ-ийн 59<br>дүгээр зүйлийн дагуу<br>буцаахаар шийдвэрлэ<br>сэн УТХ |
| <b>2002</b> | 555,5 сая төг<br>(УТХ+алданги<br>+ торгууль)        | =                                         | =                                                              | =                                                                        |
| <b>2003</b> | 975,4 сая төг                                       | =                                         | 855,3 сая төг                                                  | =                                                                        |
| <b>2004</b> | 1'015,2 сая төг                                     | =                                         | 1'006,5 сая төг                                                | =                                                                        |
| <b>2005</b> | 1'623,4 сая төг                                     | =                                         | 1'504,3 сая төг                                                | =                                                                        |
| <b>2006</b> | 1'302,4 сая төг                                     | =                                         | 1'183,4 сая төг                                                | =                                                                        |
| <b>2007</b> | 1'231,8<br>(-70,6) сая төг                          | =                                         | 1'115,2(-68,2) сая<br>төг                                      | =                                                                        |
| <b>2008</b> | 1'915,0<br>(+683,2) сая<br>төг                      | 519<br>сая төг                            | 1'530,9(+414,7) сая<br>төг                                     | 377,1(+103,1)                                                            |
| <b>2009</b> | 2'657,0<br>(743) сая төг                            | 788,1<br>сая төг                          | 2'049,0(+518,3)сая<br>төг                                      | 526,6(+149,5)<br>сая төг                                                 |
| <b>2010</b> | 2'426,8<br>(-231)сая төг                            | 774,1<br>сая төг                          | 1'970,0(-79,0) сая<br>төг                                      | 447,4(-79,2)сая<br>төг                                                   |
| <b>2011</b> | 2.417.6 сая төг                                     | 646.6<br>сая төг                          | 1.953 сая төг                                                  | 410.1 сая төг                                                            |

Хавсралт №3

**Монгол Улсын шүүхээс 2002-2003 онд шийдсэн иргэний хэрэгт,  
2004-2011 онд шийдсэн иргэн ба захиргааны хэрэгт давж заалдах,  
хяналтын шатны шүүхэд гомдол гаргахдаа төлсөн ба зохигчид  
буцаан олгосон Улсын тэмдэгтийн хураамжийн судалгаа**

| Он   | Давж заалдах шатны шүүх                              |                                                                | Хяналтын шатны шүүх                                  |                                                                |
|------|------------------------------------------------------|----------------------------------------------------------------|------------------------------------------------------|----------------------------------------------------------------|
|      | Улс, орон нутгийн төсөвт оруулахаар шийдвэрлэсэн УТХ | ИХШХШТХ-ийн 59 дүгээр зүйлийн дагуу буцаахаар шийдвэрлэсэн УТХ | Улс, орон нутгийн төсөвт оруулахаар шийдвэрлэсэн УТХ | ИХШХШТХ-ийн 59 дүгээр зүйлийн дагуу буцаахаар шийдвэрлэсэн УТХ |
| 2002 | =                                                    | =                                                              | =                                                    | =                                                              |
| 2003 | 52,1 сая төг                                         | =                                                              | 68,0 сая төг                                         | =                                                              |
| 2004 | 7 сая төг                                            | =                                                              | 1,7 сая төг                                          | 39 сая төг                                                     |
| 2005 | 77,3 сая төг                                         | =                                                              | 41,8 сая төг                                         | 38,5 сая төг                                                   |
| 2006 | 73,2 сая төг                                         | =                                                              | 45,8 сая төг                                         | 107,1 сая төг                                                  |
| 2007 | 76,0 (+2,8) сая төг                                  | =                                                              | 40,5 (-5,3) сая төг                                  | 13,4 (-93,7) сая төг                                           |
| 2008 | 323,4 (+247,4) сая төг                               | 80,3 сая төг                                                   | 61,6 (+20,9) сая төг                                 | 26,9 (+13,5) сая төг                                           |
| 2009 | 444,2(+120,1) сая төг                                | 243,9(+163,6) сая төг                                          | 164,4(+102,8) сая төг                                | 17,6 (-9,3) сая төг                                            |
| 2010 | 340,2 (-102,0) сая төг                               | 220,3 (-23,6) сая төг                                          | 116,6 (-47,8) сая төг                                | 106,4 (+89,0)                                                  |
| 2011 | 332,3 сая төг                                        | 144,0 сая төг                                                  | 132,2 сая төг                                        | 92,5 сая төг                                                   |

Хавсралт №4

**Монгол Улсын шүүхээс 2002-2003 онд шийдсэн иргэний хэрэг,  
2004-2011 онд шийдсэн иргэн ба захиргааны хэргийн Улсын  
тэмдэгтийн хураамж**

| Он   | Улсын төсөв            | Шүүхийн төсөв       | Иргэн, захиргааны<br>хэрэгт төлүүлсэн<br>УТХ | Эохигчид буцаан<br>олгосон УТХ | Улсын төсөвт<br>үлдсэн УТХ |
|------|------------------------|---------------------|----------------------------------------------|--------------------------------|----------------------------|
| 2002 |                        |                     | 555.5<br>сая төг                             |                                | 555.5<br>сая төг           |
| 2003 |                        |                     | 975.4<br>сая төг                             |                                | 975.40<br>сая төг          |
| 2004 |                        |                     | 1,015.2<br>сая төг                           | 39.0<br>сая төг                | 976.25<br>сая төг          |
| 2005 |                        |                     | 1,623.4<br>сая төг                           | 38.5<br>сая төг                | 1,584.90<br>сая төг        |
| 2006 | 1,161,197.1<br>сая төг | 4,141.5<br>сая төг  | 1,302.4<br>сая төг                           | 107.1<br>сая төг               | 1,195.30<br>сая төг        |
| 2007 | 1,725,971.7<br>сая төг | 6,590.9<br>сая төг  | 1,231.8<br>сая төг                           | 13.4<br>сая төг                | 1,218.40<br>сая төг        |
| 2008 | 1,815,584.4<br>сая төг | 13,283.1<br>сая төг | 1,915.0<br>сая төг                           | 484.3<br>сая төг               | 1,430.70<br>сая төг        |
| 2009 | 2,200,942.8<br>сая төг | 9,819.3<br>сая төг  | 2,657.0<br>сая төг                           | 788.1<br>сая төг               | 1,868.90<br>сая төг        |
| 2010 | 2,101,200.0<br>сая төг | 12,113.5<br>сая төг | 2,426.8<br>сая төг                           | 774.1<br>сая төг               | 1,652.70<br>сая төг        |
| 2011 | 3,609,784.5<br>сая төг | 14,309.1<br>сая төг | 2,417.6<br>сая төг                           | 646.6<br>сая төг               | 1,771.1<br>сая төг         |

○○○○○

○○○○○

○○○○○

## **Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн байдал**

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгаа\*

### **ОРШИЛ**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн байдалд эрх зүйн дүн шинжилгээ хийх судалгааны ажлын зорилго нь ашигт малтмалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэглэхэд учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох, түүнийг эрх зүйн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, улмаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгоход санал дэвшүүлэхэд оршиж буй юм.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд:

- Ашигт малтмалын хууль тогтоомж, түүний дотор тусгай зөвшөөрөлтэй холбоотой Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн маргааныг түүвэрлэх;

- Түүвэрлэсэн маргаанд эрх зүйн дүн шинжилгээ хийх;

- Шүүхийн шийдвэрт хийсэн эрх зүйн дүн шинжилгээ болон хууль тогтоомжийн зохицуулалтыг харьцуулах, түүний үндсэн дээр хуулиар зохицуулагдаагүй болон дутуу зохицуулагдсан, цаашид зохицуулах зайлшгүй шаардлагатай асуудал (харилцаа)-ыг тодорхойлох;

- Тодорхойлсон асуудлын чиглэлээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн орчинг сайжруулах санал боловсруулах гэсэн зорилт тавьсан.

Судалгаанд 2004-2009 онд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн ашигт малтмалын хууль тогтоомж (тусгай зөвшөөрөл)-той холбоотой маргааныг түүвэрлэн авсан.

Дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд судалгааны ажлын зорилтуудыг хэрэгжүүлэхэд социологийн судалгааны баримтын шинжилгээ, тоон

\* Судалгааг үндэслэн ХЗҮХ-ийн Эрэлтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор Б.Грибунзэг, МУИС-ийн ХЗС-ийн багш, хууль зүйн доктор Г.Банзрагч, ХЗҮХ-ийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрхлэгч, докторант Р.Мухийт, гүйцэтгэсэн ХЗҮХ-ийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Л.Амаржаргал.

- Тусгай зөвшөөрлийг авах "онцгой эрх"-тэй холбоотой маргаан;
- Тусгай зөвшөөрөлтэй холбоотой нөхөх олговрын маргаан;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийн хэрэгжилттэй холбоотой; маргаан (жишээ нь АМТЗ эзэмшигч нь хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас, тодруулбал захиргааны зөрчил гаргасны улмаас захиргааны хариуцлага хүлээсэнтэй холбоотой маргаан);
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд үүссэн хилийн маргаан (энэхүү маргааныг төрийн захиргааны байгууллага шийдэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд хандана) зэргээр ангилж болно.

5. Шүүхийн шийдвэрийн агуулга, үндэслэлийн талаар (Ашигт малтмалын тухай хуулийн ямар зүйл, заалтыг баримтлан хэрхэн шийдвэрлэсэн)

- Хүчингүй болгосон;
- Даалгасан ;
- Хохирол тогтоосон (нөхөх олговор гм.);
- Эрх зүйн харилцааг тогтоосон (анхдагч өргөдөл гаргагчаар тогтоосон, хөөн хэлэлцэх хугацааг сэргээсэн гм.);
- Хэрэгсэхгүй болгосон;
- Хүлээн авахаас татгалзсан буюу буцаасан;
- Нэхэмжлэгч, хариуцагч эвлэрсэн.

6. Ашигт малтмалын тухай хууль-ийг захиргаанаас хэрэгжүүлэхэд болон түүнтэй холбоотой маргааныг шүүхээс шийдвэрлэхэд учирч буй бэрхшээл

- Хуулиар огт зохицуулаагүй асуудал;
- Хуулиар дутуу зохицуулсан асуудал;
- Хуулиар ойлгомжгүй (хоёрдмол утгатай, бүрхэг) зохицуулсан асуудал.


7. Асуулга 6-аар тодорхойлсон асуудал нь одоо үйлчилж буй Ашигт малтмалын тухай хууль-иар (2009 оны) зохицуулагдсан эсэх, хэрэв тийм бол хэрхэн зохицуулсан, зохицуулалт хангалттай эсэх.

Энэхүү аргачлалын дагуу явуулсан эрх зүйн дүн шинжилгээний үндсэн дээр дараах асуудлыг тодруулахыг зорив. Үүнд:

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан нь нийт захиргааны маргаанд хэдэн хувь эзэлж байгаа;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааны төрөл буюу аль төрлийн тусгай зөвшөөрөлд илүү маргаан гарч буй;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой нэхэмжлэлийн шаардлагын агуулга, ямар маргаан илүү давамгайлж байгаа;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг

зөвшөөрлийг цуцлахтай холбоотой маргаан 21 байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон, шилжүүлсэн, сунгасан зэрэгтэй холбогдон гарсан аливаа шийдвэрийг хүчингүй болгохтой холбоотой маргаан 17, хайгуулын тусгай зөвшөөрлийн эрхийг сэргээхтэй холбоотой маргаан 16, хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан маргаан 15 байна. Харин хайгуулын зөвшөөрлийг давхардуулан олгосон хилийн маргаантай хэрэг 9, тусгай зөвшөөрөл барьцаалсантай холбоотой маргаан 5, бусад маргаан тус бүр 1-2 байна. (График 2)

График 2



Үүнээс үзвэл ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааны хувьд дараах нэхэмжлэлийн шаардлага (тусгай зөвшөөрөл олгохыг шаардах) давамгайлах онцлог шинжтэй байна. Мөн гуравдагч этгээдийн зүгээс гаргах нэхэмжлэл (тусгай зөвшөөрөл олгосон, шилжүүлсэн, сунгасан шийдвэрийг хүчингүй болгоход чиглэсэн) багагүй хувийг эзэлж байна. Түүнчлэн тусгай зөвшөөрлийг олгох, цуцлахаас гадна хугацаа сунгахтай холбоотой маргаан нэлээд өндөр хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

Нийт 44 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаанаас нэхэмжлэлийн шаардлагаар нь ангилж үзвэл ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой маргаан 20 буюу хамгийн их, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбогдон гарсан шийдвэрийг хүчингүй болгох маргаан 10 байна. (График 3)

Гэхдээ маргаан бүрийн бүрэлдэхүүн, тохиолдол харилцан адилгүй байна.



хуудас тус бүрт бүртгэлийн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх зэргээр өргөдлийг бүртгэх ажиллагааг явуулахыг заасан байхад энэ хуулийн заалтыг зөрчсөн нь тогтоогдсон тул нэхэмжлэлийн шаардлагыг хангажээ. Тодруулбал, А компанид олгосон хайгуулын тусгай зөвшөөрөл нь журам зөрчсөн формаль эрх зүйн алдаатай акт байсан тул шүүх хүчингүй болгожээ. Уг алдаа нь захиргааны буруутай үйл ажиллагааны улмаас үүсчээ.

Ксүс 2

**Х компанийн өргөдлийг ГУУКГ-ын мэргэжлэтэн бүртгэлийн дэвтэрт бүртгэж, үйлчилгээний хөлсөнд 250 000 төгрөг авсаныг тодорхойлсон баримт өгч, бүртгэж авсан гэсэн тодорхойлолт өгсөн атлаа өргөдөл гаргагчаар өргөдлийн дэвтэрт гарын үсэг зуруулаагүй. Иймээс Х компанийн материалыг алга болсон гэж үзэн А компанийг бүртгэсэн байна. Үүний эсрэг Х компани түүний өргөдлийг бүртгээгүй нь захиргааны хууль бус эс үйлдэхүй гэж үзэн нэхэмжлэл гаргажээ.**

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхээс материал алга болсонд өргөдөл гаргагч буруутүй, гарын үсэг зуруулах нь захиргааны байгууллагын үүрэг учир захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны (үйлдэл, эс үйлдэхүй) улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн учир нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.

Гэтэл Хяналтын шатны шүүхээс дээрх үйл ажиллагааг захиргааны байгууллагын эс үйлдэхүй биш гэж үзэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон шийдвэр гаргажээ. Эндээс шүүх харилцан адилгүй шийдвэр гаргаж байгаа нь харагдаж байна. Х компанийн өргөдлийг бүртгээгүй нь хуулийн зохицуулалтаас бус захиргааны хууль зөрчсөн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахтай холбоотой маргаан маш их байна. Ашигт малтмалын тухай хуулийн 22.2-т “Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 22.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтааж тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 7.2, 31 дүтээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянаж, зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг энэ хуулийн 21.1.5-д заасан хугацаагаар сунгаж энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ” гэж заасан.

дуусахад хүргэжээ.

Эндээс дүгнэхэд төрийн захиргааны байгууллага хуулийг буруу ойлгож, буруу хэрэглэж, хуульд заасан хугацааг баримтлахгүйн улмаас иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигджээ.

Энэ тохиолдолд захиргааны актын алдааны шалтгаан нь хуулийн заалтад бус харин түүнийг захиргаанаас санаатай болон санаандгүй байдлаар буруу ойлгож, хэрэглэхэд оршиж байна.

#### Кейс 4

Г компани тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар ГУУКГ-д өргөдлөө өгөхдөө байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хавсаргаагүй өгсөн. Учир нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг батлуулахаар сумын Засаг даргад өгсөн байсан боловч сумын Засаг дарга ээлжийн амралтаа аваад тухайн орон нутагт байхгүй байж таараад төлөвлөгөөг хугацаанд нь батлуулж чадаагүй байна. Гэтэл ГУУКГ байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө дутуу байна гэсэн үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ.

Энэхүү маргааныг шүүх дараах байдлаар шийдвэрлэжээ. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахаар гаргасан өргөдөлд Ашигт малтмалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө хавсаргагдаагүй байжээ. Г компани байгаль орчныг хамгаалах шинэчилсэн төлөвлөгөөг батлуулахаар сумын Засаг даргад хүргүүлсэн боловч тухайн Засаг дарга ээлжийн амралтаа авч, орон нутагтаа байгаагүйгээс Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасан үүргээ биелүүлээгүй болох нь хэрэгт авагдсан албан бичгээр тогтоогдсон байна. Иймд Г компанийг дээрх хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан үүргээ биелүүлээгүй гэж буруутгах үндэслэлгүй болно. Ашигт малтмалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.4-т тусгай зөвшөөрөл эзэмшигч мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол тусгай зөвшөөрлийг сунгахаас татгалзаж болохоор заасан байхад ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, КАДАСТРЫН ГАЗАРЫН дарга өргөдөлд хавсаргах баримт бичиг дутуу гэсэн хуульд заагаагүй үндэслэлээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзаж Г компани эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байна гэж үзээд Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 22 дугаар зүйлийн 22.2, 22.4-т заасныг баримтлан нэхэмжлэгчийн шаардлагыг хангажээ.

судалгааны арга болон эрх зүйн харьцуулалтын, кейс (тохиолдол) судалгааны аргыг хэрэглэсэн. Эрх зүйн дүн шинжилгээг дараах үе шат, аргачлалын дагуу явуулав.

#### *I. Бэлтгэл ажил*

1. 2004-2009 онд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн ашигт малтмалын хууль тогтоомжийн хүрээнд үүссэн маргааныг түүвэрлэж, он оноор нь ангилах;

2. Түүвэрлэсэн маргаанаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл (бүх төрлийн лиценз)-тэй холбоотой маргааныг ангилах;

3. Ашигт малтмалын тухай хууль-иас тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээг түүвэрлэх;

4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой хэм хэмжээний акт байгаа эсэхийг тодруулах, байгаа бол түүвэрлэх.

#### *II. Шүүхийн шийдвэрийг судлах ажил*

Түүвэрлэсэн маргаанд дараах асуулгаар эрх зүйн шинжилгээ хийсэн:

1. Хэдэн онд шийдвэрлэгдсэн болох (хэдэн оны Ашигт малтмалын тухай хуулийг хэрэглэсэн);

2. Нэхэмжлэгч нь хэн болох

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч (эзэмшиж байсан, болон эзэмшихийг хүсэж буй этгээд);

- Гуравдагч этгээд (эрх нь хөндөгдсөн).

3. Маргааны зүйл юу болох

- ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл;

- ашиглалтын тусгай зөвшөөрөл ;

- бусад зөвшөөрөл, акт (жишээ нь нөхөн төлбөр олгосон, давхцыг тогтоосон акт гм.).

4. Маргааны агуулга ямар болох

- Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой;

- Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсантай холбоотой;

- Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахтай холбоотой;

- Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэнтэй холбоотой;

- Тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгосонтой холбоотой;

- Тусгай зөвшөөрлийг шилжүүлсэнтэй холбоотой;

- Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаан өгөхтэй холбоотой маргаан;

- Тусгай зөвшөөрлийг үргэлжлүүлэн эзэмших “давуу эрх”-тэй холбоотой;

шийдвэрлэсэн байдал (нэхэмжлэлийн шаардлагыг хангасан эсэх);

- Маргаан гарч буй шалтгаан нь юу болох, хууль буруу хэрэглэсэнээс үү, эсвэл хуулийн зохицуулалт дутуу, бүрхэг, байхгүйгээс үүсэж байна уу;


- Шалтгааныг шийдвэрлэх ямар арга зам байгаа гэх мэт.

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ДАХЬ ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ

2004-2009 оны хооронд Захиргааны хэргийн шүүхээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой нийт 188 хэрэг шийдвэрлэсэн нь нийт захиргааны маргаанд 5 жилийн дундажаар 7,6 хувийг эзэлж байгаа нь үүсэж буй маргаанд эзлэх хувийн жин нь харьцангуй бага байна.


188 хэргээс хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан нь 144, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан 44 байгаагаас үзэхэд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан илүү давамгайлж байна. (График 1) Энэ нь ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд нь хайгуулын үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдтэй харьцуулбал харьцангуй бага байдагтай холбоотой байж болох талтай.

График 1



Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг агуулгаар нь ангилж авч үзвэл хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой маргаан 29 буюу хамгийн их байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахтай холбоотой маргаан 23 байхад харин хайгуулын тусгай

График 3



Ашигт малтмалын тухай хуулийн 19.1, 19.1.4, 19.2 зэрэг заалтыг баримтлан шийдсэн хэрэг нэлээд байна. Үүнтэй холбогдох хэргийг жишээ болгон авч үзье.

## Кейс 1

С компани хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар ГУУКГ-т өргөдөл өгсөн. ГУУКГ өргөдлийг хүлээн авч бүртгэсэн. Өргөдөл гаргагч хоёр хоногийн дараа өргөдлөө шалгахад өргөдөл нь бүртгэлд байхгүй өөрийнх нь дугаар дээр өөр өргөдөл бичсэн байсан. Өргөдөл гаргагч ГУУКГ-ын мэргэжилтнээс тодруулахад “материал нь байхгүй болохоор андуурч буруу өргөдөл бүртгэсэн юм байх гэж бодоод дараагийн өргөдлийг урагшуулж бүртгэсэн” гэж тайлбарлажээ. Бүртгэл нь урагшилсан А компани хайгуулын тусгай зөвшөөрөл авсан байна. С компани өөрийн дугаар дээр бүртгэгдэж хайгуулын тусгай зөвшөөрөл авсан А компанид гаргасан шийдвэрийг хүчингүй болгохоор шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Энэ тохиолдлыг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхээс шийдэхдээ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, КАДАСТРЫН ГАЗАР Ашигт малтмалын тухай хуулийн 19.1.1-дэх хэсэгт зааснаар өргөдлийг “Өргөдөл бүртгэх дэвтэр”-т бүртгэж өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн

Хуулийн энэхүү зүйл, заалтыг хэрэглэсэнтэй холбоотой олон маргаан үүсжээ.

*Кейс 3*

Нэхэмжлэгч “Н” ХХК ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 2008 оны 05 дугаар сарын 20-ныг дуустал хугацаагаар эзэмших эрхтэй байсан бөгөөд уг тусгай зөвшөөрлийг сунгуулах өргөдлийг 2008 оны 05 дугаар сарын 02-нд Геологи уул уурхайн кадастрын газарт өгч бүртгүүлсэн. “Н” ХХК тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө лицензийн төлбөр 887 ам.доллар, лиценз сунгуулах үйлчилгээний хөлс нэг сая төгрөгийг 2008 оны 04 дүгээр сарын 24-нд төлснийг Геологи, уул уурхайн кадастрын газар 05 дугаар сарын 02-нд хүлээн авч төлбөр төлсөн тодорхойлолт өгчээ. Гэтэл ГУУКГ нь 07 сарын 09-нд Ашигт малтмалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтыг үндэслэн өргөдлийг бүртгэлээс хасах шийдвэр гаргажээ.

Ашигт малтмалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 заалтын дагуу ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, КАДАСТРЫН ГАЗАР нь өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг хянаад зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг мөн хуулийн 21.1.4-т заасан хугацаагаар сунгах ёстой байтал өргөдлийг бүртгэлд авснаас хойш 2 сар 7 хоногийн дараа хасахаар шийдвэрлэсэн нь хуульд заасан журмыг зөрчсөнөөс гадна хууль буруу хэрэглэсэн шийдвэр байна. Учир нь ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, КАДАСТРЫН ГАЗАРЫН энэхүү шийдвэрийн үндэслэл болгосон Ашигт малтмалын тухай хуулийн 22.2 дахь заалт нь лицензийн хугацаа сунгуулах өргөдлийг хугацаа хожимдуулж гаргасан бол өргөдлийн бүртгэлээс хасах зохицуулалт биш, харин өргөдлийг хүлээн авч, хянан шийдвэрлэх журмыг зохицуулсан заалт байна.

Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлийн газар нь нэхэмжлэгчийн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших хуульд заасан хугацаа дуусаагүй, тусгай зөвшөөрөл эзэмших эрхээ хадгалж байгаа үедээ гаргасан лицензийн хугацаа сунгуулах өргөдлийг хуульд заасан 10 хоногт нь багтаан шийдвэрлэлгүйгээр удаасны эцэст хугацааг сунгалгүй өргөдлийг 2008 оны 7 дугаар сарын 09-нд бүртгэлээс хассаны улмаас нэхэмжлэгч “Н” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацаа хүчин төгөлдөр байх хугацаа

## Кейс 5

“А” ХХК нь Б аймгийн Г сумын нутагт орших Д гэдэг газар 11111.Х тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд түүний хугацаа нь 2007 оны 8 сарын 5-ны өдөр хүртэл хүчинтэй. А тусгай зөвшөөрлийг эзэмших хугацаандаа хуульд заасан үүргээ биелүүлж ирсэн. Тэрээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай өргөдлөө 2007 оны 8 сарын 6-ны өдөр гаргасан байна. Учир нь 2007 оны 8 сарын 5-ны өдөр нь амралтын өдөр байсан. Гэтэл АМХЭГ-ийн Кадастрын бүртгэлийн төв А-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан. Үндэслэлээ тайлбарлахдаа, А нь АшМтХ-ийн §22.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс нэг сарын өмнө хүсэлтээ гаргах ёстой байтал үүнийг зөрчсөн. А-ийн тусгай зөвшөөрлийн хугацаа 2007 оны 8 сарын 5-ны өдөр дууссан тул АшМтХ-ийн §53.1.1-ийн түүний тусгай зөвшөөрөл дуусгавар болсон. Иймд нэгэнт дуусгавар болсон тусгай зөвшөөрлийг сэргээн сунгах хууль зүйн үндэслэл байхгүй тул татгалзсан шийдвэр хууль ёсны гэжээ. А үүнийг эсэргүүцэн Захиргааны хэргийн шүүхэд Кадастрын бүртгэлийн төвийн татгалзсан шийдвэрийг хүчингүй болгох, түүний тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахыг даалгах нэхэмжлэл гаргажээ.

Шүүх хэргийг шийдвэрлэхдээ ИХ-ийн §72.2-т “тоолох хугацааны эцсийн өдөр ажлын бус өдөр байвал түүний дараагийн ажлын өдөр уг хугацаа дуусна” гэсний дагуу нэхэмжлэгч тусгай зөвшөөрлөө дуусгавар болохоос өмнө хугацаа сунгуулах өргөдөл гаргажээ.

ААҮАТЭТХ-ийн §6.4-т “тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй”, Ашигт малтмалын тухай хуулийн §22.4-т “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй бол төрийн захиргааны байгууллага хугацаа сунгахаас татгалзаж, энэ тухай өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, тусгай зөвшөөрлийн бүртгээд тэмдэглэнэ”, мөн хуулийн §53.1.1-т “тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бол тусгай зөвшөөрөл дуусгавар болно” гэсэн заалтуудыг Кадастрын бүртгэлийн төв зөрчиж, А-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзжээ.

Иймд Хариуцагчийн татгалзсан шийдвэрийг хүчингүй болгож, А-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахыг Кадастрын бүртгэлийн төвд даалгахаар шийджээ.

Дээрх тохиолдолын хувьд хугацаа тоолох асуудал дээр захиргаа хууль буруу тайлбарласан алдаа гарсан боловч А ХХК нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах өргөдлөө хугацаа дуусахаас 1 сарын өмнө бус бүр дуусах өдрөө гаргасан нь Ашигт малтмалын тухай хуулийн 22.1 зүйлд заасан журмыг зөрчсөн. Гэвч энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх санкцыг хуулиар тодорхой заагаагүйгээс шалтгаалан хэдийгээр өргөдөл гаргагч нь хугацаа хэтрүүлсэн байх боловч энэ нь тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болохгүй байгаа тул иймэрхүү төрлийн маргааныг шүүхээс шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг дандаа хангаж шийдвэрлэжээ.

Иймээс захиргаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 22.1-д заасан журмыг бодит байдалд хэрэгжүүлэх зорилгоор Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 181 дүгээр тушаалаар батлагдсан журам гарснаас хойш тусгай зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн тохиолдолд 1-2 сая төгрөгөөр торгох санхүү хүлээлгэх болсоноос хойш энэ төрлийн маргаан гарахаа больсон. Гэтэл саяхан энэхүү журмыг хууль бус хэм хэмжээний акт гэж хүчингүй болгожээ. Иймд дахин ийм төрлийн маргаан үүсэх нөхцөл бүрдээд байна.

**Ашигт малтмалын тухай хуулийн 18.1-т “Энэ хуулийн 7.1, 17.2-т заасан шаардлага хангасан бөгөөд хамгийн түрүүнд өргөдөл гаргаж бүртгүүлсэн этгээдэд хайгуулын тусгай зөвшөөрөл олгоно” гэсэн заалтаар хэн нь түрүүлж өргөдөл гаргасан бэ гэдэгт маргаан үүсдэг практик их байна.**

#### Кейс 6

“Х” ХХК нь Өмнөговь аймгийн “Нүүрст хөтөл” нэртэй газарт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар 2008 оны 7 дугаар сарын 23-ны өдөр өргөдлөө АМГТХЭГ-ын ГУУКГ-т өгсөн. “П” ХХК 2008 оны 07 дугаар сарын 24-ний өдөр ГУУКГ-т өргөдөл өгсөн. Дээрх компаниудын өргөдөл гаргасан талбайг Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2008 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 72 дугаар тогтоолоор аймгийн тусгай хэрэгцээний газраас чөлөөлж, уг 72 дугаар тогтоолыг 2008 оны 07 дугаар сарын 23-ны өдөр албан бичгээр Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын Геологи, уул уурхай, кадастрын газарт хүргүүлснийг тус төвийн бичиг хэрэг 2008 оны 07 дугаар сарын 24-ний өдөр бүртгэж, мэдээллийн сан, зураг зүйн бүртгэл хариуцсан албан тушаалтанд 07 дугаар сарын 28-нд шилжүүлжээ. Гэтэл ГУУКГ



7 дугаар сарын 24-ний өдөр бичиг хэрэгт ирж бүртгүүлсний дараа өргөдөл өгсөн учир “П”ХХК-гийн өргөдлийг хамгийн түрүүнд өгсөн гэж үзээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгожээ.

Дээрх тохиолдлыг дүгнэхэд “хамгийн түрүүнд өргөдөл гаргасан” гэдгийг захиргаа янз бүрээр тайлбарлан хэрэглэсэн. Тухайлбал, захиргааны хувьд тусгай хэрэгцээнээс гарсанаас хойш (2008 оны 7 дугаар сарын 22-ноос хойш) тооцох, эсхүл уг шийдвэрийг хүргүүлснээс хойш (2008 оны 7 дугаар сарын 23-наас хойш) тооцох, эсхүл уг шийдвэрийг хүлээн авч бүртгэснээс хойш (2008 оны 7 сарын 24-нөөс хойш) тооцох гэсэн хэд хэдэн боломж байна. Гэвч хуулийн нэг заалтыг өөр өөрөөр тайлбарлаж хэрэглэх ёсгүй. Иймд хуулийн энэхүү тодорхой бус ойлголтыг тодорхой болгох шаардлагатай юм. Учир нь хуульд “тусгай хэрэгцээний газраас чөлөөлсөн шийдвэрийг бичиг хэрэгт бүртгэсний дараа өргөдөл өгсөн бол хамгийн түрүүнд гэж үзэх, харин бүртгүүлэхээс өмнө өгсөн бол хамгийн түрүүнд гэж тооцохгүй гэсэн агуулга байхгүй. Гэхдээ энэ тохиолдолд захиргааны байгууллага уг зүйл заалтыг өөр өөрөөр ойлгож хэрэглэх бололцоо байгааг засах шаардлагатай.

Ашигт малтмалын тухай хуулийн 56.2-т “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 5 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрлийг цуцлах болсон үндэслэлийг тодорхой заана” гэсэн заалтад төрийн захиргааны байгууллага ажлын 5 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэл өгнө гэснийг цуцалсан хойно нь сонинд мэдэгдэхийг ойлгож энэ заалтыг ихээр зөрчсөн тохиолдол гарч байна.

### Кейс 7

Иргэн Б өөрийн нэр дээр байгаа хайгуулын тусгай зөвшөөрлөө 2006 онд Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт орж зөвхөн хуулийн этгээд ашигт малтмалын лиценз эзэмших болсонтой холбогдуулан өөрийн эзэмшиж байсан лицензийг компанийхаа нэр дээр шилжүүлэхээр ГУУКГ-д өргөдөл өгсөн. ГУУКГ өргөдлийг хүлээж аваад шилжүүлэх өргөдлийн бүртгэлд бүртгэсэн. Гэтэл ГУУКГ төлбөрөө хугацаа хожимдуулж төлсөн гэдэг үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцалсан. Ингэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэл өгөөгүй. Тусгай зөвшөөрлийг цуцалсан талаар сонинд нийтэлснээ мэдэгдсэн гэж үзсэн.

Энэ тохилдлыг тайлбарлавал, Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа жилийн төлбөрийг тухайн тусгай зөвшөөрлийг олгосон өдрөөс эхлэн тооцож жил бүр урьдчилан төлнө" гэж заасныг үндэслэж ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, КАДАСТРЫН ГАЗАР хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг цуцалхаар шийдвэрлэхдээ мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т "Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 5 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрөл цуцлах болсон үндэслэлийг тодорхой заана" гэсэн заалтуудыг зөрчиж мэдэгдэл өгөөгүй. Мөн түүнчлэн тус хуулийн 56.3-т "Энэ хуулийн 56.2-т заасан мэдэгдэлд заасан үндэслэлийг зөвшөөрөхгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигч түүнийгээ нотлох баримт бичгийг төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ", 56.4-т "Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 56.3-т заасан баримт бичгийг хянаж үндэслэлтэй бол тусгай зөвшөөрлийг цуцлах тухай мэдэгдлийг хүчингүй болгох ба үндэслэлийг бол тусгай зөвшөөрлийг цуцалж эдгээр шийдвэрийг эзэмшигчид нь мэдэгдэнэ" гэж заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн лицензээ хүчинтэй байлгах хуулиар олгогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхалыг хөндсөн байна. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, КАДАСТРЫН ГАЗАР тусгай зөвшөөрлүүдийг цуцлах үндэслэл, цуцалсан тухай сонинд тус тус нийтэлж нэхэмжлэгчид мэдэгдсэн гэж тайлбарлаж байгаа боловч сонинд нийтлэх гэдэг нь нийтэд мэдээлэхээр хуульчилсан болон зайлшгүй сонордуулах шаардлагатай гэж үзсэн мэдээллийг хүргэх ойлголт бөгөөд өөрөөр хэлбэл мэдэгдэх гэдэг нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн тусгай зөвшөөрлийг эзэмших эрхтэй холбоотой мэдэгдлийг түүнд өөрт нь албан ёсоор мэдэгдэхийг хуулиар зохицуулсан.

Иймд хариуцагчаас гаргасан шийдвэр эсхүл түүний утгыг илэрхийлсэн мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид биечлэн гардуулсан, эсхүл баталгаат шуудангаар хүргүүлсэн, факс, и-мэйл, цахилгаан зэргээр мэдээлж түүнийгээ баталгаажуулсан баримт байхгүй байх тул тусгай зөвшөөрлүүдийг цуцлах үндэслэл, цуцалсан тухай нэхэмжлэгчид мэдэгдсэн гэж үзэх үндэслэлгүй байна. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, КАДАСТРЫН ГАЗАР тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.6-д заасан "Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 49.5-д заасан ажиллагааг өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэх", 49.6.2-т "өргөдөл нь энэ зүйлд заасан шаардлагыг хангаагүй бол нэмэлт мэдээлэл ирүүлэхийг өргөдөл гаргасан этгээдээс шаардах" гэсэн заалтуудыг зөрчиж

өргөдлийг бүртгэхдээ тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлсөн эсэх, төлүүлж зөрчлийг арилгах талаар ажиллагаа хийгээгүй, тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл улмаар цуцалсан болон шинэчилэн бүртгэсэн хоёр өөр шийдвэр гаргасан тухай ямарч мэдээллийг нэхэмжлэгчид мэдэгдээгүй зэргээр хууль зөрчиж сонордуулах шаардлагатай гэж үзсэн мэдээллийг хүргэх ойлголт бөгөөд өөрөөр хэлбэл мэдэгдэх гэдэг нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн тусгай зөвшөөрлийг эзэмших эрхтэй холбоотой мэдэгдлийг түүнд өөрт нь албан ёсоор мэдэгдэхийг хуулиар зохицуулсан.

Захиргааны актыг мэдэгдэхтэй холбоотой маргаан багагүй гарч байсан (жишээ нь байгууллагын самбарт тавихыг "нийтэд мэдээлэх"-д тооцох эсэх гм.) боловч энэ талаар Улсын дээд шүүхийн 2010 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 09 тоот тогтоолоор "нийтэд мэдээлэх" гэдгийг "өдөр тутмын сониноор нийтэд мэдээлснээс хойш" хэмээн тайлбар гарснаар уг асуудал харьцангуй тодорхой болсон.

Тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой журмыг зөрчсөний улмаас шүүхээс захиргааны тусгай зөвшөөрөл цуцалсан шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол цөөнгүй байгаа нь анхаарал татаж байна. Нэгэнт хуульд заасан журмыг зөрчсөн бол шүүх захиргааны актыг хүчингүй болгох нь зүйтэй. Гэхдээ бодит байдалд тусгай зөвшөөрөл эзэмшигч үүргээ биелүүлээгүйг тогтоосон, энэ нь зөвшөөрөл цуцлах үндэслэл болж байгаа боловч журам (Аш.МтХ-ийн §56) зөрчсөний улмаас (жишээ нь, 5 хоногтоо багтаан шийдвэрлээгүй гм.) цуцалсан шийдвэр хүчингүй болох нь эргээд хууль зөрчигчдөд боломж олгох сөрөг талтай. Иймд тусгай зөвшөөрлийг цуцлах журмыг боловсронгуй болгох (жишээ нь хугацааг нэмэх) шаардлагатай юм.

Харин "төлбөрөө хугацаа хожимдуулж төлсөн" гэдэг үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцалсан нь хууль ёсны эсэхэд шүүх тайлбар хийгээгүй. Аш.МтХ-ийн 31.1. "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 32, 33 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд зөрчвөл мөн хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцална" гээд 32.1-т "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг энэ хуулийн дагуу жил бүр төлнө", 34.2. "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа жилийн төлбөрийг тухайн тусгай зөвшөөрлийг олгосон өдрөөс эхлэн тооцож жил бүр урьдчилан төлнө" гэжээ. Хэрэв 34 зүйлийг 32.1-ийг тодруулсан заалт гэж үзвэл төлбөрөө хугацаанд нь төлөөгүй нь 31.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл цуцлах үндэслэл болох боломжтой байна. Хэрэв болохгүй гэж үзвэл Аш.МтХ-ийн 34 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах механизм нь, өөрөөр хэлбэл зөрчсөн тохиолдолд хүлээлгэх санцр нь тодорхойгүй байна.

Кейс 8

АМХЭГ-аас Б-ийн хайгуулын тусгай зөвшөөрлийг ААҮАТЭТХ-ийн §14.1.3-ыг үндэслэн хүчингүй болгожээ. Б үүний эсрэг “захиргаа хуульд заагаагүй үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон нь хууль бус” гэсэн үндэслэлээр уг шийдвэрийг хүчингүй болгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Хариуцагч тайлбартаа, АшМТХ-ийн 56 дугаар зүйлд тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэлийг зохицуулсан боловч үүнд “тусгай зөвшөөрөл авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон бол” хүчингүй болгох талаар заагаагүй. Гэхдээ энэ үндэслэл нь ААҮАТЭТХ-ийн §14.1.3-д байдаг тул үүнийг хэрэглэсэн. Иймд хууль зөрчөөгүй гэжээ.

Шүүх АМХЭГ-ын шийдвэрийг хүчингүй болгосон бөгөөд шийдвэрээ үндэслэхдээ ААҮАТЭТХ-ийн §2.3-ийн дагуу байгалийн баялагийг ашиглахтай холбоотой олгох зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хууль-нар зохицуулахаар заажээ. Иймд захиргаа хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэн Б-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон нь хууль зөрчсөн алдаатай шийдвэр тул хүчингүй болгох үндэслэлтэй гэжээ.

Дээрх тохиолдлын хувьд үндсэн хоёр асуудал хөндөгдөж байна. Үүнд:

1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг зөвхөн Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлээр цуцлах үндэслэлтэй эсэх, өөр үндэслэлээр цуцалж болох эсэх;

2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаанд зөвхөн тусгай хууль хэрэглэх үү, ААҮАТЭТХ (ерөнхий хууль)-ийг хэрэглэж болох эсэх гэсэн асуудлууд үүсэж байна.

Тусгай зөвшөөрлийг зөвхөн Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан таван үндэслэлээр л цуцална гэсэнтэй санал нийлэх боломжгүй юм. Учир нь уг хуулийн бусад зүйл заалтаар тусгай зөвшөөрлийг цуцлах боломжтой болох нь тодорхой байдаг. Жишээ нь, Ашигт малтмалын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3, 66 дугаар зүйлийн 66.4 дэх заалтаар цуцлах боломжтой байна. Түүнээс гадна Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийг үзвэл:

56.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангахгүй болсон;

56.1.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөөгүй;

56.1.3.хайгуулын болон уурхайн талбайг энэ хуулийн 13.1.3-т заасны дагуу нөөц болон тусгай хэрэгцээнд авч, эсхүл тухайн талбайд ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглож нөхөх олговрыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн төлсөн;

56.1.4.тухайн жилд гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардал нь энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс бага бол;

56.1.5.тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлэггүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан бол цуцлахаар заажээ.

Дээрх 5 нөхцөл нь бүгд хууль ёсны захиргааны актын үйлчлэлийг дуусгавар болох буюу цуцлах үндэслэл болж байна. Тодруулбал, тусгай зөвшөөрөл (захиргааны акт) нь анхнаасаа хууль ёсны дагуу олгогдсон, өөрөөр хэлбэл эрх зүйн алдаагүй акт юм. Гэвч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн буруугаас буюу хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс эсхүл хуульд заасан тусгай нөхцөл байдлын улмаас (жишээ нь газрыг тусгай хэрэгцээнд авах §56.1.3) тухайн актын үйлчлэлийг дуусгавар болгох (цуцлах<sup>1</sup>) нөхцөл үүсэх нь байна.

Тэгвэл тусгай зөвшөөрлийг анхнаасаа хууль зөрчиж олгосон, өөрөөр хэлбэл, алдаатай захиргааны акт гарсан бол хэрхэх талаар асуулт үүсэж байна.

Зарчмын хувьд захиргаа нь актын алдааг хожим нь (алдаатай актад гомдол гаргах хугацаа өнгөрч хүчин төгөлдөр болсон хойно нь ч) засах боломжтой, зарим тохиолдолд үүрэгтэй байдаг. Жишээ нь, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлд Газар эзэмшүүлэхэд тавигдах шаардлагыг зохицуулсан.<sup>2</sup> Энэхүү газар эзэмшүүлэхэд тавих шаардлагыг зөрчсөн бол (жишээ нь газрыг давхардуулан олгосон) уг шийдвэр нь хууль зөрчсөн буюу алдаатай захиргааны акт болох бөгөөд үүнийг эрх бүхий этгээд (захиргаа өөрөө, эсхүл шүүх) хүчингүй болгох эрхтэй. Гэхдээ энэхүү үндэслэл нь Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйл буюу Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох нөхцөлд заагаагүй.<sup>3</sup>

<sup>1</sup> Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрлийг "хүчингүй болгох" гэсэн нэр томъёо хэрэглэгдээгүй, зөвхөн "цуцлах", "дуусгавар болох" гэсэн үгийг хэрэглэсэн байдаг.

<sup>2</sup> 31.1. Газар эзэмших хүсэлт гаргагч нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байна.

31.2. Хүсэлт гаргасан газрын байршил нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар эзлэйн байгуулалтын төлөвлөгөөнд нэгж, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болохоор заагдсан байна.

31.3. Хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшинг, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна.

<sup>3</sup> 40.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараах тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно:

40.1.1. эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл,

Иймд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь анхнаасаа алдаатай, хууль зөрчиж олгогдсон бол эрх бүхий этгээдээс (жишээ нь дээд шатны захиргааны байгууллагаас) түүнийг хүчингүй болгох боломжтой. Жишээ нь, Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлд Хайгуулын тусгай зөвшөөрөл авахад тавих шаардлага<sup>4</sup>, 18.2 дугаар зүйлд Хайгуулын тусгай зөвшөөрөл авах, өргөдөл гаргахад хавсаргах баримт бичгийг зохицуулсан. Гэтэл эдгээр шаардлагыг зөрчиж (зөрчил нь захиргааны буруутай үйл ажиллагаа байж болно, эсхүл өргөдөл гаргагчийн буруутай үйл ажиллагаа ч байж болно, тухайлбал өргөдөл гаргагч анхнаасаа хуурамч баримт бичиг бүрдүүлэн хүсэлт гаргасан, түүнийг нь захиргаа мэдэлгүй зөвшөөрөл олгосон бол) тусгай зөвшөөрлийг олгосон болохыг нь тогтоосон тохиолдолд түүнийг эрх бүхий этгээд хүчингүй болгох боломжтой.

Мөн захиргаа өөрөө тусгай зөвшөөрөл олгох журмаа зөрчиж олгосон бол түүнийг хүчингүй болгох үндэслэлтэй. Тодруулбал, захиргаа Ашигт малтмалын тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан журмыг зөрчсөн бол дээд шатны захиргааны байгууллагаас эсхүл захиргааны хэргийн

бэлэлцэж удаа дараа буюу нэгдүгээр зөрчсөн;

40.1.2. газрыг хүн амын зүүд, байгаль хамгаалах, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харишаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

40.1.3. шилжүүлж авсан эрхийн гэрчилгээг улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

40.1.4. байгаль орчинд нөлөөлөх байдлын үндэслэлээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй;

40.1.5. эрхийн гэрчилгээг хэвшинг газрын төлбөрөө хутагтаанд нь бүрэн төлсөнгүй;

40.1.6. худалттан үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараахан ашиглаагүй.

<sup>4</sup> 17.1. Энэхүү хуулийн 7.1-д заасан шаардлага хангасан этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл авал өргөдөл гаргах бөгөөд түүнд хайгуулын талбайн байршил, түүний булангийн цэгийг төрийн захиргааны байгууллагаас гаргасан нэг загварын газрын зураг дээр тэмдэглэж, солбицуулах гравис, минут, секундээр тодорхойлж хавсаргана.

<sup>5</sup> 17.2. Өргөдөлд дурдсан хайгуулын талбай дараах шаардлагыг хангасан байна:

17.2.1. дөрвөн өнцөгт хэлбэртэй байх бөгөөд түүний хил нь уртраг, өргөргийн дагуух чиглэлтэй давхцсан шулуун шугамууд хүрээлэгдсэн;

17.2.2. тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар, нөөцөл авсан талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй;

17.2.3. хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгосон болон түрүүлж өгсөн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд дурдсан талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй.

17.4. Нэг тусгай зөвшөөрлөөр олгох хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас баггүй, 400 мянган гектараас ихгүй байна.

18.2. Энэ хуулийн 18.1-д заасан этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг баталгасан мэдлэйн дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

18.2.1. тухайн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, факсын дутаар;

18.2.2. тухайн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчүүлсэн хуульбар;

18.2.3. энэ хуулийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зураг ба тухайн зураг дээр тэмдэглэсэн уг талбай байрших аймаг, сум, дүүргийн нэр;

18.2.4. энэ хуулийн 10.1.4-д заасан үйлчилгээний хялс төлсөн баримт;

18.2.5. хайгуулын ажлаар эрхлэх мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан талаарх мэдээлэл;

18.2.6. тухайн этгээд энэ хуулийн 7.1-д заасан шаардлагыг хангаж байгааг нотлох баримт;

18.2.7. энэ хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл хүссэн этгээдийн хувьд тухайн талбайд гүйцэтгэх хайгуулын ажлын төрөл, хэмжээ, өртгийг тусгасан урьдчилсан төсөл.

шүүхээс тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох боломжтой юм. Жишээ нь, хүсэлтэд дурдсан талбайд ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хуулиар хориглосон байхад түүнийг захиргаа шалгаагүй бол (Ашигт малтмалын тухай хуулийн 19.1.4-т энэ хуулийн 19.1.3-т заасан анхан шатны шүүлт хийсний дараа хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгосон буюу түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцаж байгаа эсэхийг тогтоох), эсхүл Засаг даргад мэдэгдээгүй буюу түүний саналыг аваагүй бол (19.3.Энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн бол төрийн захиргааны байгууллага нь энэ талаар тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд энэ хуулийн 17.1-д заасны дагуу хийсэн талбайн зургийг хавсаргана), эсхүл Засаг дарга ИТХ-ын саналыг авалгүйгээр дангаараа зөвшөөрсөн эсхүл татгалзсан санал явуулсан бол (19.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн ИТХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ), эсхүл Засаг дарга үндэслэлгүйгээр татгалзсан юмуу дэмжсэн санал явуулсан бол (19.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга зөвхөн хуульд заасан үндэслэлээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу өгч болно) олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлтэй.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн байдал:

- Нэхэмжлэлийн шаардлагыг хангасан шүүхийн шийдвэр 88;
- Нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй шүүхийн шийдвэр 32;
- Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэр 43;
- Нэхэмжлэлийн шаардлагыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэр 7;
- Нэхэмжлэлийг анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан шүүхийн шийдвэр 7;
- Талууд эвлэрсэн 2;
- Нэхэмжлэлийн зарим шаардлагыг хангаж шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан шийдвэр 1;
- Нэхэмжлэлийн зарим шаардлагыг хангаж зарим шаардлагыг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр 5;

- Нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй гуравдагч этгээдийн шаардлагыг хэсэгчлэн хангасан шүүхийн шийдвэр 3;
- Акт, шийдвэрийг түдгэлзүүлсэн 2.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн маргаанд хийсэн судалгаа, эрх зүйн дүн шинжилгээг нэгтгэн дүгнэвэл:

1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан нь нийт захиргааны маргаанд эзлэх хувийн жин нь харьцангуй бага байгаа нь нэг талаас энэхүү харилцаа нь эрх зүйн зохицуулалтыг шаардсан тулгамдсан асуудал биш мэт харагдавч нөгөө талаас энэ төрлийн харилцаанд оролцогч нь угаас хязгаарлагдмал байдагтай холбоотой юм. Учир нь хүн бүр газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй буюу боломжтой байдагтай холбоотойгоор захиргааны маргаан дахь газрын маргааны эзлэх хувь нэлээд өндөр байдаг бол харин хүн бүр ашигт малтмал хайх, ашиглах боломжгүй (зөвхөн хуулийн этгээд боломжтой), хуулийн этгээд бүр энэхүү үйл ажиллагааг явуулах боломж хязгаарлагдмал (үйл ажиллагааны чиглэл, эдийн засгийн боломж зэргээс хамааран) байдаг тул энэ төрлийн маргааны эзлэх хувийн жин харьцангуй бага байдаг гэж дүгнэж болно. Иймд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан бага байгаа нь түүний эрх зүйн зохицуулалт хангалттай байгаагийн үзүүлэлт гэж ойлгож болохгүй. Харин ч ашигт малтмалын хууль тогтоомжтой холбоотой маргаан бараг бүхэлдээ ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан байгаа нь энэхүү харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна гэж дүгнэж болохоор байна;

2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааны дийлэнх нь хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой байгаа нь нэг талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон эзэмшихийг хүсэгч нь мөн харьцангуй бага байдагтай, нөгөө талаар энэ төрлийн харилцааны эрх зүйн зохицуулалт харьцангуй тодорхой байдагтай холбоотой гэж дүгнэж болох юм. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үүсэн маргааны шинж нь эрх зүйн зохицуулалтын дутагдал гэхээсээ илүү хууль хэрэглээний асуудалтай илүү холбоотой байгаа нь үүнийг баталж байгаа юм;

3. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааны ихэнх нь тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, цуцлах буюу хүчингүй болгох шийдвэрээс үүссэн маргаан байна. Маргаан үүсэж буй үндсэн шалтгаан нь:

- Хуулийн зохицуулалт боловсронгуй бус (хуулийн зохицуулалт



дутуу, хоёрдмол утгатай, тодорхой бус ойлголт нхтэй);

• Захиргаа хуулийг буруу хэрэглэснээс (энэ нь хуулийг буруу ойлгосноос, эсхүл хуулийн зохицуулалт хоёрдмол утгатайгаас, эсхүл санаатай буруу хэрэглэснээс шалтгаалж байна);

• Иргэд хуулийг буруу, дутуу ойлгосон, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой байна.

Өөрөөр хэлбэл маргаан үүсэж буй үндсэн шалтгаан нь ХУУЛЬ-ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭГЧ (буюу захиргаа)-ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ (буюу иргэд, хуулийн этгээд)-ийн "БУРУУ"-гаас үүдэлтэй байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох, цуцлах, хүчингүй болгохтой холбоотой маргааны багагүй хувь нь хууль хэрэглэгчийн (захиргааны) буруутай үйл ажиллагаанаас, өөрөөр хэлбэл хуулийг буруу хэрэглэсэн, хуульд заасан журмыг зөрчсөнөөс үүдэлтэй байгаа нь анхаарал татаж байна;

4. Захиргааны хэргийн шүүхээс маргааныг шийдвэрлэсэн байдал харьцангуй удаан, шүүхийн шийдвэр харилцан адилгүй байгаа нь анхаарал татаж байна.<sup>2</sup> Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан нь шийдвэрлэхэд амаргүй, ажллагаа ихтэй зэрэг шалтгаанаас хэрэг хянан шийдвэрлэх ажллагаа удааширч байгааг тайлбарлаж болох талтай ч зарим нэг маргааны хувьд ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэйгээр хэргийн оролцогчдын зүгээс болон шүүхээс зоринд хутацааг сунжруулах сонирхолтой байдгийг үгүйсгэхгүй. Энэ нь шүүгчдийн мэдлэг, чадвар, ёс зүйтэй холбоотой юм.

Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Ашигт малтмалын тухай хуулийг боловсронгуй болгох. Энэхүү хууль нь ашигт малтмалын үйл ажиллагаатай холбоотой өргөн хүрээтэй харилцааг гэхээсээ илүү үндсэндээ тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг л зохицуулж байна. Иймд уг хуулийг уул уурхайн асуудлыг бүхэлд зохицуулсан ("Уул уурхайн хууль") ерөнхий хууль болгох, тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг нэг бол уг ерөнхий хуулийн нэг бүлэг болгох, эсхүл тусгай хууль ("Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хууль") болгож нарийвчлах нь зүйтэй болов уу;

2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн зохицуулалтын хүрээнд тусгай зөвшөөрлийг сунгахтай холбоотой харилцааг илүү тодорхой болгох. Ашигт малтмалын тухай хуулийн §22.1, 28.1-д заасан тусгай зөвшөөрлийн

<sup>2</sup> Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх хутагад дундажаар 3 сараас 2 жил гуртал үргэлжилж байна. Мөн нэг маргааны хувьд анхан, давах, хяналтын шатны шүүлийн шийдвэрүүдийн агуулга тус өөр байх тохиолдол нэг биш байна.

хугацаа сунгуулах тухай өргөдөл гаргах хугацааг баримтлах механизмыг тодорхой болгох. Өөрөөр хэлбэл, хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хугацаа хэтрүүлбэл хүлээлгэх санцрыг хуулиар тодорхой болгох. Жишээ нь, тусгай зөвшөөрлийг шуцах, эсхүл торгууль оногдуулах гм;

3. Хуулийн тодорхой бус ойлголтыг тодорхой болгох. Жишээ нь, Ашигт малтмалын тухай хуулийн §18.1 дэх "хамгийн түрүүнд гаргасан", §19.12 дахь "эрдсийн хуримтлал бүхий талбай" зэрэг ойлголтыг тодорхой болгох;

4. Тусгай зөвшөөрлийг шуцалсан, сунгасан эсхүл татгалзсан тохиолдолд нийтэд мэдээлэхээс гадна тусгай зөвшөөрлийг эзэмшигчид албан ёсоор мэдэгдэх, мэдэгдэх хэлбэрийг тодорхой болгох;

5. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлийг илүү тодорхой болгох;

6. Ашигт малтмалын тухай хууль зөрчигчдөд хүлээлгэх санцрын үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс захиргааны хариуцлагын төрөл, торгуулийн хэмжээ зэргийг боловсронгуй болгох.

7. Хуулийг тайлбарлах, хэрэглэх талаар нэг мөр ойлголттой болгох зорилгоор захиргааны байгууллага, захиргааны хэргийн шүүгчдэд хандсан үйл ажиллагаа зохион байгуулах.



**Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Япон  
Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийг үндсэн  
хуулийн эрх зүйн үүднээс харьцуулах нь\***

**Улсын Их Хурлын Тамгын газрын  
референт-судлаач, магистр (LLM)  
П.Амаржаргал**



Энэ жил Монгол Улсад Ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ой тохиож байгаа билээ. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль нь манай улсын хувьд улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хүрээний шилжилтийн эрх зүйн үндсийг тавьж, шинэ үеийн эхлэлийн суурь болсон гэдгийг хэн бүхэн мэдэх билээ. Харин Үндсэн хуулийн заалтуудыг ягштал мөрдөн биелүүлэхийн тулд түүний заалт бүрийн цаана байх үзэл баримтлал, түүхэн нөхцөл байдлыг ухаж ойлгох нь Үндсэн хуулиа нэг мөр зөв хэрэглэх, эрх зүйн тогтвортой байдалд чухал үүрэгтэй юм. Иймд судлаачийн хувьд Үндсэн хуулийн гол үзэл баримтлалын нэг болсон эрх мэдэл хуваарилах онолын дагуу хууль тогтоох эрх мэдлийн үндэс болох Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийг Япон Улсын ижил төстэй заалттай харьцуулан авч үзэж, Монголын болон гадны эрдэмтдийн санаа бодол, судалгааны гаргалгааг харьцуулан тусгаж, өөрийн дүгнэлтийг хийхийг зорьсон.

Хууль тогтоох байгууллагын статус, бүрэн эрхийг улс төр, философи зэрэг нийгмийн шинжлэх ухааны олон салбарын хүрээнд судлан, шинжилдэг боловч энэхүү илтгэлд уг асуудлыг зөвхөн үндсэн хуулийн

\* Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимдийн нэрэмжит илтгэлийн уралдаанд судлаачдын төрөлд III байрт шалгарсан илтгэл.

эрх зүйн<sup>1</sup> үүднээс авч үзсэн юм. Үндсэн хуулийн эрх зүйн судлах зүйлийн хүрээнд парламент, түүний бүрэн эрхийн асуудал голлох байр суурьтай байна.

Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага мөн...” гэж заасан нь цаанаа ямар утга, агуулга илэрхийлж байгаа, энэ нь эрх мэдэл хуваарилах зарчимд нийцэж байгаа эсэх асуудлаар эрдэмтэн, судлаачдын дунд маргаан дагуулсаар байна. Манай улсын хувьд Үндсэн хуулиа боловсруулахдаа гадаад улсуудын дэвшилтэт Үндсэн хуулиудыг өргөнөөр харьцуулан, хэрэглэх уламжлалтай билээ. Тухайлбал, 1924 оны анхны Үндсэн хуулийг боловсруулахад Япон Улсын 1884 оны Үндсэн хуулийг судалж байсныг судлаачид нотолсон байдаг<sup>2</sup>. 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн 20 дугаар зүйлтэй төсөөтэй заалт Япон Улсын 1946 оны Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд байдаг гэдгийг манай нэрт эрдэмтэд ч тэмдэглэж байгаа<sup>3</sup>. Иймд энэхүү хоёр заалтыг үндсэн хуулийн эрх зүй судлаачид хэрхэн ойлгон тайлбарлаж ирсэнийг дараах байдлаар судалсан.

Юуны өмнө Парламентын талаар үндсэн хуулийн эрх зүйн монгол

<sup>1</sup> Чиниад Б (2006) Үндсэн хуулийг дээдлэн шүүхэд ёс У6, 11.

<sup>2</sup> Доктор, профессор Б.Чинид Үндсэн хуулийн эрх зүйг “1922 оноос тойм манай оронд Төрийн бичиг Үндсэн хуулийн эрх зүйн ном зохиогч хэлбэрээр нь тэдгээрийн дүнжүүстэй чийгс мөн. Энэ тооц агуулгатай ойлголт ч судлах зүйлийн хувьд нэгдсэн гэгжээрээр төгсгөлд түгт агуулсан тооцоо нь авч үзвэл гэж тайлбарласан.

Сүхонго Д (2003) Төрийн эрх зүйн тайлбар толь У6, 133-134.

<sup>3</sup> Доктор, профессор Д.Сүхонго цг ойлголтыг “Төрийн (Үндсэн хуулийн) эрх зүйгээр нийгмийн сүлжээ харилцааг зохицуулна. Төрийн (Үндсэн хуулийн) эрх зүйн гол эх сурвалж нь Үндсэн хууль бусад хуулиуд, Ерөнхийлөгчийн шийдвэр, Засгийн газрын өгт, Үндсэн хуулийн шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ боловч нийгмийн өөрөөр үзвэлхээ ёсны байгууллагын зарим эрх ахилцаа ман хамчарна” гэж тайлбарласан.

Нээлттэй нийгэм форум, НҮБХХ (2006) Арчигдсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь У6, 130.

Дарвигийн нэг өөр хувилбар бол Үндсэн хуулийн эрх зүй гэж эрх зүйн салбарын тогтолцоонд гол бийг хэрэглэн түүнийг нэг салбар шинжлэх үзлэн юм. Үндсэн хуулийн эрх зүй нь тухайн үзлийн эрх зүй чөлөөт хангын байгуулжүүлэх тогтолцоо, улс орны нийгэм эдийн засаг, улс төрийн байгуулал болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгуулалж, төр, иргэний нийгэм гоёомь харилцаа, түүнийгээр эрх зүйн үндсэн үндсэн зарчмыг тодорхойлж бийлж, Ман эрх зүйн тогтолцооноос хангач өөр өөрөөр хэрэглэхэд бийтэй шийдэхгүй юм. Тухайлбал Англи-Саксоны эрх зүйн тогтолцоонд “Constitutional Law” бичиг Үндсэн хуулийн эрх зүй, Ром-Германы эрх зүйн тогтолцоонд “State Law” бичиг Төрийн эрх зүй гэж.

Энэ удаад би бээр Үндсэн хуулийн эрх зүйн нэр тэмдгээр авч үзэхээ. ПА.

<sup>4</sup> Японы Нагаоагийн их сургуулийн Олон улсын хөгжлийн сургуулийн докторант, Накамура Масакэ Гадаад улсуудын Үндсэн хуулийн орчуулга ба Монгол Улсын анхны Үндсэн хуультай хэлбэлхээ баримт бичиг. Монгол Улс дахь эрх зүйн шинжлэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил Хууль зүйн үндснийг хүрээлэн (2004) 71-74.

<sup>5</sup> Чиниад Б (2006) Үндсэн хуулийг дээдлэн шүүхэд ёс У6, 48.

<sup>6</sup> “Мунгала бийгч нэг шидат бийгч “УИХ нь төрийн эрх барих дээд байгууллага...” гэсэн томогтоотой бичлэхээ бий өөрийн үзлэнжлэлтэй шидат туслахын хамт Японы 1946 оны Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд үйл зөвшөөр байдаг юм шигэ гэдгийг ч хань татаж болохсон билээ. Ийм хангачаа баримтласан нь өөрийн нэгдлэл бийгч (улс нэг засагтай бийгч), хүний эрхийг хангах үзлэхээ ч эрх мэдлийг тэрхүү нэг засгийн 3 салаа (“Three branches of government”) -нд Үндсэн хуулиар хуваах, хуваарилан тэнцвэржүүлэх хоёрыг ялган ойлгохыг чинээсэн үзлэнгтэй юм.”

эрдэмтэд хэрхэн тодорхойлсныг авч үзвэл, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар<sup>1</sup>-т Улсын Их хурлын тамгын газрын хуулийн хэлтсийн зөвлөх Н.Тунгалаг нь хуулиар ард түмний хүсэл зоригийг илэрхийлж байгаа учраас төрийн эрх мэдлийн дээд байгууллага гэж тодорхойлсон байна. Хууль зүйн доктор, профессор Д.Солонгын Төрийн эрх зүйн тайлбар толь<sup>2</sup> Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдэл, төрийн эрх барих дээд байгууллагыг ард түмнээс сонгогдсон төлөөллийн ардчилалтай холбон тодорхойлсон байна. Энэхүү тайлбарууд 2003, 2009 онуудад хэвлэгдсэн бөгөөд одоо хүртэл ач холбогдлоо алдаагүй байна. Харин хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндорж<sup>3</sup> төрийн эрх мэдлийн хуваарилах онолын харилцан тэнцвэртэй, хяналт бүхий (check and balance) зарчим нь зөрчилдөж байгааг одоогийн бодит байдлаар тодорхойлсон билээ. Ийнхүү уг асуудлыг эрдэмтэн, судлаачид өөр өөр өнцгөөс, олон талаас нь судлан дүгнэлт хийж буй нь харагдаж байна.

Япон Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлээр тогтоосон парламентын асуудлаар үндсэн хуулийн эрх зүйн профессор Хироюки Хата, Го Накагава, Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Такехиро Ёокомичи болон Парламент судлаач, профессор Ханс Х. Байрвальд нарын тайлбарыг авч үзье.

Япон Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйл.

Англи хэлнээ хөрвүүлбэл:

Chapter IV. The Diet

Article 41. The Diet shall be the highest organ of state power, and shall be the sole law-making organ of the State.

Монгол хэлнээ хөрвүүлбэл:

Дөрөвдүгээр бүлэг. Парламент (The Diet)

<sup>1</sup> Ханкс-Зайдеман сан, "Эрх зүйн боловсрол" академи (2011) Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар Уб, 117.

<sup>2</sup> Дэлхийн улс орнуудад төрийн эрх барих дээд байгууллага нь зарим тохиолдолд хоёр танхимтай, зарим оронд нэг танхимтай парламент хэлбэртэй байна. Олон улс орны ирэгчдийн төлөөллийн цэвэр "хууль тогтоох бичлэг эрх", "хууль тогтоох эрх", "хууль гэрээ эрх", "хууль тогтоох бүрэн эрх" гэх нийт ойлголтыг буй болгосон юм. Эдгээрийг Үндсэн хуульдаа хуучилсан баталгаажуулжээ. Өөрөөр хэлбэл хууль гэрээ нь төрийн агууваа нэг зүтгэлтний хувийн хүсэл зоригийн илэрхийлэл болох ёстой билээ. Хууль бол иргэдийн нийтлэг хүсэл зоригийн илэрхийлэл билээ. Иймд ард нийтийн төлөөлөгчдийн байгууллагын институтыг төрийн эрх мэдлийн систем дэх улс төрийн дээд төлөөлөл хэмээн тодорхойлсон юм. Үүнээс төлөөллийн өөр институт байхгүй билээ. Манай Улсын хувьд парламент-Улсын Их Хуртыг нэг танхимтай, нийт хувьд амин тооцдог тохирон, ард түмнээ төлөөлж эрх барих, хууль тогтоох байгууллага байхаар хуучилсан юм."

<sup>3</sup> Солонго, Д. (2003) Төрийн эрх зүйн тайлбар толь Уб, 139, 167.

<sup>4</sup> "Ард түмнээс сонгогдсон, төрийн эрх барих, төлөөлөгчийн дээд байгууллага"

<sup>5</sup> Лүндэндорж Н. (2010) Шалжитгийн цэ: улс төр, эрх зүйн асуулал Уб, 25-26.

<sup>6</sup> "Өгөөч Монгол Улсад төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хуваарилан эрэгжүүлэх бус, харин "төрийн эрх барих дээд байгууллага" төрийн дээд эрхээ дангивар эзэлж байна" дэлгэрэнгүй энэхүү номноос цимина цу.

41 дүгээр зүйл. Парламент бол улсын хуулийг дангаар тогтоодог, төрийн эрх мэдлийн дээд байгууллага юм.<sup>8</sup>

Япон Улсын Үндсэн хуулийн эрх зүйн профессор Хироюуки Хата, Го Накагава нарын тайлбар Хууль тогтоох байгууллага болон Төрийн эрх барих дээд байгууллага гэдэг ойлголтыг гарган тайлбарласан<sup>9</sup> байна. Энэхүү тайлбарт "хууль тогтоох цорын ганц байгууллага гэсэн үг ямар утга санааг илэрхийлж байна вэ? Тухайн үеийн Үндсэн хуулийн төсөл боловсруулагчид Эзэн хаанаас төрийн хууль тогтоох эрх мэдлийг салгаж, түүнийг Үндэсний засгийн газрын хүлээн зөвшөөрөгдсөн хууль тогтоох байгууллага болох парламентад шилжүүлэх "ухамсарлагдаагүй" төлөвлөгөөтэй байсан гэжээ. Цааш нь "Төрийн эрх барих дээд байгууллага гэдэг нь мөн дээрхийн адилаар тайлбарлагдаж болох юм. Парламентын баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгох шүүхийн бүрэн эрхийн зүгээс авч үзвэл парламент нь заавал ч төрийн эрх барих дээд байгууллага биш болж байна. Үндсэн хуулиар юуг дээд болгож байгаа нь парламентын хүсэл зориг бус Үндсэн хуулийн өөрийнх нь хүсэл зориг юм. Тэгвэл яагаад парламентыг төрийн эрх барих дээд байгууллага гэсэн бэ? Энэ нь өөрөө эрх мэдэл хуваарилах зарчмын эсрэг болж байна. Харин хуучин Үндсэн хуульд байсан Эзэн хааны бүрэн эрхт байдлын үзэл санааг хууль ёсоор үгүйсгэх гэсэн үндсэн хуулийн төсөл боловсруулагчдын арга техник байсан байж болох юм. Тэдний гол зорилго нь төрийн бүрэн эрхт байдлын аливаа эх сурвалжийг Эзэн хааныг үлдээлгүйгээр түүний дотор, хууль тогтоох эрх мэдлийн хувьд парламентыг хамгийн дээд бөгөөд хууль тогтоох цорын ганц байгууллага гэсэн түвшинд зэрэглэсэн явдал юм. Хэрвээ энэ үнэн бол төрийн эрх барих дээд байгууллагын эрх мэдлийг парламентад Үндсэн хуулиар өгөөгүй гэдэгт гайхах зүйл байхгүй" гэсэн байна. Үүнээс үзэхэд парламентын "төрийн эрх барих дээд байгууллага" гэсэн ойлголт нь "төрийн хуулийг тогтоох цорын ганц субъект" гэдэг талаас нь тайлбарласан байна.

Энэ заалтыг Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Такехиро Ёкомичи тайлбарлахдаа "Ард түмнээс сонгогдсон танхимын манай гишүүд нь улс төрийн хэлэлцүүлэг өрнүүлж, Диетийг "нээлттэй" бөгөөд ойлгоход "энгийн" болгож, манай ард түмний амьдралын алхам бүрт Япон орныг зөв чиглүүлэх хүнд харнуцлага үүрч байгаагаа байнга мэдэж байдаг" гэсэн байна.<sup>10</sup> Ийнхүү төлөөллийн зарчимд үндэслэгдсэн

<sup>8</sup> (2011) Япон Улсын Үндсэн хууль Орч. Амаржаргал.П, Ред. Лүцэнзорж.Н, Оюултулгар.Ж. Уб. Админ. 15.

<sup>9</sup> Hiroyuki Hata, Gu Nakagawa (1997) *Constitutional Law of Japan* Kluwer Law International 58-59.

<sup>10</sup> [http://www.shugiin.go.jp/index.nsf/html/index\\_e\\_message.htm](http://www.shugiin.go.jp/index.nsf/html/index_e_message.htm). Япон Улсын Төлөөлөгчдийн танхимын албан ёсны цахим хуудас.

бодлогын шийдвэр гаргах парламентын гишүүний үүрэг, хариуцлага талаас нь дээрх заалтыг тайлбарласан байна.

Парламентын гишүүдтэй ярилцлага хийх, парламентын үйл ажиллагаанд ажиглалт хийх замаар Японы парламентын талаар судалгаа хийсэн, Япон Улсын Парламент судлаач, профессор Ханс Х.Байрвальд нь энэ тухай судалгааны нэртэй өгүүлэлдээ “Парламент бол төрийн эрх барих дээд байгууллага” гэсэн Үндсэн хуулийн томъёолол нь Японы парламентын бодит бүрэн эрхийн тусгал биш юм гэж улс төр судлаачид төднийгүй Япон хүмүүсийн ихэнх нь үздэг” гэжээ.<sup>11</sup>

Ийнхүү хоёр улсын Үндсэн хуулийн заалтын тайлбарыг харьцуулан авч үзэж дүгнэхэд:

Монгол Улсын төр, эрх зүйн түүх болон нийгэм, эдийн засгийн харилцаанд Үндсэн хуулийн эрх зүйн салбар чухад байр суурь эзэлдэг билээ. Аливаа улс орны Үндсэн хууль нь тухайн нийгмийн хүний эрх, эрх чөлөөг хангах, нийгмийн байгууллын тогтолцоо, төрийн эдийн засгийн үндсийг тогтоодог болно.

Аливаа төрийн эрх мэдлийн үндэс нь ард түмнээс эх үндэстэй билээ. Ард түмэн эрх мэдлээ өөрсдийн сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэгжүүлнэ. Энэ нь төлөөллийн ардчилал буюу ард түмнээс сонгуулийн аргаар эрх мэдлийг шилжүүлж авах хууль ёсны үйлдлийг ойлгоно. Энэ утгаараа эрх мэдлийн үт үндэс нь тэрхүү ард түмний төлөөллийн байгууллага Парламентад олгогдож болно. Гэхдээ нөгөө талаас үүнийг шууд утгаар нь Улсын Их Хурал бол эрх мэдэл хуваарилалтын 3 салаа мөчир дундаасаа дээд байгууллага нь гэж ойлгож болохгүй юм. Учир нь эрх мэдэл хуваарилалтын үүднээс хандвал “check and balance”-ийн зарчмаар хандвал энэ нь тохирохгүй байна. Эрх мэдлийн гурван салаа мөчир хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлүүд өөр хоорондоо харилцан хяналт, тэнцвэртэй байх зарчмыг алдагдуулах нэг үндэс болж болзошгүй юм.

Япон Улсын тухайд энэхүү Үндсэн хуулийн заалтыг тухайн үеийн түүхийн нөхцөл байдлаас хамаарах, мөнхүү Үндсэн хуульдаа заасан шууд утгаар ойлгох бус ард түмний хүсэл зоригор ойлгон тайлбарлаж байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл төлөөллийн ардчилал болон эрх мэдлийг субъектийн хооронд шилжүүлэх бодит шаардлага, түүхэн нөхцөл байдлын үүднээс тайлбарлажээ.

Монгол Улсын хувьд энэхүү Үндсэн хуулийн заалт нь шилжилтийн нийгмийн нөхцөл байдал болон шууд утга, өгүүлбэрээр нь ойлгох явдал

<sup>11</sup> Hans H. Baerwald, “Parliament and parliamentarians in Japan” Pacific Affairs, Vol. 37, No.3, (1960) Autumn, 271-282 pp. University of British Columbia

түгээмэл байх бөгөөд “хууль тогтоох дээд байгууллага” байгууллага гэсэн утга агуулга байна уу, эсхүл төлөөллийн ардчиллын үүднээс тайлбарлах уу гэсэн хувилбарууд байна. Нөгөө талаас “төр хуулийг дээдлэх” үзэл баримтлалын үүднээс энэхүү “хууль”-ийг тогтоогч дээд байгууллага нь ард түмнээс хууль ёсоор эрх мэдэл шилжүүлэн авсан парламент болох гэсэн утгаар “төрийн эрх барих дээд байгууллага” гэдгийг ойлгон хэвшүүлэх нь зүйтэй болов уу.

2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.2.2-т заасны дагуу дээрх хорьдугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно гэсэн байна. Ийм тохиолдолд энэхүү заалтыг зөв ойлгон тайлбарлаж, нэг мөр хэрэглэх нь ихээхэн ач холбогдолтой байна.



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭГ  
www.nli.gov.mn



түгээмэл байх бөгөөд “хууль тогтоох дээд байгууллага” байгууллага гэсэн утга агуулга байна уу, эсхүл төлөөллийн ардчиллын үүднээс тайлбарлах уу гэсэн хувилбарууд байна. Нөгөө талаас “төр хуулийг дээдлэх” үзэл баримтлалын үүднээс энэхүү “хууль”-ийг тогтоогч дээд байгууллага нь ард түмнээс хууль ёсоор эрх мэдэл шилжүүлэн авсан парламент болох гэсэн утгаар “төрийн эрх барих дээд байгууллага” гэдгийг ойлгон хэвшүүлэх нь зүйтэй болов уу.

2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.2.2-т заасны дагуу дээрх хорьдугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно гэсэн байна. Ийм тохиолдолд энэхүү заалтыг зөв ойлгон тайлбарлаж, нэг мөр хэрэглэх нь ихээхэн ач холбогдолтой байна.



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭН  
www.nli.gov.mn

## Цахим худалдааны загвар хууль батлах болсон шалтгаан, нөхцөл

ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн  
секторын эрдэм шинжилгээний  
ажилтан Г.Халиунаа



Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжихийн хэрээр уг харилцааг олон улсын хэмжээнд нэгдмэл зохицуулалтад оруулах хэрэгцээ нэмэгдсээр байна. Эдийн засгийн харилцааны нэг чухал хэсэг болох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ялангуяа шинээр гарч ирж байгаа худалдааны хэлбэрийг нэгдсэн зохицуулалтад оруулан хуульчлах нь олон улсын эрх зүйн нэгээхэн хэсэг юм.

Шинэ төрлийн худалдааны хэлбэрт цахим худалдаа яахын аргагүй багтаж байгаа бөгөөд тус худалдаа нь биечлэн хийгдэх худалдааг бодвол талуудын цаг хугацаа, зардлыг хэмнэдгээрээ давуу талтай юм. Тиймээс энэхүү худалдааны хэлбэрийг ашиглан гадаад худалдаа хийх сонирхолтой улс орнууд цөөнгүй болсон.

Олон улсын хэмжээнд тухайн харилцааг НҮБ, НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL), Дэлхий худалдааны байгууллага (WTO) зохицуулж байна.

“Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай” Марракешийн хэлэлцээр, түүний хавсралт болох олон талт худалдааны хэлэлцээрийг УИХ-аас 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдөр соёрхон баталж улмаар Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 29-ний өдрөөс Дэлхийн худалдааны

байгууллагын гишүүн орон болсон<sup>1</sup>. Нэгэнтээ Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орон болсон учраас Монгол Улс гадаад худалдааг зохицуулах олон улсын дүрэм, журам, зохицуулалтыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн.

Цахим худалдааны хэлбэр нь манай улсын хувьд шинээр гарч ирж буй ойлголт төдийгүй, уг харилцааны практик нэгэнт үүсэж байгаа тул эрх зүйн зохицуулалтыг анхнаас нь зөв зүйтэйгээр зохицуулж, боловсруулах нь нэн тэргүүний асуудал болоод байна. Тиймээс бусад улсад жишиг болгон хэрэглэхээр гаргасан цахим худалдааны загвар хууль батлах болсон шаардлага, нөхцөлийн талаар дор өгүүлье.

ЮНСИТРАЛ<sup>2</sup>-ын гишүүн улсуудад эдийн засгийн янз бүрийн хөгжлийн түвшинтэй орнууд байдаг бөгөөд 1996 онд НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйг хариуцсан комиссоос “Цахим худалдааны загвар хууль”<sup>3</sup>-ийг батлан гаргасан юм.

Тус комисс нь олон улсын худалдааны хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжилтийг хангах зохион байгуулах чиг үүргийнхээ хүрээнд худалдааны хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй зөрүүтэй ойлголтууд болон зарим зохицуулаагүй, тодорхойгүй байгаа асуудлыг цэгцлэх зорилгоор энэхүү загвар хуулийг баталсан. Өөрөөр хэлбэл, бизнесийн талууд харилцаа холбоондоо компьютер болон орчин үеийн техникийн шийдлүүдийг өргөнөөр ашиглахтай холбоотойгоор гарч байгаа өөрчлөлтүүдтэй уялдуулж боловсруулсан. Улс орнууд дотоодын хууль тогтоомждоо зохицуулаагүй компьютер болон орчин үеийн техникийн шийдлүүдтэй холбоотой харилцаа энэхүү загвар хуулийг ашиглан өөрийн дотоодын эрх зүйн хүрээнд жишиг болгон ашиглах боломжтой юм.

Загвар хуулийг дараах хэд хэдэн үе шатыг дамжин боловсруулжээ. Үүнд:

• 1984 оны Комиссын 17 дугаар хуралдаанаар “Автомат мэдээлэл боловсруулалтын эрх зүйн асуудал” сэдвээр хэлэлцүүлэг болсон бөгөөд тус хэлэлцүүлгээр компьютерийн мэдээллийн аюулгүй байдал, компьютерийн мэдээлэл эрх зүйн хувьд хэрхэн үнэлэгдэх эсэх асуудлыг хөнджээ. Тус хурлаар Комиссын эрхлэх үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь автомат мэдээллийн системийн эрх зүйн үр дагаварын асуудал юм байна гэж үзсэн.

• Компьютер болон тэдгээрийн хоорондын мэдээлэл дамжуулалт нь олон улсын худалдаанд тавих шаардлагыг (тухайлбал, худалдааны баримт бичиг нь заавал бичгэн хэлбэртэй бөгөөд гарын үсэг зурсан

<sup>1</sup> Оюунцэцэг Х. (2003) “Электрон худалдааны эрх зүйн асуудал” // Монголын төр эрх зүй сэтгүүл №4, 11.

<sup>2</sup> НҮБ-ын худалдааны эрх зүйн комиссын үүргийг гүйцэтгэдэг байгууллага.

<sup>3</sup> Тус загвар хууль нь ЮНСИТРАЛ-ын 29 дүгээр хуралдааны нэгдүгээр хэсгийн хэсрэлт 1-д нийтлэгдсэн.

байх) хангахгүй байгаа нь гол асуудал болсон. 1985 оны Комиссын 18 дугаар хуралдаанаар автомат мэдээллийн эрх зүйн үр үнэлгээ сэдвийн буюу компьютерт хадгалагдаж байгаа мэдээлэл нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр нотлох баримт болох эсэх талаар хэлэлцсэн. Хурлаас улс орнуудад худалдааны баримт бичгийн цаасан хэлбэрээс аль болох татгалзаж цахим баримт бичиг хэрэглэх, энэхүү цахим хэлбэрийн бичиг баримтыг нотлох баримтын түвшинд үнэлэх, худалдааны эрх зүйн орчин болон бусад дүрэм, журам боловсруулдаг байгууллагууд аль болох дээрх уриалгыг харгалзан үзэж эдгээр баримт бичгийг боловсруулахдаа баримталж байх талаар зөвлөмж<sup>4</sup> гаргасан. 1985 оны энэхүү ЮНСИТРАЛ-ын зөвлөмжийн дагуу улс орнууд өөрийн хууль тогтоомжийг зөвлөмжтэй нийцүүлэх оролдлого хийсэн боловч нэлээд бэрхшээл гарч ирж байсан бөгөөд тухайн зөвлөмжөөр дотоодын хууль тогтоомждоо өөрчлөлт оруулахыг уриалсан хэдий ч хэрхэн өөрчлөлт хийх талаар тусгаагүй байсан. Ийнхүү улс орнууд хэрхэн өөрчлөлт хийх арга замын талаар дахин зөвлөмж өгөх хүсэлт тавьсаны дагуу Комиссоос цахим худалдааны загвар хууль батлах ёстой юм байна гэж үзсэн.

• 1988 оны Комиссын 21 дүгээр хуралдаанаар олон улсын цахим хэлбэрээр хийгдэж байгаа гэрээ, хэлэлцээрийн хууль зүйн үндсэн зарчмыг хангах тухай хэлэлцээд судалгааны ажил явуулахаар болсон. Энэ судалгааны ажлын хүрээ нь худалдааны бичиг баримтыг бичгээр үйлдсэн байх гэсэн шаардлагыг цахим харилцаанд хэрхэн оновчтойгоор хэрэглэх, цахим гэрээ, хэлэлцээртэй холбоотой бусад асуудлыг, цахим худалдаа хийхэд гарч буй бэрхшээлүүд, тэдгээрийг хэрхэн даван туулах арга замыг тодорхойлох зэрэгт чиглэгдэж байсан. Комисс 1990 оны 23 дугаар хуралдаанаар дээрх судалгааны үр дүнгээ нэгтгэсэн ба дараагийн хуралдаанаар цахим мэдээллийн солилцооны талаар хэлэлцэхээр болсон.

• Комисс 1991 оны 24 дүгээр хуралдаанаар “Цахим мэдээллийн солилцоо”-ны асуудлын талаар хэлэлцэж хурлаар цахим мэдээлэл солилцооны хууль зүйн бэрхшээлийг тайлбарлаж, хийсэн болон боловсруулж байгаа стандартын агуулгыг нэгтгэн дүгнэсэн. Өөрөөр хэлбэл, олон төрлийн хэрэгцээ шаардлагатай, олон төрлийн хэрэглэгчдийн зэрэглэлээс шалтгаалан мэдээлэл нь өөр хоорондоо харилцан адилгүй байдаг. Тиймээс энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд мэдээлэл солилцооны үндсэн хүрээгээ зөв тодорхойлох шаардлага гарсан. Иймээс нэг систем, нэгдсэн зарчим, ойлголттой болохын тулд загвар хуулийг яаралтай батлахаар бэлтгэж эхэлсэн. Ийнхүү загвар хуулийн эцсийн төслийг бусад

<sup>4</sup> Энэхүү зөвлөмж нь “1985 CITRAL Recommendation” 1985 оны 12 дугаар сарын 11-нд Ерөнхий Ассамблейгээс 40/71 тогтоолын 5(b) зүйлээр батлагдсан.

улс орон өөрийн хууль тогтоомждоо нийцүүлж, хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон хөтчийн<sup>1</sup> хамт боловсруулахаар болсон.

• Комиссын 29 дүгээр хуралдаанаар Комисс нь Хянан засах газраас бэлтгэсэн загвар хуулийн бичвэрийг авч үзсэний дараа 1996 оны 6 дугаар сарын 12-ны өдөр 605 дугаар цуглаан дээр дараах шийдвэрийг гаргасан. Олон улсын худалдааны эрх зүйг хариуцах НҮБ-ын Комисс нь, Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 17-ны 2205 (XXI) шийдвэрийн дагуу олон улсын худалдааны хуулийг нэг мөр болгох заалтуудын уялдаа холбоог сайжруулах ажлыг дэмжих ба хөгжиж буй орнуудын ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийг олон улсын худалдааны өргөн хүрээтэй хөгжилд оролцуулах чиг үүргийнхээ хүрээнд, Олон улсын худалдаан дахь үйл ажиллагаа, хэлцлийн тоо нь цахим мэдээллийн солилцооны арга хэрэгслээр болон бусад харилцааны хэлбэрийн тусламжтайгаар нэмэгдэж байгааг тэмдэглэж, 1985 оны 18 дугаар хуралдаанаар Комиссоос баталсан автомат мэдээллийн хууль зүйн үнэ цэнийн тухай зөвлөмжүүдийг болон 1985 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Ерөнхий Ассамблейн 40/71 шийдвэрийн 5(b) зүйлийг харгалзан, загвар хуулийг бий болгох нь цахим худалдааны хэрэглээг хөнгөвчилж, олон янзын хууль зүй, нийгэм, эдийн засгийн системтэй аль ч оронд тохирно гэж үзэн, загвар хууль нь цаасанд суурилсан харилцааны хэлбэр, түүнийг хадгалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар одоогийн хууль тогтоомжоор зохицуулагдаагүй харилцааг илүү тодорхой болгож зохион байгуулахад нь туслах зорилготой гэж үзэж тус хуулийг батлан гаргажээ.

Цахим худалдааны загвар хууль нь хоёр хэсэг, дөрвөн бүлэг, 17 зүйлээс бүрдэх бөгөөд мөн өөрийн хөтчийн хамт боловсруулагдсан. Хуулийг ерөнхийд нь задалж үзвэл, нэг дүгээр хэсэгт ерөнхий зүйлийг тусгасан. Тухайлбал, хуулийн нийтлэг үндэслэл, нэр томъёоны тодорхойлолт, цахим мэдээллийн шаардлага, хэрэглээ, хэлцлийн төрөл, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, гарын үсэг, бүртгэл, хариуцлага гэх мэт харилцааг зохицуулахаар заасан бол хоёр дугаар хэсэгт барааны тээвэрлэлт, бараа дамжин өнгөрүүлэх талаар тусгасан байна.

Энэхүү загвар хуулийг жишиг болгон өөрийн дотоодын эрх зүйн зохицуулалтыг хийж өгсөн улсын тоонд Азербейжан, Канад гэх мэт улс багтаж байна.

Цахим худалдааны хуультай болохын тулд улс орнууд энэ тэргүүнд цахим хуульн үсгийн эрх зүйн зохицуулалтыг хийж өгдөг нийтлэг хэв маяг байна.

<sup>1</sup> Хөтөч нь Загвар хуульд тодорхой заагаагүй мэдээлүүдийг дэлгэрэнгүй бөгөөд ойлгомжтой болгох зорилгоор хийгдсэн байна.

Манай улсын хувьд ч мөн Цахим гарын үсгийн тухай хуулий<sup>6</sup> 2011 оны 12 сарын 15-ны өдөр батлан гаргасан билээ.

Цахим худалдаа нь дотроо харилцаанд оролцож буй субъектүүдээрээ хэд хэдэн төрөл байдаг. Тухайлбал, бизнесээс бизнест (B2B), бизнесээс хэрэглэгчид (B2C), хэрэглэгчээс хэрэглэгчид (C2C), бизнесээс Засгийн газарт (B2G), бизнесээс ажилчдад (B2E) гэх мэт.

Одоогоор Монгол Улсад B2C, C2C худалдааны хэлбэрийг голчлон хэрэглэж байна. Цаашдаа энэхүү худалдааг улам боловсронгуй болгохын тулд эрх зүйн орчныг судлан үзэж дээрх загвар хуулийг жишиг болгон дотооддоо энэхүү харилцааны зохицуулалтыг хийж өгөх шаардлагатай байна. Энэ алхмыг хийхийн тулд цахим худалдааны хуулийг цогцоор нь шийдвэрлэх тухайлбал, мэдээллийн аюулгүй байдлын тухай, өгөгдлийн сан хамгаалах тухай, цахим бичиг баримтын тухай гэх мэт асуудлын эрх зүйн орчинг зохицуулах шаардлагатай болно.

○○○○○○

○○○○○○

○○○○○○

<sup>6</sup> <http://www.legalinfo.mn>.

## БНХАУ-ын Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн талаар\*



Жайка төслийн  
мэргэжилтэн, Япон Улсын  
өмгөөлөгч, Ока Хидзо

### УДИРТГАЛ

Бүгд Найрамдах Хятад Улсад (цаашид “Хятад” гэх) 2010 оны 8 дугаар сарын 28-ны өдөр “Бүгд Найрамдах Хятад Улсын Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хууль” (2011 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн) батлагдсанаар<sup>1</sup> Хятадын ард иргэд ADR<sup>2</sup>-ийг илүүтэй сонирхон ашиглах болсон.

Хятадад иргэд хоорондын маргаан жилээс жилд нэмэгдэж, Ардын шүүхийн ачаалал ихэссэн байснаас гадна, “эвсэг нийгэм”<sup>3</sup>-ийг бий болгох зорилгын дор маргалдагч талуудын хэн алины ашиг сонирхолыг ханган маргааныг уян хатан шийдвэрлэдэг “эвлэрүүлэн зуучлал” гэх мэт шүүхийн бус журмаар маргаан зохицуулдаг механизмын ач холбогдлыг дахин авч хэлэлцэх болсон нь энэхүү хуулийг батлах үндсэн хүчин зүйл болсон гэж үздэг.

Монголд ч гэсэн шүүхийн ачаалал маш их, ард иргэд маргааныг эвийн журмаар шийдвэрлэх сонирхол өндөр байдаг. Эндээс, Монгол ч гэсэн

\* Монгол хэлнээ хөрвүүлсэн Жайка төслийн зохицуулагч, хуульч Г.Тогос

<sup>1</sup> Хятадын хууль тогтоогч байгууллага болох Бүх Хятадын Иргэдийн Төлөөлөгчдийн Арван нэгдүгээр Их Хурлын Байнгын хорооны 16 дугаар хуралдаанаар баталсан (2010.8.23-28).

<sup>2</sup> Alternative Dispute Resolution-ий товчлол. “Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх арга” гэсэн утгатай.

<sup>3</sup> 2004 онд Хятадын Коммунист намаас гаргасан “нийгмийн давхаргаас үл хамааран ард түрэн хоорондоо эвсэж байх гэсэн утгатай” уриа. Хятад Улс нь “нээлттэй шинэчлэлийн бодлого” хэрэгжүүлэх болсноор албан тушаалтнууд, намын гишүүдийн завхрал хэрээс хэтэрч, нийгмийн давхарга хоорондын болон бус нутаг хоорондын хөгжлийн ялгаа ихсэж, байгалийн бохирдол гарч байгаа юм. Энэ нөхцөлд нийгмийн тайван бус байдлыг намжаах зорилгоор төрөөс дээрх уриаг гаргасан гэж үздэг.

эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагын хувьд Хятадтай адил нөхцөлд байгаа гэж хэлж болно. Иймд, энэхүү бичвэрээрээ Хятадад шинээр хуульчилсан эвлэрүүлэн зуучлах тогтолцооны талаар товчхон танилцуулахыг зорилоо.

## НЭГ. ХЯТАДЫН ADR-ЫН ТОГТОЛЦООНЫ ЕРӨНХИЙ ДҮР ЗУРАГ

Хятадад эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэгч субъектээс нь шалтгаалан дараах гурван төрөлд ангилдаг байна.

1. Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлал-Ардын Эвлэрүүлэн Зуучлах Хорооноос хэрэгжүүлдэг эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа;
2. Захиргаа төвтэй Эвлэрүүлэн зуучлал-Төр, захиргааны байгууллагаас хэрэгжүүлдэг эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа;<sup>4</sup>
3. Шүүх төвтэй Эвлэрүүлэн зуучлал-Ардын шүүхээс хэрэгжүүлэн явуулдаг эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа. Монголоор бол шүүхийн шатанд эвлэрэх<sup>5</sup>-тэй адил утга.

Энэ удаад дээрх гурван төрлөөс "Ард төвтэй эвлэрүүлэн зуучлал"-ын талаар товч тайлбарлая.

## ХОЁР. АРД ТӨВТЭЙ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ ТОГТОЛЦОО

### • Түүхэн замнал

Ард төвтэй эвлэрүүлэн зуучлал нь Хятад Улс үүсэн байгуулагдсанаас хойш өргөн дэлгэр хэрэглэгдэж ирсэн маргаан шийдвэрлэх арга юм. 1980-аад онд иргэний хэргийн 80%-ийг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэж байсан гэдэг<sup>6</sup>. Гэсэн хэдий ч ийм үр ашигтай тогтолцоо мөртлөө огт хуульчлагдахгүй хэрэгжсээр ирсэн байх юм<sup>7</sup>.

<sup>4</sup> "Захиргаа төвтэй эвлэрүүлэн зуучлал"-ын хамрах хүрээг сулалт бүр өөр, өөрөөр тайлбарладаг. Энэхүү бичвэрт ойлгомжтой байгаа үүднээс "Салбарын эвлэрүүлэн зуучлал" болон "Ажилгааны эвлэрүүлэн зуучлал"-ыг "Захиргаа төвтэй эвлэрүүлэн зуучлал"-д оруулан бичсэн хэдий ч үүнийг оруулахгүй гэж үзэх үзэл байдлыг дурдал нь зүйтэй.

<sup>5</sup> Хятадын Шүүх төвтэй эвлэрүүлэн зуучлал нь хэрэг хянан шийдвэрлэх явцад зохиогчид эвлэрүүлэн ажиллагаагаар хягаарлагддаг бөгөөд Японд байдаг болон Монголд одоо туршиж байгаа "Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал"-тай адил шүүхэд хэрэг үүсгэхээс өмнөх шатанд эвлэрүүлэн зуучлах тогтолцоо Хятадад байхгүй юм.

<sup>6</sup> 2009 онд Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар нийт 7,676,064 хэрэг хүлээн авсан бөгөөд Ажлын шатны шүүхэд хүлээн авсан нэхэмжлэлийн тоо болох 5,800,144-оос хамаагүй нэлүү байна. Иймч, Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар хүлээн авсан хэргийн тооны хувьд "хэрэг хүлээн авах" гэсэн ойлголт тодорхойгүй байдагас яаж ч бол яаж ч тодорхойлогддог тул энэ тооны үндэслэлтэй эсхл нь иргэлээнтэй.

<sup>7</sup> Яг үнэндээ бол огт хуульчилж байгаагүй ч бас биш юм. 1954 онд Ардын Төв Засгийн Газраас "Ард төвтэй эвлэрүүлэн зуучлах хорооны үйл ажиллагааны дүрэм" баталсан ба 1989 онд АТЗГ-аас дээрх дүрмийг "Ард төвтэй эвлэрүүлэн зуучлах хорооны үйл ажиллагааны тухай хууль" болгон өөрчилж, захиргааны хууль тогтоомжид оруулсан. 1982 онд одоо мөрдөж буй Хятад Улсын Үндсэн хуулийн §111.2-т Ард төвтэй эвлэрүүлэн зуучлах хорооны талаар заалт оруулсан байдаг. Түүнчлэн, 2002 онд Хууль зүйн ламнаас "Ард



2010 он гарснаас хойш буюу 8 дугаар сарын 28-нд л "Бүгд Найрамдах Хятад Улсын Ард Төвтэй Эвлэрүүлэн Зуучлалын тухай хууль" баталж, 2011 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлжээ.

• *Хуулийн талаар*

Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь таван бүлэг, 35 зүйлээс бүрдэнэ. Цаашид хуулийн заалтын дарааллын дагуу Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлах тогтолцооны талаар тайлбарлая.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Нийтлэг үндэслэл (§1-§6)**

**(Хуулийн ач холбогдол)**

Ард төвтэй эвлэрүүлэн зуучлал гэж маргалдагч талуудыг ятгах, зааварчлах замаар тэднийг эрх тэгш байдлаар харилцан ярилцах боломжийг бүрдүүлснээр талууд сайн дураар эвлэрлийн тохиролцоонд хүрч, ингэснээр иргэд хоорондын маргааныг шийдвэрлэдэг Ардын Эвлэрүүлэн Зуучлах Хорооны үйл ажиллагааг хэлнэ<sup>8</sup>.

**(Үндсэн зарчим)**

Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалын үндсэн зарчим нь (1) Маргалдагч талуудын хүсэл зоригийн чөлөөт илэрхийлэл, эрх тэгш байдлыг хангах зарчим, (2) Хууль тогтоомж, төрийн бодлогыг чандлан сахих зарчим, (3) Маргааныг хэрхэн шийдвэрлэх тухай маргалдагч талуудын сонголт хийх эрхийг хүндэтгэх зарчим юм.<sup>9</sup>

**(Үнэ төлбөргүй хэрэгжих)**

Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлал нь үнэ төлбөргүй хэрэгжих ба ард иргэдээс ямар нэг хураамж авахгүй<sup>10</sup>.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. Ардын Эвлэрүүлэн Зуучлах Хороо (§7-§12)**

**(Хэрэгжүүлэх байгууллага)**

Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалыг Ардын Эвлэрүүлэн Зуучлах Хороо<sup>11</sup> хэрэгжүүлнэ. Ардын эвлэрүүлэн зуучлах хороог хот тосгон, төвтэй эвлэрүүлэн зуучлах ажиллагсийн таларх зарим заалт<sup>12</sup>-ыг баталсан, Гэхдээ эдгээр нь бүтэ засиргааны хуум тогтоомжийн нэгдэхэн хэсэг бөгөөд Бүх Хятадын Иргэдийн Төлөөлөгчдийн Их Хурлаас баталсан "албан ёсны хууль" биш юм.

<sup>8</sup> АТЭЗХууль§2.

<sup>9</sup> АТЭЗХууль§3.

<sup>10</sup> АТЭЗХууль§4. Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал

(АТЭЗХорооны оффисийн төлбөр, тавилга, мэдээллийн хэрэгсэл, бичиг хэргийн зардал, ус цахилгааны төлбөр, зуучлагчийн хилс, утасны зардал зэрэг)-ыг АТЭЗХороог дэргэдээ байгуулал тухайн тусганы иргэдээс бүрдэх зөвлөл эсхүл хувийн компанийн хариуцан гаргана. Түүнчлэн муж, хот, бүс нутгийн хувьд олон нутгийн засаг захиргааны нэгжээс шаардлагатай зардлын зарим хэсгийг хариуцан гаргадаг (АТЭЗХууль§6).

<sup>11</sup> ИХШШХХ 16 дугаар зүйл "Ард төвтэй эвлэрүүлэн зуучлах хороо гэж тухайн бүс нутгийн засирга болон шүүх байгууллагын удирдлагад иргэд хоорондын маргааныг эвлэрүүлэн зуучлах олон нийтийн байгууллагыг хэлнэ". АТЭЗХ 7 дугаар зүйл "Ард төвтэй эвлэрүүлэн зуучлах хороо гэж хуулийн дагуу байгуулж иргэд хоорондын маргааныг эвлэрүүлэн зуучлах олон нийтийн байгууллагыг хэлнэ" гэжээ.

хувийн компаниудын дэргэд, шаардлагатай бол үйл ажиллагааны төрлөөр<sup>12</sup> төрөлжүүлэн байгуулж болно. Хороо нь 3-9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба нэг ахлах гүйшүүнийг сонгон томилно.<sup>13</sup> Ардын Эвлэрүүлэн Зуучлах Хорооны чнг үүрэгт иргэд хоорондын маргааныг эвлэрүүлэн зуучлахаас гадна, эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан хууль тогтоомж, төрийн бодлогыг иргэдэд таниулах, ард иргэдийг хууль дээдлэх ёсонд сургах, иргэд хоорондын маргаанаас урьдчилан сэргийлэх, төрийн захиргааны байгууллагад үйл ажиллагаагаа тайлагнах зэрэг орно<sup>14</sup>.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. Ардын Эвлэрүүлэн Зуучлагч (§13-§16)  
(Ардын эвлэрүүлэн зуучлагчид тавих шаардлага)

Эвлэрүүлэн зуучлагчийн хувиар хэргийг шийдвэрлэхэд оролцох этгээдийг Ардын эвлэрүүлэн зуучлагч гэнэ. Ардын эвлэрүүлэн зуучлагч нь Ардын эвлэрүүлэн зуучлах хорооны гишүүн эсхүл хорооны урилгаар ажиллах этгээд байна<sup>15</sup>. Ардын эвлэрүүлэн зуучлагч нь үнэнч шудрага, ажил үүрэгтээ идэвх зүтгэлтэй, тодорхой хэмжээний боловсрол, улс төрийн байр суурь, хуулийн мэдлэгтэй, насанд хүрсэн<sup>16</sup> Хятад Улсын иргэн байна.

Ардын Эвлэрүүлэн Зуучлагч нь талуудаас зуучлалын хураамж авахгүй.<sup>17</sup> Түүнчлэн зарчмын хувьд цалин хөлсгүй ажиллах боловч, өөрийн албан ёсны ажлаасаа чөлөө авч эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсон тохиолдолд улсаас тэтгэмж авна.<sup>18</sup>

ДӨРӨВДҮТЭЭР БҮЛЭГ. Эвлэрүүлэн зуучлалын журам (§17-§27)

(Өргөдөл гаргах)

Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалыг иргэний хэрэгт хэрэглэнэ.<sup>19</sup>

Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалыг маргааны аль нэг тал өргөдөл гаргаснаар эсхүл Ардын Эвлэрүүлэн зуучлах хорооны зааварчилгааны дагуу эхлүүлнэ. Аль ч тохиолдолд, маргааны аль нэг тал эвлэрүүлэн зуучлалаас татгалзаж буйгаа тодорхой илэрхийлсэн тохиолдолд эвлэрүүлэн зуучлалыг явуулж болохгүй.<sup>20</sup>

Жич, хуульд Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар өргөдөл гаргах газар нутгийн харьяаллын талаар заалт байхгүй.

<sup>12</sup> Ойрын жилүүдэд тодорхой мэргэжлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг дагнан явуулааг АЭЗХороо байгуулах болсон. Жишээлбэл, эмнэлгийн өснөөр мэргэшсэн Эмнэлгийн ослын Эвлэрүүлэн зуучлах хороо, үл мэдлэх хөрөнгөтэй холбогдох маргаанаар мэргэшсэн ҮХХ-ийн маргааныг ЭЗХороо байлаг.

<sup>13</sup> АТЭЗХууль§8.

<sup>14</sup> АТЭЗХууль§11.

<sup>15</sup> АТЭЗХууль§13.

<sup>16</sup> Хятадад 18 наснаас насанд хүрсэн гэж үздэг.

<sup>17</sup> АТЭЗХууль§4.

<sup>18</sup> АТЭЗХууль§16.

<sup>19</sup> АТЭЗХууль§1.

<sup>20</sup> АТЭЗХууль§17.

Түүнчлэн хуульд Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар хэрэг хүлээн авах журмын талаар ч заалт байхгүй<sup>21</sup>. Ардын эвлэрүүлэн зуучлах хороо өргөдлийг хүлээн авахдаа тухайн маргаан нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд нийцэж байна гэж үзсэн бол өргөдлийг хүлээн авч эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхлүүлж болно.

(Ардын эвлэрүүлэн зуучлагчийг сонгон томилох)

Тодорхой хэргийг хариуцан ажиллах Ардын эвлэрүүлэн зуучлагчийг АЭЗХорооноос сонгон томиж эсхүл талууд өөрсдөө сонгож болдог. Хэрэг тутамд нэг буюу хэд хэдэн зуучлагч ажиллана<sup>22</sup>.

Ардын эвлэрүүлэн зуучлагч нь шаардлагатай тохиолдолд талуудын зөвшөөрлийн дагуу тэдний төрөл садангийн хүмүүс болон хөрш, хамтран ажиллагсдыг эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд урьж оролцуулж болохоос гадна, тодорхой салбарын мэргэжлийн мэдлэгтэй хүмүүсийг урьж оролцуулж болдог<sup>23</sup>.

(Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэгжүүлэх)

Ардын эвлэрүүлэн зуучлагч нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахдаа эвлэрүүлэн зуучлалын үндсэн зарчим<sup>24</sup>-ыг баримтлан, ашигласан хууль тогтоомжоо тодорхойлон, ёс журамтай байж, үнэнч шударгаар ажиллах ёстой бөгөөд тохиромжтой хугацаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй<sup>25</sup>. Эвлэрүүлэн зуучлах уулзалтыг зуучлалын өрөөнөөс гадна тухайн маргааны “үүссэн газар” явуулж болно<sup>26</sup>.

(Талуудын эрх)

Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалд оролцогч талууд дараах эрхийг эдэлнэ<sup>27</sup>. (1) Ардын эвлэрүүлэн зуучлагчийг сонгох, хүлээн зөвшөөрөх эрх, (2) Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хүлээн зөвшөөрөх, татгалзан гарах, дуусгавар болгохыг шаардах эрх, (3) Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хаалттай эсхүл нээлттэй явуулахыг шаардах эрх<sup>28</sup>, (4) Өөрийн хүсэл

<sup>21</sup> Эвлэрүүлэн зуучлалын журмаар хэрэг хүлээн авснаар хөөн хэлэлцэх хугацаа тасалзана гэж хуульд заагдсан байдаг хэдий ч, хэргийг хүлээн авах тодорхой журам байхгүй явдал нь хөөн хэлэлцэх хугацааг хэвээрээ тасалзаныг тодорхойлох боломжгүй болгодог тул асуудалтай. Түүнчлэн эвлэрүүлэн зуучлалын журмаар хүлээн авсан хэргийн тоог тухайн байгууллага чөлөөтэй нэмж хасах боломжтой боловч тул АТЭЗ-ын үр шийгнйг хуурамчаар хөөргөн дүгнэх гэсэн үр дүнд ч хүрэх магадлалтай гэсэн шүүмжлэл бий.

<sup>22</sup> АТЭЗХууль§19.

<sup>23</sup> АТЭЗХууль§20.

<sup>24</sup> АТЭЗХууль§3-ын үндсэн зарчим. (1) Маргалагч талуудын хүсэл зоригийн чөлөөт илэрхийлэл, эрх тэгш байдлыг хангах зарчим. (2) Хууль тогтоомж, төрийн бодлогыг чандлан сахил зарчим, (3) Маргааныг хэрхэн шийдвэрлэх тухай маргалагч талуудын сонголт хийх эрхийг хүндэтгэх зарчим.

<sup>25</sup> АТЭЗХууль§21.

<sup>26</sup> АТЭЗХууль§21.

<sup>27</sup> АТЭЗХууль§23.

<sup>28</sup> Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг нээлттэй явуулахаар шаардаж ч болно, хаалттай явуулахаар шаардаж ч болно. Үүнч, талууд энэ асуудлаар санал зөрчилдсөн тохиолдолд яах талаар тодорхой заалт байхгүй.

зоригийг илэрхийлэх, өөрийн хүслээр эвлэрлийн тохиролцоонд хүрэх эрх.

(Талуудын үүрэг)

Ард төвтэй Эвлэрүүлэн зуучлалд оролцогч талууд дараах үүрэг хүлээнэ<sup>29</sup>. (1)Бодит нөхцөлийн талаар үнэн зөв мэдүүлэх үүрэг, (2) Эвлэрүүлэн зуучлалын дүрэм, журамд захирагдан, ардын эвлэрүүлэн зуучлагчийг хүндэтгэн харьцах үүрэг, (3) Эсрэг тал эрхээ хэрэгжүүлэхэд хүндэтгэлтэй хандах үүрэг. Жич, Ардын эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд талууд дээрх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар заалт байхгүй<sup>30</sup>.

(Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болох)

Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар талууд харилцан ярилцсан хэднй ч эвлэрэхгүй тохиолдолд тухайн ажиллагааг дуусгавар болгоно. Энэ тохиолдолд Ардын эвлэрүүлэн зуучлагчын зүгээс талуудад хуулийн дагуу арбитрын журмаар, захиргааны журмаар, шүүхийн журмаар эрхээ хамгаалж болох тухай мэдэгдэх үүрэгтэй<sup>31</sup>.

(Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тэмдэглэл)

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тэмдэглэлийн хувьд, Ардын эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцыг тэмдэглэх үүрэгтэй. Түүнчлэн Ардын эвлэрүүлэн зуучлах хороо нь хэргийн бүртгэл хийж, ажиллагааны тэмдэглэл, эвлэрлийн гэрээ зэргийг боловсруулах, хадгалах үүрэг хүлээнэ<sup>32</sup>.

ТАВДУГААР БҮЛЭГ. Эвлэрлийн гэрээ (§28-§33)

(Эвлэрлийн гэрээ боловсруулах)

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дүнд талууд тохиролцоонд хүрсэн бол эвлэрлийн гэрээ боловсруулж болно<sup>33</sup>.

Эвлэрлийн гэрээнд дараах агуулгыг тусгаж болно<sup>34</sup>. (1)Талуудын талаар ерөнхий мэдээлэл<sup>35</sup>, (2) Маргааны нөхцөл, маргааны гол зүйл, талуудын хэн буруутай болох<sup>36</sup>, (3) Тохиролцсон агуулга, үүргээ

<sup>29</sup> АТЭЗХууль§24.

<sup>30</sup> Мэдээж Эвлэрүүлэн зуучлагчид гар хүрэх зэргээр эрүүтний хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжинд харшлал үйлдэл хийвэл тухайн хууль тогтоомжийг үндэслэн хариуцлага хүлээлгэнэ.

<sup>31</sup> АТЭЗХууль§26. АТЭЗХорооны үйл ажиллагааны тухай хууль§9.2.

<sup>32</sup> АТЭЗХууль§27.

<sup>33</sup> АТЭЗХууль§28. Гэрээг амаар хийж болно.

<sup>34</sup> АТЭЗХууль§29.1. Эдгээр агуулгыг эвлэрлийн гэрээнд тусгаж болох бөгөөд заавал тусгах шаардлагагүй юм. Ард төвтэй эвлэрүүлэн зуучлал нь талуудын хүсэл зоригийн чөлөөт илэрхийлэлд үндэслэдэг тул эдгээр агуулгыг ч мин тусгавал эхлэстэй гэдэг үүднээс санал болох байдлаар зааж өгснө.

<sup>35</sup> Тухайлбал, овог, нэр, хаяг, албан тушаал, нас зэрэг орно. Гэр бүлийн маргааны хувьд талууд хоорондоо ямар холбоотой болохыг ч мин бичнэ.

<sup>36</sup> Маргааны шалтгаан, маргаан үүсгэсэн этгээд зэргийг бичнэ. Жич, эвний журмаар маргааныг шийдвэрлэх үүднээс талуудын хэн нь буруутайг бичих нь эхлэсгүй тохиолдол байх тул эвлэрлийн гэрээнд бичих эрхийг маргааны нөхцөл байдлыг харгалзан шийдэх нь зүйтэй.

гүйцэтгэх арга хэлбэр, хугацаа<sup>37</sup>.

(Эвлэрлийн гэрээ хүчин төгөлдөр болох)

Эвлэрлийн гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарж, ардын эвлэрүүлэн зуучлах хорооны тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Эвлэрлийн гэрээг талууд тус бүр нэг хувь авч хадгалах ба Ардын эвлэрүүлэн зуучлах хороонд нэг хувийг хадгалж үлдэнэ<sup>38</sup>.

(Эвлэрлийн гэрээний хүчин төгөлдөр байдал)

Эвлэрлийн гэрээ нь хуулийн хүчин төгөлдөр бөгөөд талууд гэрээний үүргээ биелүүлэх үүрэгтэй<sup>39</sup>.

(Хүчин төгөлдөр бус эвлэрлийн гэрээ, эвлэрлийн гэрээг хүчингүй болгох)

Дараах тохиолдолд, эвлэрлийн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцно<sup>40</sup>.

(1) Төрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндсөн байвал, (2) Хууль бус зорилгын дагуу хийсэн байвал, (3) Нийтийн эрх ашгийг хөндсөн байвал, (4) Хууль зөрчсөн байвал, (5) Ардын эвлэрүүлэн зуучлах хорооны албадлагын дагуу эвлэрүүлэн зуучлах ажилаагаа явуулсан бол.

Дараах тохиолдолд эвлэрлийн гэрээг хүчингүй болгож болно.<sup>41</sup> (1) Ноцтой төөрөгдлийн улмаас хийсэн бол, (2) Эвлэрлийн гэрээ байгуулах үед талуудын эрх тэгш байдал хангагдаагүй нь тодорхой байсан бол, (3) Залилан мэхэлж, айлган сүрдүүлж хийсэн бол.

(Эвлэрлийн гэрээний биелэлтийг хянах)

Ардын эвлэрүүлэн зуучлах хороо нь эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг талуудаас шаардах ёстой.<sup>42</sup> Эвлэрлийн гэрээ байгуулсны дараа талуудын хооронд гэрээний үүргийн биелэлтийн тухай болон гэрээ хүчин төгөлдөр эсэх тухай маргаан үүссэн тохиолдолд аль нэг тал нь Ардын шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.<sup>43</sup>

(Эвлэрлийн гэрээг шүүхээр баталгаажуулах)

Эвлэрлийн гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор талууд Ардын шүүхэд хандан тухайн гэрээг шүүхээр баталгаажуулах хүсэлт тавьж болно.<sup>44</sup> Ардын шүүх эвлэрлийн гэрээг хүчин төгөлдөр гэж баталгаажуулсан бол талуудын аль нэг нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд эсрэг тал нь албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргах эрхтэй<sup>45</sup>.

<sup>37</sup> Мөнгөн төлбөр хийх үүргийн хувьд төлбөрийн хэмжээ, төлбөр хийх эцсийн хугацаа, хувааж төлөх эсэх, бэлэн мөнгөөр төлөх, банкаар шилжүүлэх эсэх зэргийг тусгана.

<sup>38</sup> АТЭЗХууль§29.2.

<sup>39</sup> АТЭЗХууль§31.2.

<sup>40</sup> Ард түвтэй эвлэрүүлэн зуучлалын тохиролцооны дүрэм §5.

<sup>41</sup> Ард түвтэй эвлэрүүлэн зуучлалын тохиролцооны дүрэм §6.

<sup>42</sup> АТЭЗХууль§31.2.

<sup>43</sup> АТЭЗХууль§32.

<sup>44</sup> АТЭЗХууль§33.1.

<sup>45</sup> АТЭЗХууль§33.1-3. Баталгаажуулах тухай гаргасан хүсэлтийн дагуу Ардын шүүх эвлэрлийн гэрээг хүчингүй тооцсон тохиолдолд талууд Ард түвтэй эвлэрүүлэн зуучлалын журмаар эвлэрлийн гэрээнд өөрчлөлт

(Эвлэрлийн гэрээг нотариатаар баталгаажуулах)

Эвлэрлийн гэрээнд “үүргийн гүйцэтгэлийн тухай заалт” байгаа тохиолдолд талууд нотариатын байгууллагад хандан тухайн гэрээг баталгаажуулах хүсэлт гаргаж болох ба ингэснээр тухайн гэрээний үүргийг албадан гүйцэтгүүлэх боломжтой болно<sup>46</sup>.

ЗҮРГААДУГААР БҮЛЭГ. Бусад (§34-§35)

• Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн дагуу шинээр бий болсон тогтолцоо

Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь урьдаас хэрэгжиж ирсэн ард төвтэй эвлэрүүлэн зуучлах тогтолцоог хуульчилан тодорхой болгосон төдий тул хууль баталснаар энэ тогтолцоонд ямар нэг томоохон өөрчлөлт ороогүй юм.

Хууль баталснаар шинээр бий болсон зарим нэг тогтолцооноос хамгийн чухал нь “эвлэрлийн гэрээг шүүхээр баталгаажуулах (§33)” тухай заалт юм<sup>48</sup>.

33 дугаар зүйл.

33.1 Ардын эвлэрүүлэн зуучлах хорооноос явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дүнд эвлэрлийн гэрээ байгуулсан тохиолдолд талууд шаардлагатай гэж үзвэл эвлэрлийн гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс 30 хоногийн дотор Ардын шүүхэд хандан тухайн гэрээг шүүхээр баталгаажуулахаар хамтран хүсэлт тавьж болно. Ардын шүүх зохистой хугацаанд эвлэрлийн гэрээг нягтлан үзэж, хуулийн дагуу эвлэрлийн гэрээ хүчин төгөлдөр болохыг баталгаажуулна.”

33.2 Ардын шүүх эвлэрлийн гэрээг хүчин төгөлдөр гэж баталгаажуулсан бол талуудын аль нэг нь үүргээ биелүүлэхээс татгалзах эсхүл бүхэлд нь биелүүлэхгүй тохиолдолд эсрэг тал нь албадан гүйцэтгүүлэхээр Ардын шүүхэд хүсэлт гаргах эрхтэй.

33.3 Ардын шүүх хуулийн дагуу эвлэрлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж баталгаажуулсан бол талууд Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын

орчуулах эсхүл шинээр гэрээ байгуулж болдог. Түүнчлэн Ардын шүүхэд нэхэмжлэл гаргаж болдог.

<sup>46</sup> Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалын тохиролцооны дүрэн §10.

Үүнээс гадна, талууд эвлэрлийн гэрээний агуулгаар “төлбөрийн захирамж” гаргуулахаар шүүхэд хүсэлт тавьж болно. Энэ тохиолдолд төлбөрийн захирамжид гомдол гаргалгүй бол тухайн захирамж нь шүүхийн шийдвэртэй адил хүчин төгөлдөр болно.

Түүнчлэн ойрын жилүүдэд Арбитрын хороод эвлэрлийн гэрээг үлдсэн арбитрын шийдвэр гаргах үйлчилгээ үзүүлдэг болсон ба арбитрын шийдвэр нь албадан биелүүлэх боломжтой тул эвлэрлийн гэрээг нийм аргаар албадан биелэх боломжтой болгож болно гэж үздэг.

<sup>47</sup> Жич, Хятадын иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэл нь шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо сайн цагтэргүүгээс болон нийгмийн бусад хүчин зүйлээс шалтгаалан сайн хэрэгжиж чаддаггүй байна. Эвлэрлийн гэрээг албадан биелүүлэх боломжтой болгосон ч шийдвэр гүйцэтгэлийн шатанд нээгдэв явцтай байдаггүй сайтар аялаарал хэрэгтэй.

<sup>48</sup> Жич, Шүүх төвтэй эвлэрүүлэн зуучлалын хувьд эртнээс эвлэрлийн гэрээг баталгаажуулж ирсэн.

журмаар эвлэрлийн гэрээг өөрчлөх эсхүл шинээр эвлэрлийн гэрээ байгуулж болох ба түүнчлэн Ардын шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь нээлттэй.

Ард төвтэй эвлэрүүлэн зуучлах тогтолцоо нь талуудыг чөлөөтэй оролцож, татгалзах эрхийг хамгаалсан байдаг хэдий ч талуудын зүгээс эвлэрчих юм сан, үүргээ биелүүлчих юмсан гэсэн сэтгэл зүйн сэдэл илүүтэй төрдөг. Өөрөөр хэлбэл Ардын эвлэрүүлэн зуучлах хороо нь өөрийн амьдардаг тосгоны хэмжээнд эсхүл ажлын газрын хэмжээнд байгуулагддаг ба гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх эсэхэд Хороо хяналт тавьж байдаг тул энэ хүрэн дэх нийгмийн харилцаагаа хадгалж үлдэх сонирхлын үүднээс талууд үүргээ биелүүлэхээс өөр аргагүй болдог талтай гэж үздэг<sup>49</sup>.

Шинэ хуулиар шинээр бий болсон эвлэрлийн гэрээг шүүхээс баталгаажуулах тогтолцоо нь эвлэрлийн гэрээг албадан гүйцэтгүүлэх боломжийг хангасан юм. Энэхүү заалт нь Ард төвтэй эвлэрүүлэн зуучлалыг ард иргэд өргөнөөр ашиглахад түлхэц болж өгнө гэж үздэг байна<sup>50</sup>.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын хувьд 2006 оноос Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дэргэд “Иргэний Эрх зүйн тусалцаа үзүүлэх, маргааныг эвлэрүүлэн зуучлах LGL төв”-ийг байгуулан, 2010 оноос шүүхэд эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судалж эхлээд байна.<sup>51,52</sup> 2011 оны сүүлээр Олон нийтийн байгууллагын дэргэдэх эвлэрүүлэн зуучлал, шүүх дэх эвлэрүүлэн зуучлал гэсэн хоёр баганатай “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”-ийг боловсруулан УИХ-д өргөн бариад байна. Сүүлийн үед зурагт радио, сонин хэвлэлээр эвлэрүүлэн зуучлалын тухай танилцуулах болсон бөгөөд ард иргэдийн дунд эвлэрүүлэн зуучлалын талаар сонирхох хандлага харагдаж байна.

Монгол Улсад эвлэрүүлэн зуучлах тогтолцооны талаар Америкийн Нэгдсэн Улс болон Япон Улсын туршлагаас судалсан байх тохиолдол харьцангуй их хэдий ч хөрш орон болох Хятад Улсын ADR-ын тогтолцооны талаар бараг судлаагүй байгаа нь гайхаш төрүүлж байсан

<sup>49</sup> Үүнээс гадна, Ард төвтэй эвлэрүүлэн зуучлал нь “Олон нийтийн байгууллагын зүтээх маргаан шийдвэрлэл” байгаа ба нэгичтэйгүүр олон нийтийн байгууллага нь өөрсө урх мэдлээр дутмаг тул талууд тэнд хийсэн эвлэрлийн гэрээний үүргээ сайн дураар гүйцэтгэх магадлал бага гэж үзэх үзэл ч бий.

<sup>50</sup> Жич, албадан биелүүлэх болмж практикт хүндрэлтэй байх магадлалтай. 47-г үзнэ үү.

<sup>51</sup> Аль аль нь Жайкагаас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хэрэгжиж байна.

<sup>52</sup> 2011 оноос Баянзүрх дүүргийн шүүх болон Дархан-Уул аймгийн Сүм дундын шүүхэд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг туршилтын журмаар нэвтрүүлж эхлээд байна.

юм. Гэсэн хэдий ч удиртгал хэсэгт танилцуулсанчлан шүүхийн ачаалал их, иргэдийн зүгээс маргааныг эвийн журмаар шийдвэрлэх сонирхол өндөр байдаг зэрэг нь Монгол, Хятад хоёр улсын хувьд төстэй хүчин зүйлүүд юм. Монгол Улсад эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх үйл явц өрнөж байгаа энэ үед Хятад Улсын Ард төвтэй эвлэрүүлэн зуучлах тогтолцоог товч танилцуулсан энэхүү судалгааны бичвэрээс санаа авах зүйл гарах болов уу гэдэг үүднээс энэхүү бичвэрийг боловсруулсан.

## ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ СОНИН

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Хууль зүйн мэдээ” сонин нь хууль зүйн салбарын анхны хэвлэл бөгөөд 2003 оны 4 дүгээр сарын 18-нд анхны дугаараа гаргаж байсан юм.

Тус сонин 14 хоногт 1 удаа А3 хэмжээтэйгээр хэвлэгдэн гарч байна.

“Хууль зүйн мэдээ” сонины нийтлэлийн зорилго

- ХЗДХЯ-ны харьяа байгууллагуудын мэдээлэл болон салбарын хэмжээнд гарсан чухал үйл явдлыг түүвэрлэн шинэ мэдээ, мэдээллийг уншигчдад цаг тухай бүрт нь хүргэх;

- Уншигчдын хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлийн материалыг түлхүү нийтлэх;

- Хууль зүйн салбарын хүрээнд хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны тайлан болон судлаачдын өгүүлүүдийг уншигчдын хүртээл болгох.

“Хууль зүйн мэдээ” сонины редактораас уншигчдын хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль зүйн салбарын шинэ мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нь үнэн бодитойгоор хүргэх үүднээс “Хууль төрөхийн өмнө”, “Маргаашийн хуульчид өнөөдөр бичиж байна”, “Хуульч өгүүлж байна” зэрэг байнгын буланг тогтмол ажиллуулж байна.

Хууль, эрх зүйн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авахыг хүсвэл хууль зүйн салбарын хэвлэл “Хууль зүйн мэдээ” сониноо захиалаарай.





## Гадаад орнуудын жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалт



МУИС-ийн Худалдааны сургуулийн  
Бизнесийн эрх зүйн тэнхимийн ахлах  
багш, МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч,  
магистр (LLM) О.Чулуунцэцэг

**Ж**ижиг, дунд үйлдвэрийн эдийн засгийн ач холбогдол, эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмрийг хүлээн зөвшөөрч буй илрэл нь улс орнуудын засгийн газар жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд улам түлхүү анхаарах болсон явдал юм. Тухайлбал, бизнес эрхлэлтийг дэмжих, жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэгдсэн төрөл бүрийн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлсээр байна. Эдгээр эрх зүйн актууд нь гол төлөв жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалт, санхүүжилт, технологи, холбогдох шинэчлэл, менежмент болон олон улсын хамтын ажиллагаа гэх зэрэг чиглэлээр тулгамдаж буй саад бэрхшээлийг арилгахад чиглэгдсээр байна.

Жижиг, дунд үйлдвэрийн эдийн засгийн нөлөөллийг авч үзвэл Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагын (OECD)-ийн орнуудын нийт аж ахуйн нэгжүүдийн 95-аас дээш хувийг жижиг дунд үйлдвэр эзэлж, дотоодын нийт бүтээгдэхүүний дийлэнх хувийг бүрдүүлж, хувийн хэвшил дэх хөдөлмөр эрхлэлтийн 50-иас дээш хувийг бүрдүүлдэг гэсэн судалгаа байдаг. Түүнчлэн жижиг дунд үйлдвэр нь шинэ ажлын байрыг бий болгосоор байна.

Ер нь жижиг дунд үйлдвэрийг төр, засгаас дэмжсэнээр дараах эдийн засгийн үр өгөөжийг бий болгож байна. Үүнд:

- Эдийн засгийн өсөлт, ашгийг бий болгож, үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүнд хувь нэмрээ оруулах;
- Татварын орлогыг нэмэгдүүлэх;
- Дотоодын ажил эрхлэлтийн боломжийг нэмэгдүүлэх;
- Компаниудын өрсөлдөх чадвараа хадгалах нөхцөлийг бүрдүүлэх;
- Бүс нутгийн хөгжилд нөлөөлөх, мөн хөрөнгө оруулалт татах гэх мэт.

Түүнчлэн олон улсын үйл ажиллагаанд дараах боломжийг бүрдүүлдэг байна. Тухайлбал:

- Худалдааны эргэлт болон ашгийг нэмэгдүүлэх;
- Дотоодын зах зээл дэх хэрэглээний уналт буюу түүний хэлбэлзлийн сөрөг үр дагаврыг сааруулах;
- Сүүлийн үеийн технологи ашиглах бололцоо нэмэгдэх;
- Хүний нөөцийн бололцоог илүүтэй ашиглах;
- Өрсөлдөгч компаниудаас суралцах боломж нээгдэх;
- Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гэх мэт.

Дээрх жижиг дунд үйлдвэрийн эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал чухлаар тавигдсаар байна. Ингээд зарим улс орнуудын жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалт, түүний эдийн засгийн бодлогыг авч үзье.

*1. Польш Улсын жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалт, түүний эдийн засгийн бодлого*

Польш Улс нь 1989 онд зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн. 1995 оноос эхлэн Польшийн Засгийн газар нь жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэн дэмжих зорилгоор хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлж, бодлого боловсруулсан. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлого нь дараах зорилттой байв. Үүнд:

- Үндэсний эдийн засаг дахь жижиг, дунд үйлдвэрийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх
- Жижиг, дунд үйлдвэрийн экспортын хэмжээг нэмэгдүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйлчилгээний орчин үеийн салбарыг бий болгох гэх мэт.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих эрх зүйн субъектын тогтолцоо нь Эдийн засгийн яам, Экспортыг дэмжих газар, Польш Улсаас гадаад орнуудад суугаа Элчин сайдын яамны Худалдааны хэлтэс, Бизнес эрхлэлтийг хөгжүүлэх Польш Улсын Агентлаг, Үндэсний зөвлөлийн

үйлчилгээний тогтолцоо, Гадаад худалдааны хүрээлэн, Экспортын кредитийн даатгалын корпораци, Үндэсний эдийн засгийн банк гэх мэт байгууллагуудаас бүрдэнэ.

Жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн.

1. Үндэсний эдийн засаг дахь жижиг, дунд үйлдвэр ба жижиг, дунд үйлдвэрт чиглэсэн бодлогын баримт бичиг (1995 он). Тус баримт бичиг нь:

- Сайд нарын зөвлөлөөс баталсан Үйлдвэрлэлийн бодлогын удирдамж (1993 он);

- Сайд нарын зөвлөлөөс баталсан Үйлдвэрлэлийн бодлогын удирдамж, Польш Улсын үйлдвэрлэлийн олон улсын түвшин дэх өрсөлдөх чадвар (1995 он);

- Жижиг, дунд үйлдвэрт чиглэсэн төрийн бодлогод тавих Европын холбооны дүрэм ба шаардлагуудад үндэслэсэн.

2. 2002 он хүртэлх жижиг, дунд үйлдвэрт чиглэсэн төрийн бодлогын баримт бичиг (1998 он). Энэхүү бодлогын зорилго нь жижиг, дунд үйлдвэрийн салбарын хөгжлийн боломжийг бий болгох, бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн.

3. 2003-2006 онуудын Жижиг, дунд үйлдвэрт чиглэсэн засгийн газрын бодлогын удирдамж (2002 он). 2006 он хүртэлх жижиг, дунд үйлдвэрт чиглэсэн төрийн бодлогын үндсэн зорилго нь жижиг, дунд үйлдвэрийн салбарын эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, тус салбар дахь ажил эрхлэлтийн өсөлт, өрсөлдөх чадвар, Европын нэгдмэл зах зээл дээр үйл ажиллагаагаа явуулах чадварыг тус тус нэмэгдүүлэхийг зорьсон.

4. Жижиг, дунд үйлдвэрийн экспортыг хөхүүлэн дэмжих ЭКСПРОМ хөтөлбөр (1992 он)

5. Татаасын тухай хууль (2001 он).

Дээрх эрх зүйн зохицуулалтын хүрээнд хийгдэж буй эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр нь жижиг, дунд үйлдвэрийн хөгжил, экспорт, бүс нутгийн хөгжил, орчин үеийн технологийн ашиглалт, ажлын байр бий болгох, хүний нөөцийн хөгжил, ажилгүйдлийг бууруулах, ноу-хау, эдийн засгийн мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ олж авах боломжоор бизнес эрхлэгчдийг хангах зорилгоор хэрэгжсэн.

2. Чех Улсын жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалт, түүний эдийн засгийн бодлого

Чех Улсын Засгийн газрын бодлого нь дараах гурван зорилтыг тавин ажилласан. Үүнд:

- Нэг хүнд ноогдох экспортын хэмжээг нэмэгдүүлж, үүнийг хэмжээний хувьд харьцуулж болохуйц бусад Европын улс орны жишигт хүргэх;
- Экспортын өсөлтийг дэмжих, ялангуяа нэмүү өртөг бүхий экспортыг түлхүү дэмжих замаар худалдааны тэнцлийн үзүүлэлтэд эерэг нөлөө бий болгох;
- Тус орны нийт экспортод эзлэх жижиг, дунд үйлдвэрийн хувь хэмжээг нэмэгдүүлэх.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого нь аж ахуйн нэгжүүдийн хэмжээг үл харгалзсан байдлаар тэдгээрт дэмжлэг үзүүлэх тогтолцоо бий болгох, таатай нөхцөл бүрдүүлдэг байна.

Чех Улсын жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлогын хэтийн зорилт нь дараах байдлаар тодорхойлогддог. Тухайлбал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн нөхцөл болох үндэсний эдийн засгийн өсөлт бий болгох, технологийн хөгжил дэвшил, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажилгүйдлийг багасгах, бүс нутгийн, нийгмийн давхаргын ба эдийн засгийн ялгааг арилгах зэрэг чиглэлээр жижиг, дунд үйлдвэр нь хувь нэмрээ оруулж чадахуйц нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн.

Жижиг, дунд үйлдвэрийн экспортыг хөгжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг төрийн тогтолцооны байгууллага нь Худалдаа, үйлдвэрийн яам, Худалдаа, экспортыг дэмжих зөвлөл, Худалдааг дэмжих агентлаг, Экспортын зээлийн даатгалын компани, Экспортын банк зэрэг болно.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд дараах эрх зүйн актуудыг боловсруулсан. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэрт зориулсан тусламжийг хуваарилах журам (1992 он);
2. Жижиг, дунд үйлдвэрийг төрөөс дэмжих тухай хууль (2000 он);
3. Гадаад хэргийн яам болон Худалдаа үйлдвэрийн яам хоорондын хамтын гэрээ (1997 он).

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлогын хүрээнд Чех Улсын жижиг дунд үйлдвэрүүд нь тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж тусгайлан боловсруулсан хөтөлбөрөөр дамжуулан улсын төсөв буюу бусад эх үүсвэрээс өөрсдийн баримжаа бүхий бизнесийн төлөвлөгөөний зориулалтаар санхүүжилт авдаг байна.

3. Бүгд Найрамдах Солонгос Улсын жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалт, түүний эдийн засгийн бодлого

Жижиг, дунд үйлдвэрийн төрийн байгууллагыг бий болгоход хөгжлийн эхний үе шатнаас анхаарч эхэлсэн. Худалдаа, үйлдвэрийн яаманд Жижиг, дунд үйлдвэрийн газрыг 1960 онд, Үйлдвэрлэл дэмжих захиргааг 1973 онд, Жижиг бизнесийг дэмжих корпорацыг 1979 онд, Бизнесийн инкубаторыг 1997 онд, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих Ерөнхийлөгчийн комиссыг 1998 онд, Жижиг, дунд үйлдвэрийн экспортын төвийг 1998 онд тус тус байгуулсан.

Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн эхэн үед Жижиг, дунд үйлдвэрийн хоршооны тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрийн технологийн шинэчлэлийг дэмжих хууль, Машин, тоног төхөөрөмжийг хүртээх тухай арга хэмжээг баталж, энэ гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн.

Бүгд Найрамдах Солонгос Улс нь тухайн үеийн эдийн засгийн хөгжил, байдлаас шалтгаалан импортыг хязгаарлаж экспортыг дэмжих Гадаад худалдааны хууль (Foreign Trade Act)-ийг 1957 онд баталсан боловч 1967 онд Худалдааны үйл ажиллагааны хууль (Trade Transaction Act)-ийг батлан, 1986, 1996 онд нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан. Тухайлбал, анхны хуулиар гадаад худалдааны нэлээд хязгаарлалттай, зөвшөөрөл лиценз шаардсан системийг тогтоосноор экспортын үйл ажиллагааг дэмжих, экспортын татаас олгох, татварын таатай нөхцөл үзүүлж байсан ба харин гадаадын тусламж их, импортын хязгаарлалт, гаалийн тариф өндөр байсан.

Түүнчлэн 1967 оны хуулиар тусгай зөвшөөрөл шаардлагатай бараанд экспорт, импортын зөвшөөрлийг Худалдаа, үйлдвэрийн яам олгох болсон. Бүгд Найрамдах Солонгос Улс нь өөрийн орны оюуны өмчийн эрх, хөдөө, аж ахуйн бараа, бүтээгдэхүүнийг хамгаалах арга хэмжээ авч байсны зэрэгцээ импортын хатуу бодлого, гадаадын хөрөнгө оруулалтыг либералчилах, гаалийн өндөр татварыг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч, дотоодын үйлдвэрлэгчдийн эрх ашгийг дээгүүрт тавьж, экспортыг дэмжих бодлогыг засгийн газрын гадаад харилцааны гол асуудал болгосон.

1996 оны хуулийн өөрчлөлтөөр экспорт, импортын зарчим, стратегийн холбогдолтой барааны худалдааг зохицуулах, үйлдвэр экспортлох, барааны гарал үүслийг тодорхойлох, импортыг хязгаарлах, экспорт, импортын барааны үнийн хөөрөгдлийг хязгаарлах, маргааныг шийдвэрлэх зэрэг нэлээд асуудлыг хуульчилж чадсан.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ нь дээр тэмдэглэсэнчлэн хөгжлийн онцлог, тухайн үеийн эдийн засгийн

хөгжлийн бодлоготой уялдаатай хөгжсөн. 2003 оноос хойш жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого нь:

- Жижиг, дунд үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх эхлэлийн үеийг хөнгөвчлөх;

- Үр өгөөжтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлэх;

- Жижиг, дунд үйлдвэрийг ажиллах хүчнээр хангах;

- Жижиг, дунд үйлдвэрийн зах зээлд гарах боломжийг сайжруулах;

- Технологийн шинэчлэл хийх чадварыг бий болгох;

- Хамтарсан бизнесийг дэмжих зэрэг чиглэлээр хэрэгжсэн.

Бүгд Найрамдах Солонгос Улсын үйлдвэр эрхлэгчдийн өнөөгийн зорилго нь төрөлжсөн компанийн хөрөнгө нь 7 миллиард вонноос доошгүй, өндөр технологийн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлосон байх, экспорт нь өмнөх жилийн хэмжээнээс 50-нас доошгүй хувьтай байх гэх мэт зарчмыг баримтлан ажиллах болсон.

4. Хятад Улсын жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн зохицуулалт, түүний эдийн засгийн бодлого

1979 оноос эхлэн Бүгд Найрамдах Хятад Ард Улс социалист, төлөвлөгөөт эдийн засгаа нээлттэй байлгаж, зах зээлийн чөлөөт эдийн засгийн шинж чанарыг агуулж байсан. Хятад Улсад үйлдвэр эрхлэгчдийг улсын өмчит, хамтын өмчит, хувийн өмчит гэж гурав ангилна. Санхүүгийн тогтвортой байдлын хувьд улсын болон хамтын өмчийн үйлдвэрийн нэгжүүд хувийн үйлдвэр эрхлэгчдийг бодвол илүү найдвартай байдаг. Учир нь төрийн санхүүжилт авах бүрэн боломжтой. Хамтын өмчийн үйлдвэр нь Хятадын хоёр дахь гол үйлдвэр юм. Үүнийг нутгийн захиргаа удирдан явуулах бөгөөд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг улсын төлөвлөгөөний дагуу хийнэ.

Хятад Улсад 300 000 гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэр ажилладаг. Гадаадын үйлдвэр эрхлэгчид нь бүрэн өмчлөлийн хамтарсан аж ахуйн нэгж байдаг. 1986 оны Гадаадын аж ахуйн нэгжийн тухай хууль, 1990 оны журмын дагуу гадаадын аж ахуйн нэгж төрийн хяналтад байдаг. Ингэснээр тухайн засгийн газар Хятад Улсын оролцоогүй үйлдвэр байгуулах боломжтой юм. Гадаадын үйлдвэр эрхлэгчид нь орчин үеийн техник, технологи хэрэглэх бөгөөд бараа бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг экспортлох үүрэгтэй байдаг. Хятад Улсад үйлдвэрийг санхүүжүүлэх гурван эх үүсвэр байна. Үүнд:

- Төрөөс санхүүжилт авах;

- Хувьцаа эзэмшигчид хувьцаа худалдаж авах замаар хөрөнгө

нэмэгдүүлэх;

- Арилжааны банкнаас зээл авах;
- Компани өөрийн хадгалсан хөрөнгийг хэрэглэх.

1988 оноос санхүүгийн сайд шинэ бизнесийн эрх зүйн орчныг бүрдүүлж эхэлсэн. Жишээлбэл, Аж ахуйн нэгжийн тухай хууль, Хамтарсан үйлдвэрийн тухай хууль, Корпорацийн тухай хууль, Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тухай хууль, Шударга бус өрсөлдөөний тухай хууль гэх мэт. Жишээлбэл, хамтарсан үйлдвэр хөрөнгө оруулахдаа хөрөнгө оруулалтын зээл, лизингийн хөрөнгө эсвэл гуравдагч этгээдийн өмчийг хэрэглэх гэсэн хэлбэртэй байдаг.

Хамтарсан үйлдвэр нь захирлуудын зөвлөл, ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, захирлуудтай байна. Хамтарсан үйлдвэр байгуулахад технологийн хувь оролцоо гадны хөрөнгө оруулалтын 50%-иас хэтрэхгүй байдаг. Санхүүгийн тайланг хятадын эрх бүхий нягтлангаар шалгасны дараа ноогдол ашиг хуваарилна. Хамтарсан үйлдвэр нь хувьцаат хамтарсан үйлдвэр, гэрээт хувьцаат компани, гадаадын 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани гэсэн 3 төрөлтэй. Тухайлбал, хамтарсан үйлдвэрийн энгийн үйл ажиллагаа 30-50 жилийн хугацаатай байна. Зарим тохиолдолд дэвшилтэт технологи нэвтрүүлж байгаа хамтарсан үйлдвэрт хугацаагүй эрх олгодог. Хувьцаа нь шилжих эрхгүй бөгөөд Хятадын Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх боломжгүй. Хувьцаанд бэлэн мөнгө, барилга, тоног төхөөрөмж, материал, оюуны өмчийн эрх, газрын эрх хамаарах ба хэмжээг нь Засгийн газраас батална.

Гадаадын үйлдвэрлэл эрхлэгчдийг зөвхөн үйлдвэрлэсэн барааны доод тал нь 50% нь экспортлогддог буюу дэвшилтэт технологи хэрэглэх тохиолдолд бүртгэдэг байна. Хятад Улсад технологи импортлох нөхцөл нь:

- Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадвартай;
- Бараа, бүтээгдэхүүний чанар гүйцэтгэлийг сайжруулах, бүтээгдэхүүний зардлыг бууруулах, цахилгаан эрчим хүч, түүхий эд хэмнэлтэй байх;
- Дотоодын нөөц бололцоо сайн ашигладаг байх;
- Экспортыг нэмэгдүүлж, гадаад валютын орлогыг нэмэгдүүлэх;
- Хүрээлэн буй орчинд хор нөлөөгүй;
- Үйлдвэрлэлийн аюулгүй байдал хангагдсан;
- Менежментийг сайжруулсан;
- Шинжлэх ухаан, техникийн түвшинд ололттой байх гэх мэт.

1993 онд Хятад Улс Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хууль баталсан бөгөөд гадаадын

үйлдвэр эрхлэгчдэд нэг татварын хэмжээ тогтоосон. Гадаадын үйлдвэр эрхлэгчид Хятадад олсон орлогоос татвар төлөх бол дотоодын үйлдвэр эрхлэгчид бүхий л төрлийн татвар төлнө. Дотоодын үйлдвэрлэгчдийн татварын ерөнхий хэмжээ 55% бол гадаадын үйлдвэрлэгчид 33%-ийн татвар төлнө. Хэрэв гадаадын аж ахуйн нэгж тодорхой үйл ажиллагаа явуулаагүй бол идэвхгүй орлогоос 20%-ийн татвар төлнө.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд улс орон бүр анхаарлаа хандуулсаар байна. Тухайлбал, Испани Улсад жижиг, дунд үйлдвэрийг дэмжих III хөтөлбөр үйлчилдэг бол Польш Улсад "Өрсөлдөх чадвартай үйлдвэрлэгчдийг дэмжих хөтөлбөр", Унгар Улсад жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөгжлийн стратеги боловсруулсан, Хятад Улсад "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх улсын төсөв"-ийг баталж (жижиг, дунд үйлдвэрийн салбарт 65%-ийг патент, 75%-ийг техникийн шинэчлэл, 80-аас илүү хувийг Хятадын шинэ бүтээгдэхүүн эзэлдэг ба жижиг, дунд үйлдвэрийн 46.2%-ийг татварын орлого, Хятадын нийт экспортын хэмжээний 62.3%-ийг эзэлдэг), мөн "Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн департамент"-ыг байгуулсан бөгөөд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санхүүгийн системийг бий болгожээ.





## Хууль, шүүхийн байгууллагын залуу мэргэжилтнүүдээс авсан асуулга судалгааны зарим дүн



Дэлхийн банкны  
“Хууль зүйн салбарын үйлчилгээг  
сайжруулах” төслийн  
сургалтын хөтөлбөрийн зөвлөх,  
боловсролын доктор (Ph.D)  
У.Туяа

Өнөөдрийн байдлаар эрх зүйч мэргэжил олгодог 10 гаран их, дээд сургуульд нийт 8000 гаран оюутан, өдөр, орой, эцнээ хэлбэрээр суралцаж байна<sup>1</sup>. Жил бүр бэлтгэгдэн гарч байгаа эрх зүйч мэргэжилтэй боловсон хүчний тоо харьцангуй олон боловч тэдгээрийн суралцах хугацаандаа олж авсан мэдлэг, ур чадвар нь хуульчийн мэргэжлээр ажиллахад тавих өнөөгийн шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Сүүлийн жилүүдэд ХЗДХЯ-аас олон улсын байгууллагын санхүүгийн болон техникийн туслалцаатайгаар эрх зүйн салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн бакалаврын боловсролын чанарыг дээшлүүлэх, эрх зүйн бакалаврын боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр багагүй ажил хийж байгааг улам бүр чанаржуулах, сонирхлын бүлгийн хэрэгцээ, хүлээлтийг илрүүлэхийн тулд ХЗДХЯ, Дэлхийн банкны “ХЗҮС” төсөл хамтран хууль зүйн их, дээд сургууль төгсөөд хууль, хяналтын байгууллагад 1-5 жил ажиллаж буй залуу мэргэжилтнүүдийн дунд асуулга судалгаа явуулав. Судалгаанд хууль, хяналтын есөн байгууллагын 169 албан хаагч хамруулснаас, нийслэлийн шүүхээс 65, Хан-Уул дүүргийн шүүхээс 15,

<sup>1</sup> (2011) “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганы “Салбар хуралдаан 4” хуралдааны тэмдэглэлээс.


Чингэлтэй дүүргийн шүүхээс 14, нийслэлийн прокуророос 4, Баянзүрх дүүргийн прокуророос 4, Баянгол дүүргийн прокуророос 6, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас 28 албан хаагч, мөн 27 өмгөөлөгч, 6 нотариатч байна.

Судалгаанд оролцогчдын мэдээлэл

График 1



График 2



Судалгааны дүнгээс харахад залуу мэргэжилтнүүд суралцаж буй үедээ эзэмшсэн мэргэжлийн мэдлэг, дадлагаа 64.0 хувь нь хангалттай, 35.0 хувь нь дунд зэрэг, 1.0 хувь нь хангалтгүй гэж үнэлжээ.

Хүснэгт 1

**Таны төгссөн сургууль оюутанд мэргэжлийн мэдлэг, дадлагыг ямар түвшинд эзэмшүүлсэн гэж та үнэлдэг вэ? асуултад оролцогчдын хариулсан байдал**

| №  | Байгууллага                                                            | Үнэлгээ    |            |            |
|----|------------------------------------------------------------------------|------------|------------|------------|
|    |                                                                        | Хангалттай | Дунд зэрэг | Хангалтгүй |
| 1. | Нийслэлийн Шүүх, Чингэлтэй дүүргийн шүүх                               | 66 69.0    | 29 30.0    | 1 1.0      |
| 2. | Нийслэлийн Прокурорын газар, Баянгол дүүргийн ПГ, Баянзүрх дүүргийн ПГ | 11 78.5    | 3 21.5     |            |
| 3. | Нийслэлийн Шийдвэр Гүйцэтгэх Алба                                      | 17 65.4    | 9 34.6     |            |
| 4. | Монголын өмгөөлөгчдийн Холбоо                                          | 14 52.0    | 11 41.0    | 2 7.0      |
| 5. | Нотариатчдын Танхим                                                    | 1 17.0     | 5 83.0     |            |
|    | <b>Нийт</b>                                                            | <b>109</b> | <b>57</b>  | <b>3</b>   |

Дээрх үнэлгээ нь төгссөн сургуулийнхаа сургалтын агуулгыг дөрвөн шкалаар үнэлсэн үнэлгээтэй үндсэндээ тохирч байна. Тухайлбал, сургалтын агуулгыг хэрхэн үнэлж буй тухай асуулгад судалгаанд оролцогчдын 58.5 хувь нь боломжийн түвшинд, 30.0 хувь нь дунд зэрэг, 3.5 хувь нь хангалтгүй, 8.0 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Хүснэгт 2

**Та төгссөн сургуулийнхаа сургалтын өнөөгийн агуулгыг хэрхэн үнэлдэг вэ? асуултад оролцогчдын хариулсан байдал**

| №  | Байгууллага | Үнэлгээ   |            |            |          |
|----|-------------|-----------|------------|------------|----------|
|    |             | Боломжийн | Дунд зэрэг | Хангалтгүй | Мэдэхгүй |
| 1. | Шүүх        | 56        | 25         | 4          | 7        |

|    |             |           |           |          |           |
|----|-------------|-----------|-----------|----------|-----------|
| 2. | Прокурор    | 8         | 4         |          | 1         |
| 3. | ШГА         | 14        | 8         |          | 4         |
| 4. | Өмгөөлөх    | 17        | 8         | 1        | 1         |
| 5. | Нотариат    | 1         | 4         | 1        |           |
|    | <b>Нийт</b> | <b>96</b> | <b>49</b> | <b>6</b> | <b>13</b> |

Харин эрх зүйч мэргэжил олгож буй сургалтын агуулгыг оролцогчдын 75.5-15.5 хувь зарим талаар болон бүхэлд нь өөрчилж, шинэчлэх шаардлагатай гэж үзсэн бол 9.0 хувь нь өөрчлөх шаардлагагүй гэж үзжээ.

Хуулийн байгууллагуудад ажиллаж буй залуу мэргэжилтнүүдийн үнэлгээ нь тухайн байгууллагын гүйцэтгэж буй чиг үүргээс хамааран нэлээд зөрүүтэй байгаа бөгөөд ялангуяа, шүүх, нотариатын байгууллагынхны хоорондын зөрүү харьцангуй их, харин прокурор, шүүхийн шийдвэр биелүүлэх албаны мэргэжилтнүүдийн үнэлгээ үндсэндээ давхцаж байна. III асуулт буюу сургалтын агуулгыг өөрчлөх эсэх талаар оролцогчид үндсэндээ санал нэгджээ.

Мэргэжилтнүүд төгссөн сургуулийнхаа эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, дадлагыг үнэлэхдээ:

1. мэргэжлийн үйл ажиллагаандаа алдаа гаргадаг байдал;

2. мэргэжлийн ур чадвар зэргийг шалгуур болгон өгсөн гэж үзэж болохоор байна.

Судалгаанд оролцогчдын 81.5 хувь нь мэргэжлийн алдааг заримдаа гаргадаг гэж үзсэн бол 17.0 хувь нь мэргэжилдээ алдаа гаргадаггүй байна.

### Хүснэгт 3

Судалгаанд хамрагдсан залуу мэргэжилтний гаргадаг нийтлэг алдаа

| Та болон таны нөхөд<br>мэргэжлийн ямар алдаа гол<br>төлөв гаргадаг вэ?                                                         | огт<br>үгүй | заримдаа | ховор | мэдэхгүй |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|----------|-------|----------|
| Хууль зүйн процессыг<br>хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх<br>чөлөө зөрчих тохиолдол байдаг<br>(эрүү, иргэн, захиргааны<br>процесс) | 18.9        | 51.6     | 20.1  | 9.43     |

|                                                                                                                                  |      |      |      |      |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|------|------|
| Хуулийг зөв ойлгож хэрэглэх чадвар дутсанаас эрүү, иргэн, захиргааны зөрчилтэй хэрэг, иргэний хэргийг зүйлчлэхдээ алдаа гаргадаг | 13.3 | 52.5 | 20.3 | 13.9 |
| Эрүү, иргэн, захиргааны процессын тодорхой ажиллагааг явуулахдаа алдаа гаргадаг                                                  | 15.1 | 57.9 | 17.6 | 9.43 |

Тэд мэргэжлийн алдаа гаргаж байгааг дараах шалтгаантай гэж үзэж байна. Үүнд:

- ажлын туршлага дутсан;
- хуулийг зөв хэрэглэх мэдлэг, дадлага, чадвар эзэмшээгүй;
- хуулийг нэг мөр ойлгох тайлбар учир дутагдалтай;
- эрх зүйн шинэ мэдээлэл дутмаг.

Дээрх 4 шалтгааныг оролцогчдын 30-50 хувь нь нэрлэсэн бол дараах шалтгааныг 11.5-23.0 хувь нь нэрлэсэн байна. Үүнд:

- мэдлэг боловсролоо дээшлүүлэх бололцоогүй;
- ёс зүйн төлөвшил муу;
- удирдах ажилтны хяналт, шаардлага сул.

Залуу мэргэжилтнүүдээс суралцаж байх хугацаандаа ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ур чадварыг хэр зэрэг эзэмшсэн болон хөгжүүлсэн тухай санал бодлыг цуглуулахад дараах дүр зураг харагдаж байна. Чадварыг дараах байдлаар ангилсан болно. Үүнд:

- **ерөнхий чадвар:** асуудал шийдвэрлэх, харилцах (амаар болон бичгээр) г.м
- **аналитик чадвар:** хуулийн дүн шинжилгээ, судалгаа хийх, шалтгаан баримтыг олох, илрүүлэх г.м
- **практик чадвар:** үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, маргаан шийдвэрлэх, хуулийн ажлыг зохион байгуулах, ёс зүйн хоёрдмол байдлыг илрүүлж, шийдвэрлэх г.м.

Оролцогчид өөрсдийн эзэмшсэн чадварыг ерөнхийд нь хангалттай гэж үзэж байгаа боловч 30.6 хувь нь практик чадвараа, 15.1 хувь нь мэргэжлийн аналитик чадвараа "голсон" байна.

Судалгаанд оролцогчдоос 101 нь хууль зүйн дээд боловсролыг сайжруулах талаар саналаа илэрхийлсэн бөгөөд тэдний 50 орчим хувь нь практик сургалт бөгөөд онолын мэдлэгийг практик сургалттай хослуулах нь эрх зүйн мэргэжлийн боловсролыг чанаржуулах гол гарц гэж үзсэн байна. Мөн хууль зүйн сургуулийн профессор, багш нартай холбоотойгоор:

- хууль зүйн их, дээд сургуулийн багш нарын мэдлэгийн түвшинг

өндөржүүлэх, өндөр шалгуураар авч ажиллуулах;

- онол, практикийн өндөр мэдлэгтэй доктор түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой, багшлах ур чадвартай хүнээр хичээл заагах;

- заах арга зүйг өөрчлөх;

- багш оюутан хоорондын харилцаа нигт байх зэрэг нь сургалтын чанарт ахиц гарахад нөлөөлөх хүчин зүйл гэж үзжээ.

Хууль зүйн дээд боловсролын удирдлага, зохион байгуулалттай холбоотойгоор:

- Боловсролын системийг шинэчлэх;

- Хариуцлага тооцох системийг чангаруулах, үнэлгээг чанаржуулах;

- Менежментийг сайжруулах;

- Оюутны солбилцоо, бусад орны сургуулийн туршлага судлах;

- I курсээс эхлэн байнгын дадлагад суралцуулж, ажиллуулж байх (50:50 харьцаатайгаар);

- Мэргэшүүлэх чиглэлийг баримтлах гэсэн саналууд байна.

Судалгаанаас дараах зүйлийг дүгнэх боломжтой байна. Үүнд:

- Хууль зүйн их, дээд сургууль төгсөөд 2-5 жил ажиллаж буй залуу мэргэжилтнүүдийн 40 орчим хувь нь төгссөн сургуулийнхаа сургалтын чанар, эзэмшсэн мэдлэг чадвартаа сэтгэл ханамжтай бус байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тэд сургалтын агуулга, хөтөлбөрийг ямар нэгэн байдлаар өөрчлөн боловсронгуй болгох, сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

- Шүүх, прокурор, шүүхийн шийдвэр биелүүлэх алба, өмгөөлөл, нотариат зэрэг нь бүгд хууль, хяналтын байгууллага боловч хэрэгжүүлж буй чиг үүргээсээ хамааран тэнд ажиллаж буй мэргэжилтнүүдийн мэргэжлийн боловсролын хэрэгцээ, шаардлага зарим нэгэн талаар ялгаатай байна. Иймээс эрх зүйч мэргэжлийн боловсролын сонгон мэргэших чиглэлийн хичээлийн хөтөлбөрийг өргөтгөх, ажлын байранд тавигдах шаардлагатай нийцүүлэх хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

- Мөн судалгааны баримтаас үзэхэд хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулга нь практик болон дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тодорхойлох, баримтыг үнэлэх зэрэг аналитик чадварыг хөгжүүлэхэд илүү чиглэх хэрэгтэй нь харагдаж байна.

Энэхүү судалгааны түүвэр нь үндэсний хэмжээг хамаарахгүй бөгөөд хууль зүйн сургуулийн сургалтыг чанаржуулах, улмаар эрх зүйн мэргэжлийн боловсролыг сайжруулах чиглэлээр сонирхлын нэг тал болсон “бүтээгдэхүүнийг хэрэглэгч” гол, гол байгууллагуудын төлөөлөлөөс санал цуглуулсан, тандалт судалгаа болохыг тэмдэглэж байна.

○○○○○ ○○○○○ ○○○○○



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИУД (МОНГОЛ БИЧГЭЭР)

Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жил, шинэ Үндсэн хууль (1992)-ийн 20 жилийн ойд зориулан “Монгол Улсын Үндсэн хууль” хамтын бүтээлийг монгол бичгээр хэвлэн гаргажээ.

Эл бүтээлд 1921 онд Богд хаан Ардын Засгийн газар хоёрын хооронд байгуулсан гэрээ бичиг (Тангарагын гэрээ), 1924, 1940, 1960 оны Үндсэн хууль, 1990 оны Бүгд найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль, 1992 оны Үндсэн хууль, Үндсэн хуулийн хавсралт хуулийг уг эхээр нь (тэдгээрт дараа нь оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулаагүй), 2010 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг тус тус бүрэн эхээр нь оруулжээ.

Үндсэн хуулийг дээдлэх, үндсэн хуульд ёсыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулсан энэ бүтээлийг Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Батбаяр нар эрхлэн хэвлүүлжээ.

Уг бүтээлийг Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, 1992 оны Үндсэн хуулийн төсөл боловсруулах комиссын дарга П.Очирбат, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, 1992 оны Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимид, Төрийн шагналт, гавьяат багш Ш.Чоймаа, А.Түвшинтулга, Б.Ганбаяр, Д.Баянбилэг нар хянан тохиолдуулжээ.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮГСНИЙН ЧУУЛГАН



ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төв, Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төвөөс “Монгол Улсын Үндсэн хуулийн үгсийн чуулган” хамтын бүтээлийг 2012 онд хэвлүүлжээ.


Хамтын бүтээлийн оршилд “... Онол, арга зүйн хувьд Монгол Улсын эхний гурван

Үндсэн хууль адилхан хэдий ч эрх зүйн түүх судлалд тухайн цаг үеийн нөхцөл байдал, нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд гүйцэтгэсэн үүрэг, хууль зүйн хэллэг, нэр томъёонд гаргасан өөрчлөлтийг дагнан судлахад судалгааны ач холбогдол төдий хэмжээгээр өндөр байна. Мөн нөгөө талаар судлаачдад Үндсэн хууль судлахад хөтөч болгон, тэдгээрийн цаг завьт төдий хэмжээнд хэмнэхэд ч энэхүү бүтээлийн үнэ цэнэ оршино. Дээрх гурван Үндсэн хуулийн залгамж болсон 1990 оны Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль, 1992 оны Үндсэн хууль ч Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд зарчмын өөрчлөлт гаргасныг эс нурун энэхүү бүтээлийг өргөн олонд өргөн барьж байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль, зарлигуудыг, мөн 1924 оноос хойших Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны хүрээнд туурвисан бүтээлийн ном зүйг боломжийн хэрээр гаргаж энэхүү бүтээлд багтаалаа..." хэмээжээ.

Тус бүтээлийг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид, Б.Батбаяр, А.Түвшинтулга, Д.Баянбилэг, М.Мөнхбат, Р.Мухийт, С.Ганццэг нар хянан тохиолдуулжээ.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ТОВЧООН




Академич Ж.Амарсанаа шинэ Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ой, Үндсэн хуулийн цэцийн 20 жилийн ойг тохиолдуулан "Монгол Улсын Үндсэн хуулийн товчоон" бүтээл хэвлүүлжээ.

Бүтээл нь 3 бүлэгтэй. Эхний бүлэг нь 2 хэсэгтэй бөгөөд 1911-1924 онд батлагдсан Үндсэн хуулийн шинжтэй, Үндсэн хуулийн байгуулалтад голчлон хамаарах эрх зүйн баримт бичгийг түүвэрлэн оруулсан.

Хоёрдугаар бүлэгт Үндсэн хуулиуд, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд болон шууд холбогдох зарим хуулийг сонгож оруулсан. Гуравдугаар бүлэгт Үндсэн хуулийн төслийн талаарх саналыг оруулжээ.

Уг бүтээлийг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид хянан тохиолдуулжээ.





## ЭРХ ЗҮЙН ЭХ ТОЛЬ БИЧИГ


Академич С.Нарангэрэл хууль зүйн 8000 шахам нэр томъёоны тайлбар бүхий “Эрх зүйн эх толь бичиг”-ийн нэмж засварласан гурав дахь бүтээлийг 2012 онд хэвлүүлжээ.

Нэгэн боть эрх зүйн энэхүү эх толь бичигт эрх зүйн шинжлэх ухаан, хууль зүйн практикт буй гомлох сууль нэр томъёо ба хэллэгийн тайлбарыг бичиж, нэлээдийг нь латин, англи, орос хэлнийхтэй дүйцүүлэн оноолт хийсэн.

Эл бүтээлд монголын, олон улсын ба гадаад улсуудын эрх зүйн үндсэн салбар, түүнчлэн хууль зүйн онолын ба хэрэглээний (хавсарга) судлагдахууныг (төр, эрх зүйн онол, түүх, криминологи, криминалистик, шүүх эмнэлэг) багтаасан.

Зохиогч бүтээлийнхээ оршилд “... Гурав дахь хэвлэлтэд бэлтгэх явцдаа монголын хууль зүйн товчлолыг тусад нь үйлдэж хавсаргасан бөгөөд ийнхүү тус улсын эрх зүй судлаад хууль зүйн товчлолын анхны эх үндэс тавигдаж байгаа болно. Эл толь бичгийн хоёр дахь хэвлэлтийн дараа хууль зүйн нэлээд нэр томъёо ба хэллэгийг шинээр нэмэв. Мөн зарим ухагдахууны агуулгыг улам нарийвчлан тодруулж, өмнөх дутагдал, доголдлоо засахыг оролдов...” хэмээжээ.

◇◇◇◇◇ ◇◇◇◇◇ ◇◇◇◇◇




## ХУУЛЬ ЗҮЙН АНГЛИ-МОНГОЛ ЭХ ТОЛЬ

Академич С.Нарангэрэл эрх зүйн ерөнхий ба салбарын мөн хууль зүйн хавсарга судлагдахууны 50 000 орчим англи нэр томъёо, хэллэгтэй “Хууль зүйн англи-монгол эх толь” бүтээлийг 2012 онд хэвлүүлжээ.

Их Британи, Америк, Европын холбоо, Герман, Франц, Шотландын хийгээд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн латин

хууль зүйн нэр томъёо, хэллэгээс бүрдсэн. Хууль зүй судлалын гол нэр томъёонд агуулгын товч тайлбар үйлдсэн. Англи хэлтэн улс орнуудын хууль зүйн эх сурвалж, ном зохиолын уламжлал болж тогтсон товчлол, тэдгээрийн тайлалыг үйлдэж, цаашид улмаар гүнзгийрүүлэн мэдээлэл олж авахад эл толь бичиг ашиглагчдад тус дөхөм үзүүлэх үүднээс ном зүй, интернэтээс авах мэдээллийн эх сурвалжийг үйлдсэн болно.

Уг бүтээлийг хууль зүйн доктор, МУИС-ийн хууль зүйн сургуулийн хүндэт профессор, онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Б.Алтангэрэл (Ph. D), магистр, онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ц.Сүхбаатар (LLM) нар хянан тохиолдуулжээ.




## JURISPRUDENCE-ЭРХ ЗҮЙ СУДЛАЛ: ФИЛОСОФИ, ОНОЛ

Философийн ухааны доктор, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Лүндэндорж “Jurisprudence-Эрх зүй судлал: философи, онол” бүтээл хэвлүүлжээ.

Зохиогч бүтээлийнхээ оршилд “...Эрх зүйн онол бол улс төрийн онолын нэг хэсэг юм. Эрх зүйн онолын үндэс суурь болсон улс төрийн онолыг судлахгүйгээр эрх зүйн онолыг судлах гэх нь өрөөсгөл төдийгүй зөв оных бололцоогүй гэж өдгөө үзэж байна. Энэ

учир шалтгаанаар манай сургалт, судалгаанд төдийлөн их дэлгэрээгүй улс төр, эрх зүйн зарим онолыг авч үзлээ. Мөн сургалт, судалгаанд олон жил судлагдсан уламжлалт онолуудын суурь баримтлалыг тодруулан харуулахын зэрэгцээ орчин үеийн үргэлжлэлийг нь тоймлон харуулахыг оролдлоо...” хэмээжээ.





## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хууль зүйн доктор, дэд профессор Б.Амарсанаа (LLD) “Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал” бүтээлийг 2012 онд хэвлүүлжээ.

Бүтээлд компанийн засаглал бүх компанид хамааралтай эсэх, хуулийн этгээдийн мөн чанар, компанийн төрөл, түүнийг ангилах шалгуур, компанид хяналтаа тогтоох болон хадгалах компанийн эрх зүйн механизм, эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсэн боломж, шударга эрх бүхий албан тушаалтныг хамгаалах эрх зүйн механизм, зонхилох хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн хүлээх үүрэг, ногдол ашгийн мөн чанар ба хувьцаа эзэмшигч ногдол ашгийг тогтоож болохгүй учир, хувьцаа эзэмшигч компанийн эрх ашгийг хамгаалан нэхэмжлэл гаргах боломж, Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын мөн чанар гэсэн асуудлыг хөндөж, Компанийн тухай хууль (1999) болон Компанийн тухай хууль (шинэчилсэн найруулга) (2011)-ийн харьцуулсан хүснэгтийг хавсаргажээ.

Гол утга санаа нь энэ бүтээлийн хүрээнд хөндсөн асуудал өнөөдөр Монголын эрх зүйн тогтолцоон дахь бизнесийн байгууллагын эрх зүйн зохицуулалт, компанийн засаглалын түвшинд тулгамдсан асуудал гэж зохиогчийн хувьд үзжээ. Бүтээл нь шүүгч, бизнесийн байгууллагын хуульч, ТУЗ-ийн гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, эдийн засгийг зохицуулагч төрийн байгууллагын албан хаагч, эрх зүй, менежмент, санхүүгийн мэргэжлийн судлаач, суралцагчдад зориулагджээ.

◇◇◇◇◇

◇◇◇◇◇

◇◇◇◇◇



“Хууль дээдлэх ёс” сэтгүүл нь Олон улсын стандарт бүртгэл буюу International Standart Serial Number (ISSN)-д бүртгэлтэй болов

“Хууль дээдлэх ёс” сэтгүүл нь Олон улсын стандарт бүртгэл буюу International Standart Serial Number-ийн “Парис хот дахь олон улсын төв”-д хүсэлтээ илгээснээр ISSN-ийн дугаарлалт бүхий бүртгэлтэй сэтгүүл болов.

Цуврал хэвлэлийн дутаарын олон улсын стандарт болох International Standart Serial Number (ISSN) нь 8 оронтой тоо байдаг ба сэтгүүл, сонин, цуврал, монограф гэх мэт цуврал хэвлэл бүрт олгогддог.

ISSN нь цуврал хэвлэлд олгогдож, хэвлэлийн дутаар бүрт адил дутаарлалттай байдгаараа ISBN дутаарлалтаас ялгаатай байдаг.

ISBN нь International Standart Book Number буюу Номын дутаарын олон улсын стандарт болох 10 оронтой тоонууд байдаг байна. Манай улсад ISBN дугаарыг авах боломжтой байдаг бол ISSN дугаарыг авах үндэсний хэмжээний төв хараахан ажиллаагүй байна.

◇◇◇◇◇ ◇◇◇◇◇ ◇◇◇◇◇

“Хууль дээдлэх ёс” сэтгүүл нь жилд 6, хоёр сар тутам 1 дугаар гарна.

Жилийн захиалгын үнэ 18 000 төгрөг  
Хагас жилийн захиалгын үнэ 9000 төгрөг

Захиалгын индекс

| №                          | Монгол шуудан | Улаанбаатар шуудан |
|----------------------------|---------------|--------------------|
| “Хууль дээдлэх ёс” сэтгүүл | 200279        | 2001065            |

Хууль зүйн үндэсний хүрээлэн  
байгуулагдсаны 10 жилийн ойн  
төнд дэвшуурье.

